

**ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЛААРХ
ЭРХ ЗҮЙН ШИЛДЭГ ТУРШЛАГА, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ,
ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

АГУУЛГА

НЭГ. ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ТҮҮНИЙГЭЭ ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА МЕДИА	1
1.1. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө	1
1.2. Медиа	6
1.3. Мэдээллийн эмх замбараагүй байдал	18
ХОЁР. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, СЭТГҮҮЛЧ ЭХ СУРВАЛЖАА НУУЦЛАХ, ГЭРЧИЙН МЭДҮҮЛЭГ ӨГӨХӨӨС ТАТГАЛЗАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ АСУУДАЛ	26
2.1. Монгол улсын эрх зүйн орчин	26
2.2. Харьцуулсан судалгаа	28
2.3. Дүгнэлт	40
ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ АСУУДАЛ	43
3.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний норматив суурь	43
3.2. Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны үүсэл, хөгжил	44
3.3. Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны загварууд, харьцуулсан судалгаа	52

НЭГ. ҮЗЭЛ БОДОЛТОЙ БАЙХ, ТҮҮНИЙГЭЭ ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ БА МЕДИА

Боловсруулсан: МУИС, ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхим,
Багш С.Бат-Орших (LL.M)

1.1. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө

Энэхүү хэсэгт үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний утга агуулгыг авч үзнэ.

Монгол улсын Үндсэн хууль (1992)-ийн 16 дугаар зүйлийн 16.16-д Монгол Улсын иргэн *“итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно”* гэж заасан байдаг. Үндсэн хуулийн дээрх зүйл заалт буюу *“итгэл үнэмшилтэй байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”*¹-ний утга агуулгыг дэлгэрүүлж ойлгоход хүний эрхийн олон улсын баримт бичгүүд, тухайлбал Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948), Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт (1966)-ууд чухал үүрэгтэй.² Учир нь Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг буюу *“Хүний эрх, эрх чөлөө”* хэсгийг дээрх хүний эрхийн олон улсын баримт бичгүүдийг удирдлага болгож, тэдгээрийн агуулгыг бататган буулгах чиглэлээр боловсруулсан байдаг.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал (цаашид *“ХЭТТ”* гэх)-ын 19 дүгээр зүйлд *“Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэхүү эрхэд ямар нэгэн хорио саадгүйгээр үзэл бодолтой байх эрх чөлөө болон аливаа мэдээлэл хийгээд үзэл санааг бүхий л арга замаар, түүнчлэн улсын хил хязгаарыг үл харгалзан эрж хайх, хүлээж авах болон түгээх эрх чөлөө багтана.”*³ гэж заасан байдаг.

ХЭТТ-д дээрх байдлаар тусгагдсан үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхийг Иргэний болон Улс төрийн Эрхийн тухай Олон Улсын Пакт (цаашид *“ИБУТЭТОУП”* гэх)-ын 19 дүгээр зүйлд дараах байдлаар 3 хэсэгт хувааж дэлгэрүүлж тусгасан:⁴

¹ Энэхүү судалгааны хүрээнд, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-т тусгагдсан эрхийг цаашид *“итгэл үнэмшилтэй байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх”* гэсэн нэршлээр томъёолж ашиглана.

² Энэ талаар үз., Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, (2008), 96-98 тал.

³ Англи эх: Universal Declaration of Human Rights (1948), Article 19.

“Everyone has the right to freedom of opinion and expression; this right includes freedom to hold opinions without interference and to seek, receive and impart information and ideas through any media and regardless of frontiers.”

Accessed October 27, 2024, <https://www.un.org/en/about-us/universal-declaration-of-human-rights>

⁴ Англи эх: International Covenant on Civil and Political Rights (1966), Article 19.

“1. Everyone shall have the right to hold opinions without interference.

2. Everyone shall have the right to freedom of expression; this right shall include freedom to seek, receive and impart information and ideas of all kinds, regardless of frontiers, either orally, in writing or in print, in the form of art, or through any other media of his choice.

3. The exercise of the rights provided for in paragraph 2 of this article carries with it special duties and responsibilities. It may therefore be subject to certain restrictions, but these shall only be such as are provided by law and are necessary:

“1. Хүн бүр ямар нэгэн хорио саадгүйгээр үзэл бодолтой байх эрхтэй.

2. Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй. Энэ эрхэнд бүхий л төрлийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр буюу хэвлэж, уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад хэрэгслээр (other media)-аар эрж хайх, хүлээн авах болон түгээх эрх чөлөө багтана.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан эрхийг эдлэхэд онцгой үүрэг, хариуцлага дагалдана. Тиймээс энэхүү эрхийг зарим талаар хязгаарлаж болно. Гэхдээ тэдгээр хязгаарлалт нь заавал хуулиар тогтоогдсон байх ёстой бөгөөд дараах зайлшгүй шаардлагаар хийгдсэн байх ёстой:

а/ бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх;

б/ үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах.”

ИБУТЭТОУП-ын зүйл заалтуудыг тус пактын институци болох НҮБ-ийн Хүний эрхийн хороо (The United Nations Human Rights Committee)-с албан ёсоор тайлбарладаг бөгөөд уг хорооноос сүүлд 2011 онд 19 дүгээр зүйлийн албан ёсны тайлбар болгож “Ерөнхий тайлбар (General comment) №34”⁵-г гаргасан байдаг.

Ийнхүү Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д тусгагдсан “Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”-г ХЭТТ, ИБУТЭТОУП болон НҮБ-ийн Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар №34-тэй уялдуулан авч үзвэл, тус эрхийн утга агуулгын талаар дараах зарчмын шинжтэй зүйлсийг хэлж болно:

1. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь босоо бүтцийн хувьд дотоод болон гадаад элементийг агуулдаг. Энэ нь тус эрхийг тогтоосон ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн бүтцээс тодорхой харагддаг. 19 дүгээр зүйлийн 19.1 нь тус эрхийн дотоод элемент болох “Үзэл бодолтой байх (Freedom of opinion)”-ыг зохицуулдаг бол, 19.2 нь тус эрхийн гадаад элемент болох “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх (Freedom of expression)”-г зохицуулдаг.

Дотоод элемент гэдэг нь хувь хүн нийгэм, улс төр, шинжлэх ухаан, түүх, шашин шүтлэг, ёс суртахуун зэрэг аливаа зүйлсийн талаар өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй өөрчлөхийг хэлнэ. Хувь хүний аливаа зүйлсийн талаарх “дотоод” үзэл бодол ямар ч байж болох бөгөөд үүнд ямар ч хорио саад учруулж болохгүй. Энэ элементийг Монгол улсын Үндсэн хуульд *итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө*, ХЭТТ-д *right to freedom of opinion*, ИБУТЭТОУП-д *right to hold opinions* гэсэн нэр томъёогоор тус тус илэрхийлсэн. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний энэхүү дотоод элементэд хэзээ ч, ямар ч хязгаарлалтыг тавьж болдоггүй ба энэ нь “туйлын эрх”-ийн шинжтэй юм. Тухайлбал Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Онц болон дайны

(a) For respect of the rights or reputations of others;

(b) For the protection of national security or of public order (ordre public), or of public health or morals.”

⁵ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011), accessed October 27, 2024, <https://digitallibrary.un.org/record/715606?v=pdf>

байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь ... итгэл үнэмшилтэй байх[ыг] хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.” хэмээн тусгасан байдаг.

Гадаад элемент гэдэг нь нэг талаас хувь хүн нийгэм, улс төр, шинжлэх ухаан, түүх, шашин шүтлэг, ёс суртахуун зэрэг аливаа зүйлсийн талаарх хувийн үзэл бодлоо бусдад буюу гадагш илэрхийлэхийг, нөгөө талаас бусад хүний үзэл бодол, аливаа мэдээллийг хүлээн авахыг ойлгоно. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний энэхүү гадаад элемент нь үг хэллэг, бичиг, биеийн үйлдэл зэргээр хэлбэржиж, ном, сонин, танилцуулга хуудас, хувцас зэрэг эд зүйл буюу хэрэгслээр дамжин илэрхийлэгддэг. Энэ элементийг Монгол улсын Үндсэн хуульд *үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх* эрх чөлөө, ХЭТТ болон ИБУТЭТОУП-д *right to freedom of expression* гэсэн нэр томъёогоор тус тус илэрхийлсэн. Өмнө дурдсанчлан хувь хүний дотоод үзэл бодолд ямар нэгэн хязгаарлалтыг тогтоож болохгүй бол, дотоод үзэл бодол ийнхүү гадагшаа хэлбэржин илэрхийлэгдэхэд тодорхой хязгаарлалтуудыг төрийн зүгээс тогтоож болно. Жишээлбэл, террорист, эсхүл төрлөөр устгах явдлыг сайшаадаг үзэл бодолтой хүн байж болох ч ийм “дотоод” үзэл бодолтой байсных нь төлөө түүнд төрийн зүгээс шийтгэл оногдуулж болохгүй. Гэхдээ тэрхүү үзэл бодол нь үг хэллэг, үйлдлээр нь “гадагш” хэлбэржин илэрхийлэгдсэн буюу террорист үйл ажиллагаа хийх тохиолдолд төрийн зүгээс шаардлагатай хязгаарлалт буюу шийтгэлийг түүнд оногдуулж болно.

2. Өмнөх хэсэгт “Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”-ний гадаад элемент болох “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”-г зарим тохиолдолд хязгаарлах боломжтой байдаг талаар дурдсан. Энэ хязгаарлалтын асуудлыг ИБУТЭТОУП-ын 19 дүгээр зүйлийн 19.3 хэсгээр зохицуулдаг бөгөөд холбогдох хязгаарлалт нь зөвтгөгдөхийн тулд дараах 3 шаардлагыг хангасан байх ёстой.⁶

- i. Хязгаарлалт нь (a) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, эсхүл (b) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, нийтийн эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалахын тулд буюу хууль ёсны зорилгыг хангахын тулд хийгдсэн байх ёстой.

Энэхүү хязгаарлалт нь Монгол улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т “*Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.*” гэсэн томъёоллоор тусгагдсан байдаг.

- ii. Хязгаарлалт нь хуулиар тогтоогдсон байх ёстой.

Энэхүү шаардлагын хүрээнд “хууль” гэдэгт парламентаас баталсан болон шүүхээс тогтоосон хэм хэмжээг ойлгох бөгөөд тэрхүү хууль нь энгийн хүнд ойлгогдохуйц хангалттай “тодорхой”, нийтийн зүгээс үзэж танилцахуйц “нээлттэй”, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх албан тушаалтанд “хэт задгай бүрэн эрхийг олгоогүй байх” ёстой.

Энэхүү хязгаарлалт нь Монгол улсын Үндсэн хуульд дэлгэрэнгүй байдлаар тусгагдаагүй хэдий ч, Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно.” гэсэн томъёоллоор тусгагдсан.

⁶ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011), accessed October 27, 2024, §21-36, <https://digitallibrary.un.org/record/715606?v=pdf>

- iii. Хязгаарлалт нь зайлшгүй байдал (necessity) хийгээд тэнцвэрт байдал (proportionality)-ын хатуу тестүүд (the strict tests)-д нийцсэн байх ёстой.

Зайлшгүй байдлын зарчмын хүрээнд холбогдох хязгаарлалт нь хууль ёсны зорилгыг хангахад “зайлшгүй” байх ёстой. Өөрөөр хэлбэл, холбогдох хууль ёсны зорилгод үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахгүй өөр арга замаар хүрч болохоор байвал тэрхүү хязгаарлалт нь зайлшгүй байдлын зарчимд нийцэхгүй. Аливаа хязгаарлалт зайлшгүй байдлын зарчимд нийцэж чадсан тохиолдолд, тэрхүү хязгаарлалтыг үргэлжлүүлэн тэнцвэрт байдлын зарчимд нийцсэн эсэхийг шалгах шаардлагатай.

Тэнцвэрт байдлын зарчмын хүрээнд холбогдох хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд “тохиромжтой байх (appropriate)”, зорилгодоо хүрч болохуйц арга хэмжээнүүд дундаа хүний эрхийг “хамгийн бага хязгаарласан байх”, хамгаалах гэж буй эрх ашигтай хязгаарлагдаж буй эрх ашиг “тэнцвэртэй байх” ёстой.

Энэхүү III хязгаарлалт нь Монгол улсын Үндсэн хуульд шууд байдлаар тусгагдаагүй хэдий ч, Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “[X]ууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэсэн томъёоллоор агуулгын хувьд тусгагдсан гэж ойлгогддог.⁷

3. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэвтээ бүтцийн хувьд холбогдох мэдээллийг өөрөө эрж хайх (анг. seek), эсхүл бусдаас хүлээн авах (анг. receive) замаар “олж авах”, ийнхүү олж авсан мэдээллээ бусдад “дамжуулах (анг. impart)” гэсэн үндсэн 2 үйлдлийн хүрээнд томъёолох боломжтой санагдаж байна. Зарчмын хувьд мэдээлэл олж авах үйлдлээр дамжуулж хүн өөрийн гэсэн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй өөрчлөх боломжтой болно.⁸ Ийнхүү өөрөө эрж хайх, эсхүл бусдаас хүлээн авах замаар холбогдох мэдээллийг олж авсны дараа, тухайн мэдээллийг бусдад дамжуулах замаар хүн өөрийн үзэл бодлоо бусдад илэрхийлэх боломж бүрдэнэ. Тиймээс үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хүмүүсийн мэдээлэл олж авах, тэрхүү мэдээллээ бусдад дамжуулах гэсэн 2 үйл ажиллагаа дахь мэдээллийн чөлөөтэй урсгалыг хамгаалсан эрх чөлөө хэмээн ерөнхий байдлаар ойлгож болно.⁹

4. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д “[Монгол улсын иргэн] ... үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй” гэж зааснаараа, үг хэлэх, хэвлэн нийтлэх, жагсаал, цуглаан хийх зэрэг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх түгээмэл *аргуудыг* тоочиж дурдсан байдаг. Дэлгэрүүлэн тайлбарлавал, үг хэлэх гэдэг нь үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг үг хэллэгээр хэлбэржүүлэх замаар бусдад дамжуулах арга юм. Хэвлэн нийтлэх гэдэг нь үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг бичиг, зураг, бичлэг эсхүл эдгээрийг хамтад ашиглаж

⁷ Энэ талаар дараахыг үз., О.Мөнхсайхан, “Туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл”, дотор *Хүний эрх I боть (Өгүүлэл, илтгэл, санал)*, эмх. О.Мөнхсайхан (2023), 21-40.

⁸ Түүнчлэн мэдээлэл олж авах энэ хүрээнд төрийн байгууллагын хадгалж буй мэдээлэл рүү иргэн чөлөөтэй нэвтрэх эрх [анг. right of access to information] буюу мэдэх эрх агуулгаараа багтахыг дурдах нь зүйтэй. Энэ талаар дараахыг үз., Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression (2013), accessed October 27, 2024, <https://documents.un.org/doc/undoc/gen/n13/464/76/pdf/n1346476.pdf>

⁹ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011); 松井茂記「日本国憲法」第2版（有斐閣、2002）、頁432.

хэлбэржүүлэх замаар олон нийтэд дамжуулах арга юм.¹⁰ Цуглаан гэдэг нь улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа нийтэд илэрхийлэх зорилгоор зохион байгуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ.¹¹ Өөрөөр хэлбэл цуглаан хийх гэдэг нь улс төр, нийтлэг эрх ашигтай холбогдсон асуудлаар үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг цугларах гэсэн идэвхитэй үйлдэлд суурилж хэлбэржүүлэх замаар бусдад дамжуулах арга юм. Жагсаал гэдэг нь хот суурингийн гудамж талбайгаар зохион байгуулалттайгаар жагсан явж, улс төр, нийгэм, эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон асуудлаар үзэл бодол, санал, шаардлагаа илэрхийлж байгааг хэлнэ.¹² Өөрөөр хэлбэл жагсаал хийх гэдэг нь улс төр, нийтлэг эрх ашигтай холбогдсон асуудлаар үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг жагсан явах гэсэн идэвхитэй үйлдэлд суурилж хэлбэржүүлэх замаар бусдад дамжуулах арга юм. Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь түүхэн талаасаа төрийн зүй бус дарамтыг эсэргүүцэж бүрэлдэн тогтсон байдаг бөгөөд тийм ч учраас тус эрх чөлөөнд төрийн үйл ажиллагаа, нийтлэг эрх ашигтай холбогдсон асуудлаар өөрийн үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг олон нийтэд чөлөөтэй хуваалцах, хэлэлцүүлэг өрнүүлэх, шүүмжлэл өгөх гэсэн шинж илүү хүчтэй илэрч байдаг.

Ийнхүү дүгнэвэл, Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д тусгагдсан үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө босоо бүтцийн хувьд дотоод болон гадаад элементийг агуулдаг. Дотоод элемент гэдэг нь хувь хүний нийгэм, улс төр, шинжлэх ухаан, түүх, шашин шүтлэг, ёс суртахуун зэрэг аливаа зүйлсийн талаарх хувийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй өөрчлөхийг хэлдэг. Энэхүү дотоод элементэд ямар ч тохиолдолд хязгаарлалт тавьж болохгүй.

Харин гадаад элемент гэдэг нь нэг талаас хувь хүн нийгэм, улс төр, шинжлэх ухаан, түүх, шашин шүтлэг, ёс суртахуун зэрэг аливаа зүйлсийн талаарх хувийн үзэл бодлоо бусдад буюу гадагш илэрхийлэхийг, нөгөө талаас бусад хүний үзэл бодол, аливаа мэдээллийг хүлээн авахыг ойлгоно. Энэхүү гадаад элементэд зарим тохиолдолд хязгаарлалт тавьж болно. Гэхдээ холбогдох хязгаарлалт нь зөвтгөгдөхийн тулд (i) Хязгаарлалт нь хууль ёсны зорилгыг хангахын тулд хийгдсэн байх, (ii) Хязгаарлалт нь хуулиар тогтоогдсон байх, (iii) Хязгаарлалт нь зайлшгүй байдал (necessity) болон тэнцвэрт байдал (proportionality)-ын зарчмуудад нийцсэн байх гэсэн 3 шаардлагыг хангасан байх ёстой.

Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө хэвтээ бүтцийн хувьд холбогдох мэдээллийг өөрөө эрж хайх, эсхүл бусдаас хүлээн авах замаар “олж авах”, ийнхүү олж авсан мэдээллээ бусдад “дамжуулах” гэсэн үндсэн 2 үйлдлийн хүрээнд томъёолох боломжтой. Энэ тохиолдолд энэхүү эрх чөлөө нь хүмүүсийн мэдээлэл олж авах, тэрхүү мэдээллээ бусдад дамжуулах гэсэн 2 үйл ажиллагаа дахь мэдээллийн чөлөөтэй урсгалыг хамгаалсан эрх чөлөө хэмээн ойлгогдоно.

¹⁰ “Хэвлэх” гэдгийг монгол хэлний тайлбар тольд “1. Ном бичиг, зураг зэргийг тугалган хэвээр дармаллах”, “Нийтлэх” гэдгийг “1. Хэвлэн нийтэд тараах, 2. Нийтийн болгох.” гэж тайлбарлажээ. Сүүлд үзсэн 2024.10.31, <http://www.mongoltoli.mn/>

¹¹ Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль (1994), 3 дугаар зүйлийн 3.1.

¹² Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль (1994), 3 дугаар зүйлийн 3.2.

Түүнчлэн Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.16-д үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх нь үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний түгээмэл буюу чухал аргууд мөн болохыг тодруулж дурдсан байдаг. Энэ нь үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд төрийн үйл ажиллагаа, нийтлэг эрх ашигтай холбогдсон асуудлаар өөрийн үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг олон нийтэд чөлөөтэй хуваалцах, хэлэлцүүлэг өрнүүлэх, шүүмжлэл өгөх гэсэн шинж илүү хүчтэй илэрч байдагтай холбоотой юм.

Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх түгээмэл аргуудын нэг нь хэвлэн нийтлэх юм. Хэвлэн нийтлэх гэдэг нь үзэл бодлоо буюу холбогдох мэдээллийг олон нийтэд дамжуулахыг хэлэх бөгөөд ийнхүү дамжуулах үйл ажиллагаа нь ном, зурагт хуудас, уян эсхүл хатуу диск зэрэг холбогдох мэдээлэл /дата/-ийг өөр дээрээ хадгалах эд хэрэгсэл буюу медиа (media)-ийн тусламжтайгаар явагдсаар иржээ. Энэхүү медиа гэх нэр томьёо, түүний утга агуулгын талаар дараах хэсэгт дэлгэрүүлж авч үзье.

1.2. Медиа

1.2.1. Медиа ба хэвлэл мэдээлэл

Үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нэг үндсэн ухагдахуун бол медиа (media) юм. Энэхүү хэсэгт медиа гэх ойлголтын талаар дэлгэрэнгүй авч үзэж, манай улсын Хэвлэл мэдээллийн тухай хууль (1998)-нд тус ойлголтыг уламжлалт медиа буюу зөвхөн “масс медиа (mass media)” гэх утгаар буулгасан гэдгийг тайлбарлана.

Медиа (media) гэдэг нь “medium” гэх үгний олон тооны нэршил бөгөөд өөртөө олон утгыг агуулах хэдий ч, ерөнхийдөө floppy disk (уян диск), CD-ROM (хатуу диск), флаш зэрэг мэдээллийг хадгалах эд хэрэгслийг, эсхүл сонин, сэтгүүл, телевиз, радио зэрэг олон нийтэд мэдээлэл дамжуулах суваг гэсэн утгыг илэрхийлдэг.¹³ Өөрөөр хэлбэл, медиагийн утгыг ерөнхийд нь явцуу болон өргөн гэж 2 ангилах боломжтой. Медиа нь явцуу утгаараа ном, зурагт хуудас, уян болон хатуу диск, флаш зэрэг мэдээллийг хадгалах эд хэрэгсэл гэх агуулгыг илэрхийлэх бол өргөн утгаараа ном, сэтгүүл, телевиз, радио зэрэг мэдээлэл дамжих суваг гэх агуулгыг илэрхийлнэ.

Медиа болон түүний ангиллын талаарх интернэт дэх хайлтын илэрцээс үзвэл, энэ асуудлыг хууль зүйн шинжлэх ухаан гэхээс илүүтэй холбогдох бараа бүтээгдэхүүний мэдээллийг хэрэглэгчид хэрхэн хүргэвэл дээр вэ гэх маркетингийн үүднээс илүү судалсан зүйл анзаарагдаж байна. Тухайлбал, маркетингийн үүднээс медиаг “Масс медиа”, “Интернэт медиа”, “Борлуулалт дэмжих медиа” гэсэн ерөнхий 3 хэсэгт ангилж, цаашлаад ангилал тус бүрийг нэлээдгүй олон төрлөөр дараах байдлаар хуваажээ.¹⁴

№	Медиа ангилал	Тухайлсан төрөл
1	Масс медиа	Сонин, Сэтгүүл, Радио, Телевиз

¹³ 安保克也「ニュー・メディア社会における表現の自由」(2008), accessed October 27, 2024, https://www.jstage.jst.go.jp/article/gscs/5/1/5_12/pdf

¹⁴ MarkeTrunk вэбсайт, “Медиа гэж юу?”, үзсэн 2024.10.27, <https://www.profuture.co.jp/mk/column/31273>

2	Интернэт медиа	Цахим (Цахим) сонин, Цахим сэтгүүл, Цахим радио, Цахим телевиз, Сошиал медиа (жишээ нь Facebook, Instagram, Twitter), Бичлэгийн вэбсайт (жишээ нь Youtube), Худалдааны зориулалт бүхий вэбсайт (жишээ нь Amazon), Хайлтын зориулалт бүхий вэбсайт (жишээ нь Google) гэх мэт
3	Борлуулалт дэмжих медиа	Тээврийн хэрэгсэл (жишээ нь машин, автобус, онгоц, такси), Зурагт хуудас, Зарын самбар, Цахим самбар гэх мэт

Медиа гэх ухагдахууны ердийн утгыг ийнхүү тодруулсны дараа, медиаг үндсэн хуулийн эрх зүйн талаас буюу үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд хэрхэн авч үзэх вэ гэсэн хүнд асуулт урган гарч ирж байна. Гэхдээ үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд медиагийн өргөн утга нь ашиглагддаг болон үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хэвтээ бүтцийн хувьд мэдээлэл “олж авах” болон “дамжуулах” гэсэн үндсэн 2 үйлдлээр томъёолох боломжтой гэх 2 өгөгдлийг энд ашиглавал, тус эрх чөлөөний хүрээнд медиагийн гүйцэтгэж буй үүргийг олж харахад тийм ч хэцүү биш. Тодруулбал медиаг нэг талаас хүмүүсийн мэдээлэл олж авах, нөгөө талаас бусдад мэдээлэл дамжуулах үйл ажиллагааг нөхцөлдүүлэх чиг үүргийг гүйцэтгэдэг гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл, үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд медиа гэдгийг нэг талаас хүмүүсийг мэдээлэл олж авах боломжоор хангадаг, нөгөө талаас бусдад мэдээлэл дамжуулах боломжийг тэдэнд олгодог мэдээлэл зөөвөрлөх суваг (механизм) хэмээн тодорхойлж болно. Төрийн зүгээс медиад зүй зохисгүй хязгаарлалтыг хийхгүй бол хүмүүс хооронд мэдээлэл тэр хирээр чөлөөтэй урсах боломжтой болж, улмаар үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний нөхцөл сайжирна.

Өмнө дурдсанчлан, маркетингийн үүднээс медиаг 3 хэсэгт ангилж байсан бол энэхүү судалгааны хүрээнд тус ангиллын “масс медиа” болон “интернэт медиа”-ийн ангилал илүү ач холбогдолтой байна. “Масс медиа” гэдэг нь холбогдох мэдээллийг нэг мэдээлэл олгогчоос тодорхойгүй олон тооны мэдээлэл авагчид дамжуулдаг суваг (механизм) бөгөөд үүнд сонин, сэтгүүл, радио, телевиз багтана. Манай улсын хувьд масс медиагийн асуудлыг Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (1998)-р зохицуулж байна. Масс медиа дундаа радио болон телевиз нь өргөн нэвтрүүлэг хийх (анг. broadcasting) буюу мэдээллийг нэгэн зэрэг тодорхойгүй олон тооны мэдээлэл авагчид дамжуулах чадамжтай. Манай улсын хувьд радио болон телевизийн асуудлыг Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)-р зохицуулж байна.¹⁵

Сүүлийн үед компьютер, гар утас, таблет зэрэг техник технологийн хөгжлийг дагаад хэрэгтэй мэдээллээ хэрэгтэй үед нь олж авах боломжтой “интернэт медиа” эрчимтэй хөгжиж байна.¹⁶ Дээр дурдсан маркетингийн үүднээс авч үзсэн төрлүүдээс үзвэл, интернэт медиаг

¹⁵ Үз., Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019), сүүлд үзсэн 2024.10.27, <https://legalinfo.mn/detail/15067>

Сонирхуулахад тус хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “өргөн нэвтрүүлэг” гэж радио, телевизийн хөтөлбөр бэлтгэж, нэгтгэн харилцаа холбооны сүлжээ, төхөөрөмжөөр нэг цэгээс олон нийтэд нэгэн зэрэг хүргэхийг хэмээн тодорхойлжээ.

¹⁶ Үз., UNESCO, “Media and Information Literacy: Policy and Strategy Guidelines” (2013), accessed October 27, 2024, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000225606/PDF/225606eng.pdf.multi>

дотор нь “Уламжлалт масс медиаг цахимжуулсан медиа”, “Сошиал медиа”, “Вэбсайт медиа” гэж 3 хэсэгт ангилах боломжтой санагдаж байна. Үүн дундаа “сошиал медиа” нь нэлээд онцлог шинжийг агуулж байна. Тодруулбал сошиал медиад холбогдох мэдээллийг хүлээн авагч субъект нь пост бичих, зураг, бичлэг оруулах зэргээр өөрөө мэдээлэл дамжуулагч ч болох боломжтой байдаг.

Медиаг монгол хэлэнд *хэвлэл мэдээлэл* гэсэн нэршлээр буулгах хандлага ажиглагдаж байгаа¹⁷ боловч энэ нь тийм ч зөв санагдахгүй байна. Учир нь манай улсад *хэвлэл мэдээлэл* гэдгийг масс медиа гэж ойлгох нөхцөл бүрдсэн юм. Үүний гол шалтгаан нь манай улс 1998 онд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийг баталсан бөгөөд тус хуулийн конвенцоор хэвлэл мэдээлэл, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэгт зөвхөн уламжлалт масс медиа буюу сонин, сэтгүүл, радио, телевизийг л хамруулж ойлгосонтой холбоотой. “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулиар “хэвлэл мэдээлэл”, эсхүл “хэвлэл мэдээллийн хэрэгсэл” зэрэг нэр томъёог шууд тодорхойлоогүй боловч, тус хуулийн агуулгаас хэвлэл мэдээлэл, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэдэгт уламжлалт масс медиа буюу сонин, сэтгүүл, радио, телевизийг хамааруулсан нь тодорхой харагдана. Учир нь тус хуулиар зохицуулах гол объект нь өөрийн нийтэлж (press), нэвтрүүлж (broadcast) байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээдэг зүйл байх бөгөөд нийтлэх (press) гэх аспектаар сонин, сэтгүүлийг, нэвтрүүлэх (broadcast) гэх аспектаар радио, телевизийг илэрхийлсэн юм.¹⁸ Тиймээс хэвлэл мэдээлэл гэх ойлголтоор масс медиаг илэрхийлж, харин масс медиаг өөртөө багтаасан media гэх ойлголтыг тэр чигээр нь медиа гэж галиглан орчуулах нь зүйтэй санагдаж байна.

Манай улсын хувьд шинэ медиа (new media) буюу интернэт медиа, тухайлбал вэбсайт медиа болон сошиал медиагийн талаар тухайлж зохицуулсан зохицуулалт байхгүй. Гэвч сүүлийн үед интернэт орчин дахь харилцаа өргөжиж хэвлэл мэдээллийн байгууллагууд ч интернэт орчныг өргөнөөр ашиглах болсон тул сонин, сэтгүүл, радио телевиз зэрэг уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа явуулах талбар тэлж хууль, эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, шинээр батлах зэргээр тус харилцааг зохицуулах шаардлага үүссэн. ИБУТЭТОУП-н 19-р зүйлийн талаарх ерөнхий тайлбар №34-д “Оролцогч улсууд интернэт, гар утас зэрэг цахим мэдээлэл түгээх электрон системд тулгуурласан мэдээлэл харилцааны хөгжил нь дэлхийн түвшинд өөрчлөлт хийснийг анхаарч үзэх хэрэгтэй. Орчин үед хэвлэл мэдээллийн зөвхөн уламжлалт хэрэгсэлд найдах шаардлагагүйгээр үзэл бодлоо илэрхийлэх дэлхийн хэмжээний сүлжээ бий болсон. Иймд оролцогч улсууд нь шинэ хэвлэл мэдээллийн хараат бус байдлын хангах, хүмүүст хүртээмжтэй болгох талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг авах хэрэгтэй” гэж зөвлөсөн байдаг.

Тиймээс манай улсын хувьд шинэ медиагийн асуудлыг хэрхэн зохицуулах хэрэгтэй талаарх асуулт тулгарч байна. Дараагийн хэсгээр энэ тухай авч үзье.

¹⁷ Тухайлбал үз., Болор толь бичиг, сүүлд үзсэн 2024.10.28, <https://bolor-toli.com/result?word=media&direction=1>

¹⁸ Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль (1998), сүүлд үзсэн 2024.10.27, <https://legalinfo.mn/mn/detail/546>

1.2.2. Шинэ медиагийн асуудал

Шинэ медиагийн асуудлыг бусад улсууд зарим нэг чухал харилцаа дээр төвлөрч, түүнд зориулсан тухайлсан хууль батлах замаар зохицуулж буй хандлага харагдаж байна. Энэ хүрээнд Казакстан, Европын Холбоо, Их Британи улсуудыг туршлагыг судаллаа.

1) Казакстан

Казакстан улс 2023 оны 7 дугаар сарын 10-ний өдөр “Онлайн платформууд ба Онлайн зар сурталчилгааны тухай” хууль баталсан.¹⁹ Энэхүү хууль нь зөвхөн инфлюенсер, блогеруудыг татварт хамруулах төдийгүй тэдний хариуцлагыг нэмэгдүүлж, худал мэдээлэл тараавал торгууль төлөх үүрэг хүлээлгэхийг шаардсанаараа их онцлогтой.

Хууль батлагдахаас өмнөх хуулийн төслийн тайлбарт “Өнөө үед Казакстан улсад онлайн платформуудын үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн суурь бүрдээгүй байна, холбогдох ойлголт байхгүй, хэрэглэгчдийн харилцан үйл ажиллагаа болон онлайн платформуудын удирдлагатай харилцах салбарт хэд хэдэн дутагдлууд байгаа. Энэхүү нөхцөл нь тодорхой тогтоосон эрх зүйн хүрээнд ажилладаг мэргэжлийн сэтгүүлчид болон масс медиагийн байгууллагуудыг тийм зохицуулалт байхгүй онлайн платформуудын субъектүүдтэй өрсөлдөхөд тэнцвэргүй байдалд оруулж байна. Хуулийн төсөл нь норматив эрх зүйн суурийг сайжруулах, мөн төрийн байгууллагууд, Казакстан Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, хуулийн этгээдүүд болон онлайн платформуудын хооронд үүсэх онлайн платформууд болон онлайн зар сурталчилгааны салбарын олон нийтийн харилцааг зохицуулахад чиглэсэн” гэжээ.²⁰

Шинэ хуулийн талаар Хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Дархан Қыдырәлі өөрийн хуудас дээр бичиж, тайлбар хийсэн байна. Тэрээр "Өнөөдөр сошиал медиа нь гол мэдээллийн эх сурвалж буюу олон нийтийн болон улс төрийн чиг хандлагыг тодорхойлогч платформ болсон. 'Нийгмийн сэтгэл зүйг хэмжигч' гэж нэрлэгдсэн масс медиа салбар эрчимтэй хөгжиж байсан үед мэдээллийн технологийн нөлөөгөөр дэлхий өөрчлөгдсөн, харилцааны ландшафт ч мөн гүн гүнзгий өөрчлөгдсөн. Жишээ нь, саяхан Reuters Institute-ын нийтэлсэн 'Цахим мэдээний тайлан'-д дурдсанаар, дэлхий даяар сошиал медиа ашиглан мэдээ унших нь 30 хувиар нэмэгджээ" гэж сайд онцлон бичжээ. Сайд хэлэхдээ, "Энэхүү хууль нь Казакстан Улсад онлайн платформын үйл ажиллагааны хууль эрх зүйн үндсийг бүрдүүлж, онлайн платформ болон онлайн зар сурталчилгааны салбарт зохицуулалтын норматив үндсийг концептуаль байдлаар шинэчлэх боломжийг олгоно" гэжээ. Мөн, Европын холбоо баталсан Digital Services Act буюу Цахим үйлчилгээний тухай хуулийн тэнцүү хувилбар болсон энэхүү хууль нь дэлхийн хэмжээний нийгмийн сүлжээнүүдийн интерфэйсийг казах хэл рүү хөрвүүлэх, инфлюенсерүүдийн зар сурталчилгааг тэмдэглэх, хууль бус контентыг илүү үр дүнтэйгээр модерац хийх асуудлуудыг ч зохицуулна. Хуулийн хүрээнд сүүдэр эдийн засгийн үзэгдлийг бууруулах болон онлайн залилангаас тэмцэх шаардлагатай арга хэмжээг авах болно. Өөрөөр хэлбэл, амьдралын офлайн хариуцлага нь онлайн ертөнцөд ч үүрэг гүйцэтгэх болно. Ерөнхийдөө

¹⁹ Онлайн-платформалар және онлайн-жарнама туралы, Accessed October 27, 2024, https://adilet.zan.kz/kaz/docs/Z2300000018?fbclid=IwZXh0bgNhZW0CMTEAAAR04pv3dQIGpgAcszWSNx eF1uSXUZIVXXR4YxxhawCCZ3tUc2pUO4NkYoCo_aem_OUQ6BMWB3kD5vibMqbJTPQ

²⁰ Accessed October 27, 2024, <https://www.parlam.kz/kk/blogs/stambekov/Details/6/96511>

батлагдсан хуулиар иргэдийн эрх, эрх чөлөөг хангах онлайн платформуудтай үр ашигтай хамтын ажиллагаа болон харилцан үйл ажиллагаа явуулах боломжийг олгоно. Үүний зэрэгцээ дэлхийн алдартай нийгмийн сүлжээнүүд болон онлайн платформууд хамтын ажиллагаа байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлж, зарим нь төлөөлөгчөө томилсон байна.²¹

Хуулийн талаар парламентын депутат Айдос Сырым дараах тайлбарыг өгсөн: "Энэхүү хууль нь онлайн платформын үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ. Тодруулбал, нийгмийн сүлжээнд хэрэглэгчдийн тоо тодорхой хэмжээнээс хэтрэхэд, платформ нь дор хаяж гурван дөрвөн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Нэгдүгээрт, төрийн байгууллагуудтай хамтран Казах хэлийг хөгжүүлэх чиглэлээр хамтарч ажиллах ёстой. Тухайлбал, аль нэг нийгмийн сүлжээний контент нь орос хэлээр бичигдсэн бол испани хэл рүү, испани хэлээр бичигдсэн бол орос хэл рүү хэрхэн орчуулагддаг вэ, бидний бодлоор мөн адил казах хэл рүү орчуулагдах ёстой. Хоёрдугаарт, казах хэл дээр хууль бус контент байвал түүнийг өөрсдөө модерац хийх түвшинд хүрэх хэрэгтэй. Тиймээс тэдний байгууллагад дор хаяж казах хэл мэддэг мэргэжилтнүүд байх шаардлагатай. Гуравдугаарт, худал мэдээлэл тараахтай холбоотой заалт гэх мэт зүйлсийг гэмт хэргээс салгаж байгаа."²²

Энэ асуудалтай холбогдуулан хуульч Асхат Копбаев дараах kommentыг өгчээ: "Энэхүү хууль нь олон асуудлын шийдэл болсон. Орчин үед блогер гэдэг бүлэг бий болсон. Улс төр засаг олон жил тэдний нөлөөг анхаараагүй ч сая, сая дагагчтай эсвэл гэнэт өөрийгөө блогер гэж үзэн, утсаа бариад нийгмийн сүлжээнд мэдээллээ хуваалцахыг яарсан хүмүүс хариуцлагатай байх ёстой. Үгүй бол хүмүүс төөрөлдөж дууслаа. Олон хүн блогеруудын дутуу дулимаг мэдээллийн улмаас улаан оймс шүтэж, эсвэл болохгүй зүйлд итгэж төөрөлдсөн. Ийм худал мэдээлэл түгээгч блогеруудыг хариуцлагад татах шийтгэлийг хэрэглэх нь зөв. Үгүй бол сүүлийн жилүүдэд худал мэдээлэл хэт ихэссэн. Ялангуяа хэдэн жилийн өмнө цар тахлын үеэр худал мэдээлэл нь ийнхүү айж тэвдэж байсан хүмүүсийн байдалд улам хүндрэл учруулсан. "Хүмүүсийг чипжүүлнэ," "Вирусыг нисэх онгоцоор агаарт цацдаг," "Вакцин хийлгэсэн хүмүүсийн дотор эрхтэн хэдэн жилийн дараа ялзарна," "Ковидод сарьсан багваахайн шөл эм болно" гэх мэт мэдээллүүд олон хүнийг төөрөгдүүлсэн."²³

Хуулийн талаар депутат Анас Баққожаев дараах kommentыг өгсөн байна: "Өнөөдөр интернетэд сурталчилгаа хийж, ашиг олж буй хүмүүсийн тоо өсөж байна. Өнгөрсөн онд худал мэдээлэл тараахтай холбоотой 5,545 хэрэг илэрсэн бөгөөд үүнээс 278 нь сөрөг агуулгатай, 5,267 нь залилангийн хэргүүд, 2,846 нь санхүүгийн пирамидыг сурталчилсан тохиолдлууд байжээ. Манай улсын бүтэн байдал, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж, хүний нэр хүнд, ёс зүйг 'шархлуулж' буй үзэгдэл газар авч байна. Түүнчлэн, Казахстан улсад үйл ажиллагаа явуулж буй онлайн платформууд Казах хэлний шаардлагыг бүрэн биелүүлж чадахгүй байна гэж хэлж болно. Олон нийтийн сүлжээнүүдийн интерфэйс болон контент автомат орчуулгаар Казах хэлийг ашиглахгүй байна. Энэ асуудалд эдийн засгийн талбарын асуудлыг мөн орхих ёсгүй. Хууль нь худал мэдээлэл тараах, байршуулалтад хориг тавих

²¹ Accessed October 27, 2024, <https://dauletten.kz/articles/onlayin-platformalar-zhane-onlayin-zharnama-turaly-zan-qabyldandy>

²² Accessed October 27, 2024, <https://inbusiness.kz/kz/last/onlajn-platformalar-turaly-zan-zhobasynyn-ishine-inflyuenser-ugymy-engiziledi>

²³ "Заң газеті" №55 (3586), Accessed October 27, 2024, <https://zanmedia.kz/wp-content/uploads/2023/08/Zan-%E2%84%9655-1-8.pdf>

зорилготой. Мөн онлайн платформуудын интерфейс болон модерацид улсын хэл заавал интеграцлагдах болно. Энэ нь хамгийн түрүүнд нийгмийн сүлжээний алгоритмд хууль зөрчсөн контентыг хянах боломжийг олгоно.”²⁴

Судлаач Х.Айгерим хуулийн тухай “Европын Холбооны Digital Services Act хэмээх хууль тогтоомжид суурилсан энэхүү баримт бичгийн зорилгын нэг нь санхүүгийн пирамид²⁵ болон бусад интернет залилангаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлэх явдал юм.” гэж тодорхойлжээ.²⁶

Тус хууль нь Казахстан Улсын нутаг дэвсгэрт ажилладаг онлайн платформуудтай холбоотой нийгмийн харилцаа, түүнчлэн Казахстан Улсын нутаг дэвсгэрт онлайн зар сурталчилгаа бүтээх, байршуулах, түгээх, хадгалах үйл явцад үүсэх нийгмийн харилцааг зохицуулна. Хуулийн зорилго нь онлайн платформын үйл ажиллагаа болон онлайн зар сурталчилгаа бүтээх, байршуулах, түгээх, хадгалах, хууль зөрчсөн агуулгаас сэргийлэх, түүнийг зогсоох хууль эрх зүйн үндсийг тодорхойлох явдал юм. Зорилт нь:

- онлайн платформын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
- Казахстан улсын мэдээллийн орчны аюулгүй байдлыг хангах;
- хууль зөрчсөн агуулгыг үүсгэхээс сэргийлэх;
- онлайн платформ дээр хүүхдийг эрүүл мэнд, хөгжилд нь хор хөнөөл учруулж болзошгүй мэдээллээс хамгаалах.

Энэхүү хуулиар онлайн платформын нийтлэг хэрэглэгч буюу энгийн хэрэглэгчдийг инфлюенсер (блогер) буюу онлайн платформыг бизнесийн зорилгоор ашигладаг хүнээс ялгаж зохицуулсан. Хуулийн 1-р зүйлийн 1.6 дугаар зүйлд зааснаар “инфлюенсер (блогер)” гэж цахим платформд хувь хүний тодорхой бус бүлэгт зориулан мэдээллийг бизнесийн зорилгоор нийтэлдэг онлайн платформын хэрэглэгчийг хэлнэ хэмээн тодорхойлжээ. Энд онцлох зүйл нь хуулийн үндсэн зорилго нь онлайн платформ дээр өөрийн санааг илэрхийлэх эрх чөлөөг хүмүүст олгох явдал юм. Мөн иргэдийн онлайн орон зай дахь эрхүүдийг хангах. Харин инфлюенсер буюу блогер нь өөрийн ажлыг бизнесийн чиглэлээр ашигладаг учир нэмэлт үүрэг хариуцлага хүлээх ёстой. “Онлайн платформууд болон онлайн зар сурталчилгааны тухай” хуулийн дагуу нэг чухал шинэ шаардлага бол блогерууд бизнес эрхлэгч хэмээн бүртгүүлэх шаардлагатай ба өөрсдийн зар сурталчилгаануудад тэмдэг тавих шаардлагатай.

Цахим платформууд болон цахим зар сурталчилгаа тухай хуулийн 1-р зүйлийн 1.10 дугаар зүйлд зааснаар “цахим платформ” гэж санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болон цахим худалдаанд зориулагдсан интернет ресурс (интернет дээр ажилладаг программ хангамж) шуурхай мэдээ солилцооны үйлчилгээ, онлайн платформын хэрэглэгчийн өөрийн нээсэн өгөгдөл, онлайн платформ дээрх контентыг олж авах, үүсгэх, байршуулж, тараах,

²⁴ Accessed October 27, 2024, <https://almaty.tv/kz/news/obschestvo/1953-onlayn-platformalar-dgane-onlayn-dgarnama-turaly-zan-bloggerler-dgazalanuy-mumkin>

²⁵ Санхүүгийн пирамид гэдэг нь шинэ гишүүдийн оруулсан мөнгөний тусламжтайгаар өмнөх гишүүдийн хувийг өгдөг луйврын систем юм.

²⁶ Accessed October 27, 2024, <https://khabar.kz/kk/news/kogam/item/151258-onlajn-platformalar-zhane-onlajn-zharnamalar-turaly-zan-kushine-enedi>

хадгалахад зориулагдсан интернет ресурс, интернет дээр ажилладаг программ хангамж, шуурхай мэдээ солилцооны үйлчилгээг хэлнэ гэж тодорхойлжээ.

Хуулийн үр дүнгээс үзвэл Казахстан улсад 2024 оны нэгдүгээр сараас долдугаар сар хүртэл "Худал мэдээлэл тараах" зөрчилтэй холбоотой 77 зөрчил бүртгэгдсэнээс 67 нь энгийн интернет хэрэглэгчдэд, 5 нь блогеруудтай холбоотой байжээ. Худал мэдээлэл түгээсэн блогеруудын торгуулийн нийт хэмжээ 166,000 тэнгэ²⁷ болжээ. Хамгийн алдартай тохиолдлын нэг нь Костанайн блогер автомашины цонхыг хараар будах тухай худал мэдээлэл тараасны төлөө 77,000 тэнгэ-н торгууль хүлээсэн явдал байв.²⁸

Үүнээс үзвэл энэхүү хууль нь зөвхөн блогерууд буюу инфлюенсерүүд төдийгүй, нийт интернет хэрэглэгчдийн эрхийг тодорхойлох, хууль зөрчих тохиолдолд хариуцлагыг хүлээлгэх зорилготой. Нийгмийн сүлжээнд хуурамч мэдээлэл тархах нь олон нийтийн санаа бодол болон иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлөх боломжтой тул энэхүү хууль нь нийгмийн мэдээллийн аюулгүй байдал, дэг журмыг хангахад чиглэгджээ.

2) Европын холбоо

2022 онд Европын Холбооноос Цахим үйлчилгээний тухай хууль (Digital Services Act)²⁹ -г баталсан бөгөөд энэ нь хууль бус контент, ил тод зар сурталчилгаа, худал мэдээллийг зохицуулах зорилготой. Цахим үйлчилгээний тухай хууль нь 2000 оны Цахим худалдааны удирдамж (Electronic Commerce Directive)-ийг шинэчилсэн хэлбэр бөгөөд Цахим зах зээлийн тухай хууль (Digital Markets Act)³⁰ -тай хамтаар батлагдсан. Цахим үйлчилгээний тухай хууль болон Цахим зах зээлийн тухай хууль нь ийнхүү хамтдаа хэрэглэгчдийн үндсэн эрх хамгаалагдсан илүү аюулгүй Цахим орчин хийгээд цахим бизнесийн шударгаар өрсөлдөх орчныг бүрдүүлэх зорилготойгоор батлагджээ.³¹

Цахим үйлчилгээний тухай хууль нь хэрэглэгчдийн эрхүүдийг онлайн орчинд хамгаалах зорилгоор тодорхой дүрмийг тогтоосон. Цахим контент үзүүлэгчдийг "Intermediary Services", "Hosting Services", "Online Platforms", "Very Large Online Platforms (VLOPs) and Very Large Online Search Engines (VLOSEs)" үзүүлэгч гэсэн 4 бүлэгт хувааж, тус бүрийн хүлээх үүргүүдийг тусгажээ. Хэрэглэгчид, платформууд, болон олон нийтийн байгууллагын үүргийг Европын үнэт зүйлсийн дагуу дахин тэнцвэржүүлж, иргэдийг төвд тавих зарчмыг баримталсан байна. Нэг зах зээлд үйлчилгээ үзүүлж буй бүх онлайн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, тэдгээр нь ЕХ-нд байгуулагдсан эсвэл гадна байгаа эсэхээс үл хамааран, энэхүү шинэ дүрмүүдийг дагаж мөрдөх ёстой.³²

Цахим үйлчилгээний тухай хууль нь хууль бус агуулга, бараа, үйлчилгээтэй тэмцэхийн тулд цахим үйлчилгээний хэмжээ, нөлөөнөөс хамааран дараах шинэ, нэгдсэн үүрэг хариуцлагуудыг тогтоожээ. Үүнд:

²⁷ Тэнгэ: Казакстаны мөнгөн тэмдэгтийн нэр. 1 тэнгэ ойролцоогоор 7 төгрөгтэй тэнцэнэ.

²⁸ <https://arasha.kz/alem-jane-zan/qyqyqtyq-alandagy-qogam/qazaqstandagy-onlajn-platformalar-turaly-zannyn-algashqy-natizheler/>

²⁹ <https://eur-lex.europa.eu/eli/reg/2022/2065/oj>

³⁰ <https://eur-lex.europa.eu/eli/reg/2022/1925/oj>

³¹ <https://digital-strategy.ec.europa.eu/en/policies/digital-services-act-package>

³² Цахим үйлчилгээний тухай хуулийн талаарх ерөнхий танилцуулгыг дараах холбоосоор үзнэ үү: <https://www.cliffordchance.com/content/dam/cliffordchance/briefings/2022/12/the-digital-services-act-what-is-it-and-what-impact-will-it-have-updated-december-2022.pdf>

- Хууль бус контенттой тэмцэх - Хэрэглэгчдэд хууль бус контентыг мэдээлэх боломж олгох, платформуудыг “итгэмжлэгдсэн байгууллагууд”-тай хамтран ажиллах замаар хууль бус контентыг илрүүлж цахим орчноос устгах.
- Цахим зах зээл дээрх бизнес эрхлэгчдийн мөрдөх шинэ дүрэм - Хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлж, залилагчдыг илрүүлэхэд хялбар болгохын тулд бизнес эрхлэгчид мөрдөх журам нэвтрүүлж, цахим зах зээлүүдийг бүтээгдэхүүн, үйлчилгээний нийцлийг санамсаргүй шалгалтаар баталгаажуулахыг үүрэг болгосноор хууль бус бараа, үйлчилгээ борлуулж буй этгээдүүд хариуцлага тооцуулна.
- Хэрэглэгчдийн эрхийг хангах - Платформуудаас контент нь хязгаарлагдсан эсвэл устгагдсан үед хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллийг өгөх замаар шийдвэрийг эсэргүүцэх, гомдол гаргах боломж олгосон.
- Платформуудын ил тод байдлыг нэмэгдүүлэх: Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээний нөхцөл, агуулга санал болгох алгоритмуудын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөх үүрэгтэй болгов.
- Хүүхдийг хамгаалах үүрэг: ЕХ-ны аливаа платформ дээр хүүхдүүдийг хамгаалахад чиглэсэн шинэ үүрэг хүлээлгэв.
- Томоохон платформууд болон хайлтын системүүдийн үүрэг: Хуурамч мэдээлэл, сонгуулийн хөндлөнгөөс оролцоо, кибер хүчирхийлэл, хүүхдэд хохирол учруулах зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэлд суурилсан үйл ажиллагаа явуулах үүрэг ногдуулсан.
- Онцгой байдлын хариу арга хэмжээний механизм: Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул тулгарсан тохиолдолд, тухайлбал цар тахал, дайн гэх мэт нөхцөл байдалд хэрэгжүүлэх шинэ арга хэмжээг нэвтрүүлсэн.
- Хүүхдийн болон тусгай өгөгдлүүдэд суурилсан чиглэсэн зар сурталчилгааг хориглох: Хүүхдийн эсвэл үндэстэн угсаа, улс төрийн үзэл бодол, бэлгийн чиг баримжаа зэрэг хувийн өгөгдлүүдэд үндэслэн чиглэсэн зар сурталчилгаа хийхийг хориглов.
- Зар сурталчилгааны ил тод байдлыг нэмэгдүүлэх: Цахим платформууд дээрх зар сурталчилгаа, нөлөөлөгчдийн арилжааны харилцааны ил тод байдлыг сайжруулсан.
- “Харанхуй загваруудыг” хориглох: Хэрэглэгчдийг хүсээгүй сонголт хийхэд хүргэх интерфэйсийн заль мэхийг хориглосон.
- Судалгааны зорилгоор өгөгдөлд нэвтрэх боломж олгох: Платформын үйл ажиллагааг судлах, цахим эрсдэл хэрхэн хөгжиж байгааг хянахын тулд судлаачдад мэдээлэлд нэвтрэх боломжийг олгов.
- Хяналтын шинэ бүтэц: ЕХ-ны нийт хүн амын 10%-аас дээш хэрэглэгчтэй платформ, хайлтын системүүдийг Комисс шууд хариуцаж, бусад платформ, хайлтын системийг байрладаг гишүүн орны зохицуулалтын байгууллагууд хянана. ЕХ-ны хэмжээнд гишүүн орны зохицуулагч байгууллагууд болон Комиссийн хамтын ажиллагааны механизм бүрдэж байна.
- Завсрын үйлчилгээ үзүүлэгчдийн хариуцлагын дүрэм: Хамтын хяналтыг хориглох Европын хэмжээнд нэгдсэн хариуцлагын дүрэм шинэчлэгдсэн.

Цахим үйлчилгээний тухай хуулийн дүрмүүд нь хууль бус контентыг илрүүлэх, устгах, мөн томоохон онлайн платформууд болон хайлтын системүүдийн эрсдэлийн үнэлгээний шинэ тогтолцоог нэвтрүүлэх ЕУ хэмжээнд мөрдөгдөх зохицуулалтуудыг тогтоодог. Хууль бус

контент гэж юу болохыг ЕХ эсвэл үндэсний хэмжээнд бусад хуулиудад тодорхойлсон байдаг. Жишээлбэл, ЕХ-ийн түвшинд терроризмтой холбоотой агуулга, хүүхдийн бэлгийн мөлжлөгийн материалыг эсвэл хууль бус үзэн ядалтыг тодорхойлсон. Хэрэв контент нь зөвхөн тодорхой гишүүн улсад хууль бусд тооцогдвол, ерөнхий дүрмийн дагуу тухайн улсад л устгагдах ёстой.³³

Харин цахим зах зээлийн тухай хуулиар хэрэглэгч болон бизнес үзүүлэгч хоёрыг хооронд нь холбодог Amazon, Google, Facebook, Apple зэрэг том онлайн флатформуудыг “Хаалгач (Gatekeeper)” гэх ойлголтод хамруулж, тэднийг шударгаар өрсөлдөх талаарх зохицуулалтыг оруулсан. Өөрөөр хэлбэл “хаалгач” нарын юу хийж болох, юу хийж болохгүйг тус хуулиар зохицуулжээ.³⁴

3) Их Британи

2023 онд батлагдсан Онлайн аюулгүй байдлын тухай хууль (Online Safety Bill)³⁵-аар Нэгдсэн Вант улсын иргэдийн интернэт дэх үйлчилгээний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шинэ зохицуулалтыг бий болгосон. Уг хууль нь сошиал медиагийн компаниуд болон үйлчилгээ үзүүлэгчдийн үүргийг тодорхойлж, тэднийг хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах талд өөрсдийн платформ дээр илүү хариуцлагатай болгох зорилготой. Энэхүү хуулийн нэг онцлог зохицуулалт нь хүүхдүүдийг хамгаалахад чиглэгдсэн бөгөөд энэ нь Их Британид хүүхдүүдийн онлайн орчинд хамгийн аюулгүй газрыг бий болгоно. Платформууд нь хүүхдийг хортой болон насанд тохиромжгүй контентэд хандахаас сэргийлэхийг шаарддаг бөгөөд эцэг эх, хүүхдүүдэд онлайн асуудал үүссэн үед түүнийг тайлагнах тодорхой, хүртээмжтэй арга замыг хангах үүрэгтэй.

Энэхүү хуулийн нь цахим орчинд үйлчилгээ үзүүлэгч компаниуд буюу хэрэглэгчдэд контент байршуулж, харилцан үйлчлэх боломж олгодог үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарна. Үүнд олон төрлийн вэбсайтууд, аппликейшнүүд болон бусад үйлчилгээ, тухайлбал сошиал медиагийн үйлчилгээ, видео хуваалцах платформууд, онлайн форумууд, танилцах үйлчилгээ болон онлайн шууд мессеж илгээх үйлчилгээ орно. Энэхүү хууль нь цахим орчинд үйлчилгээ үзүүлэгч компаниуд буюу контент хийх, харилцах үйлчилгээ үзүүлдэг этгээдүүд Их Британид байхаас үл хамааран зохицуулана. Үүнд, хэрвээ үйлчилгээ нь Их Британид олон хэрэглэгчтэй, Их Британи нь зорилтот зах зээл бол эсвэл Их Британиас хэрэглэгчид хандах боломжтой, мөн тэдгээр хэрэглэгчдэд чухал хохирол учруулах эрсдэлтэй бол хамаарах болно.

Энэхүү хуулиар батлагдсан гэмт хэргийн төрлүүд нь 2024 оны 1-р сарын 31-нд хүчин төгөлдөр болсон. Эдгээр гэмт хэргийн хүрээнд дараах үйлдлүүд орно:

- Өөртөө болон бусдад хор хөнөөл учруулахыг өдөөх эсвэл туслах
- Киберфлэшинг
- Бодит хохирол учруулах зорилготой худал мэдээлэл илгээх
- Сүрдүүлэх

³³ European Commission, “Questions and answers on the Digital Services Act”, Accessed October 27, 2024, https://ec.europa.eu/commission/presscorner/detail/en/qanda_20_2348

³⁴ Цахим зах зээлийн тухай хуулийн талаарх ерөнхий танилцуулгаг дараах холбоосоор үзнэ үү: <https://www.herbertsmithfreehills.com/notes/crt/2024-03/digital-markets-act-overview>

³⁵ <https://www.legislation.gov.uk/ukpga/2023/50/enacted>

- Дүрсийн эрхийг нь зөрчих

Платформууд хэрэглэгчдийг хамгаалах ёстой хууль бус контент болон үйл ажиллагааны төрлүүдийг энэхүү хуулиар тодорхойлсон бөгөөд үүнд дараах контентууд орно: Хүүхдийн бэлгийн хүчирхийлэл, Хяналт тавих эсвэл хүчээр шаардах зан үйл, Экстрим хүчирхийлэл, Бэлгийн порнографи, Луйвар, Арьс өнгөөр эсвэл шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, Хүчирхийлэлд өдөөх, Хууль бус цагаачлал, Өөртөө болон бусдад хор хөнөөл учруулахыг сурталчлах эсвэл дэмжих, Дүрсийн эрх зөрчих, Хууль бус мансууруулах бодис эсвэл зэвсэг борлуулах, Бэлгийн мөлжлөг, Терроризм.

Хүүхдүүдийг Primary Priority Content-ээс сэргийлэх ёстой бөгөөд харин Priority Content-д зөвхөн насанд хүрэгчэд хандах боломжийг олгох шаардлагатай. Эдгээр ангилалд орсон контентууд дараах байдалтай байна:

А. Primary Priority Content: Порнографи, Өөртөө хор хөнөөл учруулахыг өдөөх, сурталчлах эсвэл зааварчилгаа өгөх контент (Өөртөө хор хөнөөл учруулах, Хоолны эмгэг)

Б. Priority Content: Дээрэлхэлт, Хор хөнөөлтэй эсвэл үзэн ядах контент, Ноцтой хүчирхийлэл эсвэл бэртэл гэмтэл дүрсэлсэн эсвэл өдөөсөн контент, Аюултай болон эрсдэлтэй сорилтууд болон төсөл дэмжих контент, Хортой бодисыг идэх, уух, амьсгалах эсвэл хүрэхийг өдөөх контент.

Ofcom (The Office of Communications) буюу Мэдээлэл харилцааны газар нь Онлайн аюулгүй байдлын хараат бус зохицуулагч болж байна. Энэ нь үйлчилгээ эрхлэгчид аюулгүй байдлын үүргээ биелүүлэхийн тулд авах боломжтой арга хэмжээнүүдийг практикийн код зааж өгнө. Хуулийн үйлчлэх хүрээ нь хайлтын үйлчилгээ, хэрэглэгчдэд онлайнд агуулга байршуулж, харилцан үйлчлэх боломж олгодог үйлчилгээнд хамаарна. Үүнд сошиал медиа үйлчилгээ, хэрэглэгчдийн хадгалсан файл болон хуваалцах сайтууд, видео хуваалцах платформууд, онлайн форумууд, танилцах үйлчилгээ, онлайн шуурхай мессежийн үйлчилгээ зэрэг олон төрлийн вэбсайт, апп болон бусад үйлчилгээ орно.³⁶

Ийнхүү шинэ медиагийн талаарх зарим улсын туршлагаас үзвэл, онлайн платформ, цахим орчинд холбоотой хууль баталсан дараах нийтлэг шалтгаанууд харагдаж байна. Тодруулбал, Хүүхдийн эрхийг цахим орчинд хамгаалах, хууль бус контент, гэмт хэрэг зэргээс хамгаалах, Цахим орчинд худал мэдээлэл тараахыг хориглох (үүнд Covid-19 багагүй нөлөө үзүүлсэн байна. Гэвч ямар мэдээлллийг худал мэдээлэл гэж тооцох нь тийм ч амар асуудал биш юм), Санхүүгийн пирамид, залилах, мөнгө угаах зэрэг эдийн засгийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх зэрэг асуудлууд нь тухайлсан хууль батлах гол шалтгаан болжээ.

1.2.3. Инфлюнсерийн асуудал

Сошиал медиа хөгжихийн хэрээр түүний голлох тоглогч болох инфлюнсерийн харилцааг хэрхэн зохицуулах хэрэгтэй талаар асуудал тулгарч байна.

³⁶ Онлайн аюулгүй байдлын тухай хуулийн талаарх ерөнхий танилцуулгыг дараах холбоосоор үзнэ үү, Accessed October 28, 2024, <https://www.gov.uk/government/publications/online-safety-act-explainer/online-safety-act-explainer>

Сошиал медиа инфлюнсер гэдэг нь сошиал медиа платформ дээр өөрийн нөлөөллийг тодорхой хэмжээгээр бий болгосон хүн бөгөөд өөрсдийн бүтээсэн контентыг үздэг хэрэглэгчдийн бүлэгтэй байдаг. Инфлюнсер нь контент бүтээгч, сэтгүүлч, зурагчин, фитнес дасгалжуулагч гэх мэт олон төрлийн мэргэжилтэй хүмүүс байж болно. Инфлюнсерүүд өөрийн контентыг байршуулж болох Фейсбүүк, Инстаграм, Твиттер, Ютүб гэх мэт олон платформтой байж болдог.

Доор дурдсанчлан бусад улсууд сошиал медиагийн инфлюнсерүүдийн харилцааг зохицуулахдаа тухайлсан хууль гаргалгүйгээр тухайн инфлюнсерийн оролцож буй харилцаа нь ямар харилцаа вэ гэдгээс хамаарч холбогдох хуулийн ерөнхий зохицуулалтыг баримталж байна. Инфлюнсерүүдийн харилцааг зохицуулахдаа тэдгээрийн зар сурталчилгааны харилцаа, үүнтэй холбогдуулж холбогдох спонсороо мэдэгдэх хийгээд орлогын татварын асуудал дээр төвлөрч байна.

	Канад	АНУ
Ерөнхий тухайлсан зохицуулалт	Тухайлсан хууль байхгүй бөгөөд инфлюнсер, сурталчилгаа хийж буй хүмүүсийн оролцож буй харилцаа нь ямар харилцаа вэ гэдгээс хамаарч тэр харилцааг зохицуулсан хуулийг баримтална. ³⁷	Тухайлсан хууль байхгүй бөгөөд инфлюнсер, сурталчилгаа хийж буй хүмүүсийн оролцож буй харилцаа нь ямар харилцаа вэ гэдгээс хамаарч тэр харилцааг зохицуулсан хуулийг баримтална. Инфлюнсерүүдийн commercial буюу ашгийн шинжтэй харилцааг түлхүү зохицуулж байна.

³⁷ Accessed October 28, 2024, <https://laws-lois.justice.gc.ca/PDF/E-2.01.pdf>

Инфлюнсер ба зар сурталчилгаа	Инфлюнсерүүдийн маркетинг, сурталчилгаатай холбоотой харилцааг “Өрсөлдөөний тухай хууль” буюу “Competition Act”-аар голчлон зохицуулж байна. Өрсөлдөөний тухай хуулийн хяналтыг Competition Bureau Canada буюу Канадад өрсөлдөөнийг хамгаалж, дэмжих зорилгоор ажилладаг бие даасан хууль сахиулах байгуулах хэрэгжүүлнэ. Тиймээс инфлюнсер хүмүүсийн зар сурталчилгаатай холбоотой харилцааг дээрх байгууллагаас хянадаг.	Инфлюнсерүүдийн зар сурталчилгаатай холбоотой харилцааг Federal Trade Commission act -р зохицуулж байна. 2019 онд FTC-оос “101 for Social Media Influencers” гэх удирдамжийг гаргасан.³⁸ Түүнчлэн тодорхой төрлийн харилцаанд инфлюнсерүүд сурталчилгаа хийхдээ тэр төрлийн харилцааг зохицуулсан хууль журмыг зөрчсөн гэж үзвэл мөн хариуцлага хүлээж байгаа юм. Үүнийг тухайн төрлийн харилцааг хариуцаж, зохицуулдаг комисс шалгаж, шийдвэрлэдэг. Жишээлбэл: Kim Kardashian 2021 онд криптог өөрийн инстаграмм дээр сурталчилсан үйлдэл нь 1933 оны Үнэт цаасны тухай Хуулийн 17(b) заалт “хэрэв та үнэт цаасыг сурталчлах зорилгоор төлбөр авсан бол, уг төлбөрийн байдал, эх үүсвэр болон хэмжээг ил тод мэдээлэх ёстой” гэх заалтыг зөрчсөн холбоотой Улсын үнэт цаасны комисс түүнд хэрэг үүсгэн 1 сая доллараар торгосон байдаг. Энэ заалттай мөн холбоотойгоор Jake Paul, Soulja Boy, Lindsay Lohan, болон Ne-Yo гэх олны танил хүмүүсийг ч бас төлбөрөө ил болгож сурталчилгаа хийгээгүй, олныг төөрөгдүүлсэн хэмээн торгосон байдаг.
Инфлюнсер ба улс төр	Сонгуультай холбоотой харилцааг Canada elections act 325 хэсгээр зохицуулдаг.	Сонгуультай холбоотой асуудлыг Federal Election commission act болон FEC-ын зөвлөмжөөр зохицуулж байна.
Инфлюнсер ба татвар	Канадын оршин суугч нөлөөлөгчид Канад болон гадаад улсаас олсон бүх орлогыг (мөнгөн болон мөнгөн бус) тайлагнах үүрэгтэй. ³⁹	Муж тус бүр өөрсдийн гэсэн татварын хуультай бөгөөд тухайн хуулиараа хэдэн хувийн татвар хэрхэн төлөхийг зохицуулна. Ижил тал: инфлюнсер хүмүүс аль ч мужид татвар төлнө. Инфлюнсер хүмүүсийн татварын ангилал нь self- employed гэх ангилалд багтана. Мөн бэлэг авснаа мэдүүлэх ба бэлэг өгөгч нь тухайн бэлгийн татварыг төлсөн байх ёстой. ⁴⁰

Зарим улсын жишгээс харвал инфлюнсер хүмүүсийг зохицуулсан тухайлсан хууль байхгүй ч тэднийг огт зохицуулалтгүй орхилгүйгээр салбар хуулиудын зарим зохицуулалтыг тэдэнд хамааруулах, эсхүл холбогдох хуулийн үйлчлэлийг бүхэлд нь инфлюнсерүүдэд ч мөн хамаарна гэх байдлаар зохицуулж байна.

³⁸ Accessed October 28, 2024, https://www.ftc.gov/system/files/documents/plain-language/1001a-influencer-guide-508_1.pdf

³⁹ Accessed October 28, 2024, <https://www.canada.ca/en/revenue-agency/programs/about-canada-revenue-agency-cra/compliance/platform-economy/social-media-influencers.html#income>

⁴⁰ Accessed October 28, 2024, <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/frequently-asked-questions-on-gift-taxes>

1.3. Мэдээллийн эмх замбараагүй байдал

Хуурамч мэдээлэл (disinformation), алдаатай мэдээлэл (misinformation), буруу сэдэлтэй мэдээлэл (malinformation) дэлхий даяарх мэдээллийн орон зайг бохирдуулж байгаа бөгөөд бодит байдлыг гуйвуулах (manipulate) хандлага нь олон нийтийн харилцаа холбоо, улмаар нийгэм дэх ардчилсан үйл явцад саад учруулсаар байна. Хуурамч мэдээлэл, алдаатай мэдээлэл, буруу сэдэлтэй мэдээлэл нь мэдээжийн хэрэг шинэ үзэгдэл биш боловч сошиал медиаг өргөнөөр хэрэглэх болсон нь энэхүү асуудлыг улам хурцатгаад байна.⁴¹

Мэдээллийн эмх замбараагүй байдал (information disorder) буюу худал мэдээлэл (fake news)-ийн талаарх эх сурвалжид ихээхэн эшлэгддэг системчлэлийг Клейр Вардле болон Хоссейн Дерахшан нар дэвшүүлсэн байдаг. Вардле болон Дерахшан нар “хор уршиг (harm)” болон “худал байдал (falseness)”-г шалгуур болгож мэдээллийн эмх замбараагүй байдлыг дараах 3 хэлбэрт ангилсан⁴²:

1. Хуурамч мэдээлэл (Disinformation) - Хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага эсвэл улс оронд хор хөнөөл учруулах зорилгоор санаатайгаар бүтээгдсэн худал мэдээлэл.⁴³ Өөрөөр хэлбэл, хууран мэхлэх эсвэл хор уршиг учруулах зорилго санаатайгаар бүтээгдсэн худал агуулга бүхий мэдээлэл. Хүмүүсийг хуурамч мэдээлэл бүтээж тараахад түлхэц болдог гурван гол хүчин зүйл бол мөнгө, улс төрийн нөлөөлөл, эмх замбараагүй байдал үүсгэх хүсэл юм.⁴⁴
2. Алдаатай мэдээлэл (Misinformation) - Худал боловч хор хөнөөл учруулах зорилгоор бүтээгдээгүй мэдээлэл.⁴⁵ Өөрөөр хэлбэл, худал эсвэл төөрөгдүүлсэн гэдгийг нь мэдэхгүй, эсхүл хор хөнөөл учруулах зорилго тээгээгүй хүмүүсийн тараасан худал эсвэл төөрөгдүүлсэн агуулга бүхий мэдээлэл. Хүмүүс худал гэдгийг мэдэлгүйгээр өмнө дурдсан хуурамч мэдээлэл (disinformation)-г хуваалчихвал энэ нь алдаатай мэдээлэл (misinformation) болно.⁴⁶

⁴¹ Lejla Turcilo, Mladen Obrenovic, “Misinformation, Disinformation, Malinformation: Causes, Trends, and Their Influence on Democracy”, *E-paper series “A Companion to Democracy”* #3, p4, Accessed October 30, 2024, https://hk.boell.org/sites/default/files/importedFiles/2020/11/04/200825_E-Paper3_ENG.pdf

⁴² Claire Wardle, Hossein Derakhshan, “INFORMATION DISORDER: Toward an interdisciplinary framework for research and policy making” (2017), *Council of Europe report DGI(2017)09*, p20, Accessed October 30, 2024, <https://rm.coe.int/information-disorder-toward-an-interdisciplinary-framework-for-research/168076277c>

⁴³ Claire Wardle, Hossein Derakhshan, “INFORMATION DISORDER: Toward an interdisciplinary framework for research and policy making” (2017), p20: “Dis-information: Information that is false and deliberately created to harm a person, social group, organization or country.”

⁴⁴ Phoebe Petrovic, “Misinformation, Disinformation: A guide to sorting fiction from reality”, updated July 20, 2023, Accessed October 30, 2024 <https://wisconsinwatch.org/2023/07/misinformation-disinformation-a-guide-to-sorting-fiction-from-reality/>

⁴⁵ Claire Wardle, Hossein Derakhshan, “INFORMATION DISORDER: Toward an interdisciplinary framework for research and policy making” (2017), p20: “Mis-information: Information that is false, but not created with the intention of causing harm.”

⁴⁶ Phoebe Petrovic, “Misinformation, Disinformation: A guide to sorting fiction from reality”, updated July 20, 2023, Accessed October 30, 2024 <https://wisconsinwatch.org/2023/07/misinformation-disinformation-a-guide-to-sorting-fiction-from-reality/>

3. Буруу сэдэлтэй мэдээлэл (Malinformation)⁴⁷ - Бодит байдалд тулгуурласан боловч хувь хүн, байгууллага, улс оронд хор хөнөөл учруулах зорилгоор ашиглагдсан мэдээлэл. Өөрөөр хэлбэл, хор хөнөөл учруулах зорилгоор тараасан бодит агуулга бүхий мэдээлэл. Энэ нь ихэвчлэн хуулийн этгээд болон хувь хүний хувийн мэдээлэл, тухайлбал хэн нэгэн экс хамтрагчийнхаа нүцгэн зургийг онлайн орчинд байршуулах буюу “өшөө авах порно (revenge porn)” зэргээр задрахад тохиолдоно.⁴⁸

Зохиогчид дээрх мэдээллийн эмх замбараагүй байдлын 3 хэлбэрийг илүү ойлгомжтой болгохын тулд 2017 оны Францын ерөнхийлөгчийн сонгуулийн үед болсон тухайлсан тохиолдлуудыг жишээ болгож дараах байдлаар тайлбарласан:

1. Хуурамч мэдээллийн жишээ:

Сонгуулийн кампанит ажлын хамгийн алдартай хуурамч мэдээллийн нэг нь Бельгийн *Le Soir* сонинг дуурайлган хийсэн хуурамч хувилбар дээр Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгч Эммануэль Макроныг Саудын Арабаас санхүүжүүлж байна гэх агуулга бүхий худал нийтлэлийг гаргасан явдал байв. Өөр нэг жишээ бол Макроныг Бахамын арлуудад оффшор данс нээлгэсэн гэх худал агуулга бүхий баримт бичгийг цахим орчноор тараасан явдал байсан.

2. Алдаатай мэдээллийн жишээ:

Францын төв гудамж болох Champs-Elysees-д болсон 2017.04.20 өдрийн халдлага (тус халдлагын улмаас 1 цагдаа нас барж, 2 цагдаагаас гадна 1 энгийн иргэн шархадсан) нь алдаатай мэдээллийн маш олон жишээг гаргаж байсан. Нэг жишээ нь “Лондонгийн Муслимын шашинтнууд энэхүү халдлагыг баярлан тэмдэглэж байна” гэсэн хов жив байв. Өөр жишээ нь сошиал медиагийн хэрэглэгчид /хувь хүмүүс/ дээрх халдлагын талаар “2 дахь цагдаа нас барлаа” гэх мэт маш олон хов живийг болгоомжгүйгээр нийтэлж байсан. Ер нь хүмүүс ихэнхидээ иймэрхүү мэдээллийг бусдад ямар нэгэн хор хөнөөл учруулах санаа зорилгогүйгээр тараачихдаг /share хийчихдэг/. Тэд тэрхэн цаг үедээ баригдаж, уг нь бусдад холбогдох мэдээллийг дамжуулж туслах гэж хичээж байгаа боловч, ийнхүү дамжуулж буй мэдээллээ хангалттай хэмжээнд нягтлах тал дээр алдаа гаргачихдаг.

3. Буруу сэдэлтэй мэдээллийн жишээ:

Энэхүү ангилалд Hate speech, Harassment гэх мэт хүмүүсийг тэдний хувийн түүх, эсхүл холбогдох бүлгийн харьяалалаар нь /хэдийгээр эдгээр мэдээлэл нь бодит байсан хэдий ч/ шалтгаалж, тэдэнд хор нөлөө учруулах санаа зорилготой ашиглаж буй мэдээллийг хамруулна.

Буруу сэдэлтэй мэдээллийн нэг тод жишээ нь Эммануэль Макроны имэйл 5-р сарын 7-нд болсон хоёр дахь шатны санал хураалтын яг өмнөх баасан гарагт задрах үед болсон. Хэдийгээр имэйлд агуулагдаж байсан мэдээлэл бодит байсан хэдий ч, имэйл дээрх


⁴⁷ Claire Wardle, Hossein Derakhshan, “INFORMATION DISORDER: Toward an interdisciplinary framework for research and policy making” (2017), p20: “Mal-information: Information that is based on reality, used to inflict harm on a person, organization or country.”

⁴⁸ Phoebe Petrovic, “Misinformation, Disinformation: A guide to sorting fiction from reality”, updated July 20, 2023, Accessed October 30, 2024 <https://wisconsinwatch.org/2023/07/misinformation-disinformation-a-guide-to-sorting-fiction-from-reality/>

Макроны хувийн мэдээллийг олон нийтэд сонгуулийн өмнөх орой ийнхүү задруулж байгаа нь түүний сонгуулийн кампанит ажилд их хэмжээний хор хөнөөл учруулах зорилготой байсан.

Дээрх системчлэлийг схемээр үзүүлбэл дараах байдалтай харагдана:

TYPES OF INFORMATION DISORDER



Схем 1: Мэдээллийн эмх замбараагүй байдлын 3 хэлбэр

Клейр Вардле болон Хоссейн Дерахшан нарын дэвшүүлсэн мэдээллийн эмх замбараагүй байдлын 3 хэлбэрийн “Хуурамч мэдээлэл (disinformation)” болон “Буруу сэдэлтэй мэдээлэл (malinformation)” нь хор уршиг учруулах зорилготой байдгаараа төстэй боловч эхнийх нь худал мэдээлэл дээр суурилдаг бол нөгөөх нь бодит мэдээлэл дээр суурилдгаараа ялгаатай. Харин “Хуурамч мэдээлэл (disinformation)” болон “Алдаатай мэдээлэл (misinformation)” нь бодит бус буюу худал мэдээлэл дээр суурилдгаараа төстэй боловч эхнийх нь бусдад хор уршиг учруулах зорилготой байдаг бол нөгөөх нь тийм зорилго агуулаагүй байдгаараа ялгаатай.

Ийнхүү авч үзвэл, жишээлбэл холбогдох төрийн албан хаагч 13 удаа гадаад улс руу томилолтоор явсныг 15 удаа явсан гэх агуулга бүхий сэтгүүлчийн мэдээлэл аль хэлбэрт хамаарах вэ? Энэ тохиолдолд хэрэв сэтгүүлч ингэж мэдээлсэн нь хор уршиг учруулах зорилготой буюу 15 биш 13 удаа явсныг мэдсээр байж, тухайн мэдээллийн улмаас төрийн

албан хаагчид хор уршиг учруулахыг хүсэж үйлдсэн бол “хуурамч мэдээлэл”-д хамаарахаар байна. Харин хор уршиг учруулах зорилгогүй буюу эх сурвалжаа хангалттай нягталж шалгаагүй зэргээр 15 биш 13 удаа явсныг мэдэх боломжтой байсан ч мэдэлгүй үйлдсэн, эсхүл 13 удаа явсныг мэдсэн боловч мэдээ бэлтгэхдээ 15 удаа явсан гэж алдаж бичсэн зэрэг хайхрамжгүй үйлдэл гаргасан бол “алдаатай мэдээлэл”-д хамаарахаар байна.⁴⁹

Дээр дурдсан мэдээллийн эмх замбараагүй байдлын 3 хэлбэрт тулгуурлаж буруутай этгээдэд ямар тохиолдолд ямар төрлийн шийтгэлийг хэрхэн оногдуулах хэрэгтэй талаар дүн шинжилгээ хийе. Энэхүү дүн шинжилгээг хийхэд 1. Холбогдох харилцааг эрүүгийн хууль, эсхүл иргэний хууль (үүн дотроо гэм хорын эрх зүй) болон зөрчлийн тухай хуулиар зохицуулж байгаа, 2. Мэдээллийн эмх замбараагүй байдлаас шалтгаалж үүсэх сөрөг үр дагаврыг олон нийтийн эрх ашиг болон хувийн (энгийн иргэн, эсхүл олонд танигдсан улс төрч, нийтийн албан тушаалтан) эрх ашиг гэж ерөнхийлөн ангилах боломжтой гэсэн нэмэлт 2 элементүүдийг давхар харгалзаж үзлээ.

Нэгт, нэлээд ойлгомжтой байгаа зүйл бол холбогдох **хуурамч мэдээлэл** (disinformation) нь нийтийн эрх ашгийг зөрчихөөр байгаа бол үүнийг эрүүгийн эрх зүйгээр зохицуулахад буруудах зүйлгүй. Жишээлбэл Сингапур улс 2019 онд “Цахим худал хуурмаг, төөрөгдүүлэлтээс хамгаалах тухай хууль (Protection from Online Falsehoods and Manipulation Act)”-г баталсан. Энэхүү хуулиар “бодит мэдээлэл (a statement of fact)” гэдгийг дундаж оюун ухаан бүхий хүн бодит байдлын илэрхийлэл гэж ойлгохуйц харсан, сонссон, эсхүл тэгж мэдэрсэн мэдээллийг хэлнэ гэж тодорхойлсны дараа, “мэдээлэл худал байна” гэдэг нь холбогдох мэдээлэл бүхэлдээ эсхүл нэг хэсэг нь, түүнчлэн тэр чигтээ эсхүл илрэн гарч буй тухайлсан контекст нь ямар байхаас үл хамаарч худал, эсхүл төөрөгдүүлсэн байхыг ойлгоно гэжээ.⁵⁰ Хэрэв холбогдох худал мэдээлэл нь Сингапурын “үндэсний аюулгүй байдал”, “хүн амын эрүүл мэнд, нийтийн амар тайван байдал, нийтийн санхүүгийн байдал”, “бусад улстай харилцах нөхөрсөг харилцаа”-нд хор уршиг учруулах, “сонгууль, ард нийтийн санал асуулгын дүн”-д нөлөөлөх, “ялгаа бүхий нийгмийн бүлгүүдийн дунд дайсагнал, үзэн ядалт буюу дургуйцсан сэтгэгдэл”-ыг өдөөх, “төрийн чиг үүргийн гүйцэтгэлд итгэх олон нийтийн итгэл”-ийг бууруулах гэх мэт нийтийн эрх ашигт хор нөлөө учруулахаар бол тус хуулиар холбогдох хариуцлагыг хүлээлгэхээр зохицуулжээ.⁵¹ Хууль зөрчвөл хувь хүнийг 50,000

⁴⁹ Хуурамч мэдээлэл (disinformation) болон “Алдаатай мэдээлэл (misinformation)”-ийн ялгааны талаар дараах эх сурвалжаас дэлгэрүүлж үзнэ үү: Caroline Jack, “Lexicon of Lies: Terms for Problematic Information”, *Data&Society Research Institute*, p2, Accessed October 30, 2024, https://datasociety.net/pubs/oh/DataAndSociety_LexiconofLies.pdf

⁵⁰ Protection from Online Falsehoods and Manipulation Act 2019, Article 2. General interpretation:

2 (2) In this Act -

(a) a statement of fact is a statement which a reasonable person seeing, hearing or otherwise perceiving it would consider to be a representation of fact; and
(b) a statement is false if it is false or misleading, whether wholly or in part, and whether on its own or in the context in which it appears.

Accessed October 30, 2024, <https://sso.agc.gov.sg/Act/POFMA2019?ViewType=SI>

⁵¹ Protection from Online Falsehoods and Manipulation Act 2019, Article 7:

(1) A person must not do any act in or outside Singapore in order to communicate in Singapore a statement knowing or having reason to believe that —

(a) it is a false statement of fact; and
(b) the communication of the statement in Singapore is likely to —
(i) be prejudicial to the security of Singapore or any part of Singapore;

хүртэлх доллараар, эсхүл 5 хүртэлх жилээр хорих ялаар, хуулийн этгээдийг 500,000 хүртэлх доллараар торгох ялаар шийтгэнэ.⁵² Өөрөөр хэлбэл, холбогдох этгээд худал мэдээллийг дээр дурдсан нийтийн ашиг сонирхолд хор уршиг учруулахаар тараасан тохиолдолд л хариуцлага ногдуулахаар зохицуулсан байна. Тарааж буй мэдээлэл нь хэдий худал боловч, энэ талаар мэдэхгүй байгаа тохиолдолд буюу алдаатай мэдээлэл (misinformation)-ийн хувьд холбогдох этгээдэд хариуцлага ногдуулахгүй.⁵³ Манай улсын хувьд ч гэсэн төстэй харилцааг Эрүүгийн хууль (2017)-ийн “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах”⁵⁴, “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх”⁵⁵ гэсэн зүйл заалтаар зохицуулж байна. Нийтийн эрх ашигт нор уршиг учруулах худал мэдээллийн асуудлыг эрүүгийн эрх зүйгээр

- (ii) be prejudicial to public health, public safety, public tranquillity or public finances;
- (iii) be prejudicial to the friendly relations of Singapore with other countries;
- (iv) influence the outcome of an election to the office of President, a general election of Members of Parliament, a by-election of a Member of Parliament, or a referendum;
- (v) incite feelings of enmity, hatred or ill-will between different groups of persons; or
- (vi) diminish public confidence in the performance of any duty or function of, or in the exercise of any power by, the Government, an Organ of State, a statutory board, or a part of the Government, an Organ of State or a statutory board.

Accessed October 30, 2024, <https://sso.agc.gov.sg/Act/POFMA2019?ViewType=SI>

⁵² Protection from Online Falsehoods and Manipulation Act 2019, Article 7 (2).

⁵³ Singapore Fake News Laws: Guide to POFMA (Protection from Online Falsehoods and Manipulation Act), Accessed October 30, 2024, <https://singaporelegaladvice.com/law-articles/singapore-fake-news-protection-online-falsehoods-manipulation/>

⁵⁴ Эрүүгийн хууль, 14.8 “Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах”

1. Сонгуульд оролцогч улс төрийн нам, намуудын эвсэл, нэр дэвшигчийн нэр хүндэд халдаж, илт худал мэдээлэл тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг төрийн албан хаагч, сонгуулийн хорооны албан тушаалтан, ажилтан үйлдсэн бол нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар нийтийн албанд томилогдох эрх хасаж нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁵⁵ Эрүүгийн хууль, 18.2 “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх”

1. Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах зорилгоор худал мэдээлэл тараасан, мөнгөн тэмдэгт, валют худалдсан, худалдан авсан, гүйлгээ хийсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
2. Энэ гэмт хэргийг:
 - 2.1. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж;
 - 2.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

зохицуулахыг НҮБ-ийн Хүний эрхийн хорооноос ч мөн зөвшөөрсөн байдаг гэж үзэж болохоор байна.⁵⁶

Хоёрт, холбогдох **хуурамч мэдээлэл** (disinformation) нь хувийн эрх ашиг (энэ нь дотроо энгийн иргэн, эсхүл олонд танигдсан улс төрч, нийтийн албан тушаалтны гэж ангилагдана)-г зөрчихөөр байгаа бол үүнийг эрүүгийн эрх зүй гэхээс илүүтэй иргэний, эсхүл захиргааны эрх зүйгээр зохицуулах нь олон улсын сайн туршлага гэж харагдаж байна. Жишээлбэл НҮБ-ийн Хүний эрхийн хорооноос энэ асуудлыг эрүүгийн хуулиар зохицуулахаас аль болох зайлсхийхийг зөвлөдөг.⁵⁷ Харин манай улсын хувьд хувийн эрх ашигт нор уршиг учруулах худал мэдээллийн асуудлыг Эрүүгийн хуулийн “Худал мэдээлэл тараах”⁵⁸ гэсэн зүйл заалтаас гадна⁵⁹, Иргэний хууль (2002)⁶⁰-иар зохицуулж байна.

⁵⁶ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011), para 47 “States parties should consider ... the application of the criminal law should only be countenanced in *the most serious of cases* and imprisonment is never an appropriate penalty. (Emphasis added)”

⁵⁷ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011), para 47 “States parties should consider the decriminalization of defamation and, in any case, the application of the criminal law should only be countenanced in *the most serious of cases* and imprisonment is never an appropriate penalty. (Emphasis added)”

⁵⁸ Эрүүгийн хууль, 13.14 “**Худал мэдээлэл тараах**”

1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

⁵⁹ Хуурамч мэдээлэл (disinformation) гэж хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага эсвэл улс оронд хор хөнөөл учруулах зорилгоор санаатайгаар бүтээгдсэн худал мэдээллийг хэлнэ гэж өмнө нь тодорхойлсон. Гэвч манай улсын эрүүгийн хуулийн 13.14 “Худал мэдээлэл тараах” зүйл заалт гэмт хэргийн субъектив шинжийг тодорхой тусгалгүй орхисноороо Буруу сэдэлтэй мэдээлэл (misinformation)-ийн хувьд ч холбогдох этгээд эрүүгийн хуулиар хариуцлага хүлээх боломжтой болчихсон байгааг анхаарах хэрэгтэй. Энэ талаар судлаач Д.Оросоо нар дараах дүгнэлтийг хийжээ.

“Онолын хувьд худал мэдээлэл тараах гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрт хамаарч байгаа боловч хүний нэр төр, алдар хүндийг гутаах санаа зорилгогүй, алдаатай, худал мэдээлэл тараасан үйлдэл ч уг зүйлээр эрүүгийн хариуцлагад татагдаж байна. Субъектив талын хувьд гэмт этгээд бусдын нэр төр, алдар хүндэд хохирол учруулах гэсэн шууд санаатай үйлдлээр илрэх ёстой боловч сэдэлт болон хүний нэр, алдрыг гутаах зорилгыг хууль тогтоогч заагаагүй тул заавал шаардах нөхцөл биш юм. Цаашид Эрүүгийн хуулийн “худал мэдээлэл тараах” гэмт хэргийн бүрэлдэхүүнд субъектив шинжийг нэмж тусгах шаардлагатай.”

Д.Оросоо нар, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал”, ННФ, 2021, х60, Сүүлд үзсэн 2024.10.31,

https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformation%20Crime_Web%20version.pdf

⁶⁰ Иргэний хууль, 21 дүгээр зүйл. **Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах**

“21.2.Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.” (Доогуур зураас нэмсэн)

Гуравт, холбогдох **буруу сэдэлтэй мэдээлэл** (malinformation) нь учруулж буй хор уршгаасаа шалтгаалаад буюу хэрэв нийтийн эрх ашгийг зөрчихөөр байгаа бол эрүүгийн эрх зүйгээр, харин хувийн эрх ашгийг зөрчихөөр байгаа бол иргэний, эсхүл захиргааны эрх зүйгээр зохицуулах хэрэгтэй санагдаж байна. Манай улсын хувьд эхний тохиолдлыг онолын хувьд Эрүүгийн хуулийн “Төрийн нууцыг задруулах” гэсэн зүйл заалтаар зохицуулж байна гэж хэлж болохоор байна.⁶¹ Харин хоёр дахь тохиолдлыг Иргэний хуулийн 21.3-21.9 дүгээр зүйлээр⁶², түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих” гэсэн зүйл заалтаар зохицуулж байна.⁶³

Дөрөвт, холбогдох **хуурамч мэдээлэл** (disinformation), эсхүл **буруу сэдэлтэй мэдээлэл** (malinformation) нь хувийн эрх ашгийг зөрчихөөр байгаа тохиолдолд тэрхүү эрх ашиг нь энгийн иргэнийх үү, эсхүл олонд танигдсан улс төрч, нийтийн албан тушаалтных уу гэдгээс шалтгаалж, зөрчлийн босгыг ялгамжтай байдлаар тогтоодог байх хэрэгтэй санагдаж байна. Хэрэв аливаа олонд танигдсан улс төрч, нийтийн албан тушаалтны талаарх хуурамч мэдээлэл, эсхүл буруу сэдэлтэй мэдээлэл нийтийн ашиг сонирхлыг хөндсөн улс төрийн

⁶¹ Эрүүгийн хууль, 19.12 дугаар зүйл. **Төрийн нууцыг задруулах**

1.Төрийн маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн онц чухал нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

⁶² Иргэний хууль, 21 дүгээр зүйл. **Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах**

21.3.Бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс бусдын нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан бол энэ хуулийн 21.2-т заасан журмаар няцаах үүрэг хүлээнэ.

21.4.Хуулиар тогтоосон хувийн нууцад хамааралтай мэдээг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр тарааснаас гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

21.5.Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлснээс гэм хор учирсан гэж үзвэл тухайн этгээд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. [...]

⁶³ Зөрчлийн тухай хууль, 6.27 дугаар зүйл. **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль зөрчих**

1.Мэдээллийн эзнээс хуульд заасан үндэслэл болон анх зөвшөөрөл авсан зорилгоос өөр зорилгоор хүний хувийн мэдээллийг ашигласан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мэдээллийг хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулсны үр дүнд мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж, хууль зүйн сөрөг үр дагавар үүсгэж болох шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, бусдад дамжуулсан, задруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

асуудлын хүрээнд бүтээгдэж, тараагдсан бол тухайн үйлдлийг зөрчилд тооцох босго нь энгийн иргэнийхтэй харьцуулахад харьцангуй өндөр байх хэрэгтэй. Энэ бол тухайлбал АНУ-ын Дээд шүүхийн “*Нью-Йорк Таймс сонин эср. Салливан (1964)*”⁶⁴-ийн хэрэг, Европын Хүний Эрхийн Шүүхийн “*Линген эср. Аустри (1986)*”⁶⁵-ийн хэрэг, түүнчлэн НҮБ-ийн Хүний эрхийн хорооноос нэгэнт хүлээн зөвшөөрсөн зарчим юм.⁶⁶ Харин энэхүү зарчим манай улсын хуулийн тогтолцоо (хууль тогтоомжоос болон шүүхийн практик)-нд байхгүй байгаа нь харамсалтай санагдаж байна.⁶⁷

Тавт, **алдаатай мэдээлэл** (misinformation)-ийн асуудлыг хуулиар зохицуулахгүй үлдээсэн нь дээр болов уу. Жишээлбэл сошиал медиагийн хэрэглэгч холбогдох хуурамч мэдээлэл (disinformation)-г мэдэлгүйгээр тараасан бол түүнд ямар нэг хариуцлага оногдуулаад байх шаардлагагүй юм. Харин сэтгүүлчийн хувьд бодит байдлыг олон нийтэд дамжуулах тусгайлсан чиг үүрэгтэй этгээд тул алдаатай мэдээлэл дамжуулсан тохиолдолд тус асуудлыг сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулах нь тохиромжтой санагдаж байна.

⁶⁴ New York Times Co. v. Sullivan, 376 U.S. 254 (1964), Accessed October 30, 2024, <https://supreme.justia.com/cases/federal/us/376/254/>

Энэхүү хэрэг бол мэдээллийн эмх замбараагүй байдлын “Хуурамч мэдээлэл (Misinformation)”-ийн хэлбэртэй илүү хамааралтай хэрэг юм.

⁶⁵ Case of Lingens V. Austria (1986), Accessed October 30, 2024, <https://hudoc.echr.coe.int/fre#%7B%22itemid%22%3A%22001-57523%22%7D>

Энэхүү хэрэг бол мэдээллийн эмх замбараагүй байдлын “Буруу сэдэлтэй мэдээлэл (Malinformation)”-ийн хэлбэртэй илүү хамааралтай хэрэг юм.

⁶⁶ UN Human Rights Committee, “General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression”, (2011), para 38 “[T]he Committee has observed that in circumstances of public debate concerning public figures in the political domain and public institutions, the value placed by the Covenant upon uninhibited expression is particularly high. Thus, the mere fact that forms of expression are considered to be insulting to a public figure is not sufficient to justify the imposition of penalties, albeit public figures may also benefit from the provisions of the Covenant. Moreover, all public figures, including those exercising the highest political authority such as heads of state and government, are legitimately subject to criticism and political opposition.”

⁶⁷ Тухайлбал дараах 2 шүүхийн шийдвэрийг үзнэ үү:

Кэйз №01 - Ерөнхийлөгч У.Хүрэлсүхээр мийм хийж үзэл бодлоо илэрхийлсэн нь. Үз., Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Тогтоол №2023/ШЦТ/351 (2023.05.22).

Кэйз №02 - Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийг шүүмжилж бичсэн шүлгэн пост. Үз., Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Тогтоол №2023/ШЦТ/1218 (2023.10.13).

ХОЁР. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, СЭТГҮҮЛЧ ЭХ СУРВАЛЖАА НУУЦЛАХ, ГЭРЧИЙН МЭДҮҮЛЭГ ӨГӨХӨӨС ТАТГАЛЗАХ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ АСУУДАЛ

Боловсруулсан: МУИС, ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхим,
Ахлах багш С.Сүхчулуун (LL.D)

2.1. Монгол улсын эрх зүйн орчин

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан (сэтгүүлч) нь шүүмжлэлтэй, хурц нийтлэл хэвлэгдэхэд түүнтэй холбоотойгоор тодорхой хүмүүс, байгууллага шүүхэд нэхэмжлэл гаргах магадлалтай байдаг¹ бөгөөд 2023 оны судалгаанд дурдсанаар шүүх, цагдаа, прокуророос дуудах нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудад тулгардаг асуудлын хоёрдугаарт эрэмбэлэгдсэн байна².

Иймд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад эх сурвалжаа нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын эрх зүйн хэм хэмжээнд тусгасан эсэхийг авч үзье.

1) Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан эх сурвалжийг нууцлах эрх

2005.01.27-ны өдрийн Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 34.2 дахь хэсэгт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх үзэж ил болгосноос бусад тохиолдолд олон нийтийн радио, телевизийн ажилтан мэдээллийн эрх сурвалжийг нууцлах эрхтэй.” гэж заажээ. Гэвч тус зохицуулалт нь зөвхөн олон нийтийн радио, телевизийн ажилтнаар хязгаарлагдаж, бусад салбарын хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрх хуулиар олгогдоогүй тухайд урьд хийгдсэн судалгаанд нэгэнт авч үзжээ³.

Мөн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрхийг хуулиар баталгаажуулж өгөх шаардлага үүсэж буй талаар нийгэмд тодорхой ойлголттой болсон хэдий боловч⁴ 2024 оны 10 сарын байдлаар тус эрхийг баталгаажуулсан хүчин төгөлдөр эрх зүйн хэм хэмжээ байхгүй байна.

2) Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй холбоотойгоор түүний гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг баталгаажуулах шаардлагатай. Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээнд

¹ Глоб Интернэшнл Төв, “Сэтгүүлчдийн аюулгүй байдал” гарын авлага, УБ., 2015 он, тал 36.
<https://gic.mn/images/upld/safetyofjournalists.pdf>

² Глоб Интернэшнл Төв, “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүн” судалгааг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://www.gic.mn/post/r/1730>

³ Глоб Интернэшнл Төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2022-2023, УБ., 2024 он, тал 9-11.
Судалгааны бүтээлийг үзэх холбоос,
https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2022_2023_mn.pdf

⁴ Тухайлбал, Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс 2021.05.27-ны өдөр “Мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж байжээ. Дэлгэрүүлж үзэх холбоос,
<https://www.mediacouncil.mn/a/265>

гэрчийн мэдүүлэг өгөхгүй байх, татгалзах эрхийг хэрхэн хуульчилсан талаар дараах хүснэгтэд үзүүлэв.

Хуулийн нэр	Холбогдох хуулийн зүйл, заалт	Тайлбар
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ⁵ (ИХШХШТХ-2002)	43.8.Дараахь хүнийг гэрчээр дуудах буюу мэдүүлэг авч болохгүй: 43.8.1. үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагч , зохигчийн төлөөлөгч буюу эрүүгийн хэргийн өмгөөлөгч; 43.8.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан хамаарахгүй.
Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль ⁶ (ЗХШХШТХ-2016)	37.10.Дараахь хүнийг гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй: 37.10.1. үүргээ гүйцэтгэх замаар хэргийн нөхцөл байдлыг мэдэх болсон хэргийн оролцогч , тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч; 37.10.2.иргэний эрх зүйн чадамжгүй этгээд.	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан зөвхөн хэргийн оролцогч байх тохиолдолд үйлчилнэ. Нийтлэг тохиолдолд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нь гэрчээр дуудах, мэдүүлэг авч болохгүй этгээдэд хамаарахгүй.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ⁷ (ЭХХШТХ-2017)	16.3 дугаар зүйл.Мэдүүлэг 4.Дараахь хүнээс гэрчийн мэдүүлэг авч болохгүй: 4.1.тухайн хэргийг урьд нь хянан шийдвэрлэсэн шүүгч, прокурор; 4.2.өмгөөлөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үүргээ гүйцэтгэж байх явцад тухайн хэргийн байдлыг мэдэх болсон өмгөөлөгч, хуульч; 4.3.хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэх замаар уг хэргийн байдлыг мэдэх болсон эвлэрүүлэн зуучлагч ; 4.4.өвчний улмаас хэргийн нөхцөл байдлыг зөв ойлгож, зөв мэдүүлэх	Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан хамаарахгүй.

⁵ Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legalinfo.mn/mn/detail/302>

⁶ Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legalinfo.mn/mn/detail/11703>

⁷ Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legalinfo.mn/mn/detail/12694>

	чадваргүй болсон нь тогтоогдсон хүн; 4.5.эмчилгээ хийж байх явцад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн холбогдсон хэргийн талаар мэдэх болсон сэтгэл зүйч; 4.6.өөрийн болон гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан гэрч, хохирогч.	
--	---	--

Дээрх хүснэгтэд үзүүлснээр хүчин төгөлдөр үйлчилж буй ИХШХШТХ-2002, ЗХШХШТХ-2016, ЭХХШТХ-2017 оны хуульд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нь гэрчээр дуудах болон мэдүүлэг авч болохгүй этгээд гэдэгт хамаарахгүй байх тул Монгол Улсын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтанд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх хуульчлагдаагүй гэж дүгнэж байна.

2.2. Харьцуулсан судалгаа

Харьцуулсан эрх зүйн судалгааны үндсэн дээр хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны мэдээллийн эх сурвалжийг нууцлах, улмаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг баталгаажуулах шаардлагатай гэсэн онолын үндэслэлийг тайлбарлан таниулах хэрэгцээ үүсэж байна.

1) Япон

Тухайлбал, Япон Улсад сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй холбоотой хуульд тусгайлан заасан зүйл, заалт байхгүй, зөвхөн сэтгүүлчийн ёс зүйн хүрээнд хэрэгждэг байна.⁸ Сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй холбоотойгоор гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульд тодорхой тусгаагүй боловч 2006 онд шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн жишиг шийдвэрт сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг зөвшөөрсөн байдаг⁹. Тодруулбал, Япон Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 197.1.3 дахь хэсэгт зааснаар гэрч нь албаны үйл ажиллагаанд хамаарах нууцтай холбоотой асуудлаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй гэж заасан нь сэтгүүлч мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд олж авсан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрх, улмаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг зөвшөөрөх үндэслэл болно гэж тайлбарлагддаг байна.¹⁰

Харин Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 149 дүгээр зүйлд “Эмч, шүдний эмч, эх баригч, сувилагч, өмгөөлөгч (гадаад улсын хууль тогтоомжийн дагуух өмгөөлөгчийг мөн адил хамааруулах), патентын эрхийн өмгөөлөгч, нотариатч, шашны холбогдолтой албан тушаал хашиж байсан болон ажиллаж байсан хүмүүс албаны үүргээ гүйцэтгэх итгэмжлэлийн үндсэн дээр олж мэдсэн бодит байдал болон бусад хүний нууцад хамаарах асуудлаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно” гэж хуульчилжээ. Тус зүйлд

⁸ 塩崎 隆敏「取材対象者との関係性における倫理規範」放送研究と調査 71 (9), 2021, 45 頁。

Дэлгэрүүлж үзэх холбоос, https://www.jstage.jst.go.jp/article/bunken/71/9/71_42/article-char/ja/

⁹ 塩崎 隆敏「取材対象者との関係性における倫理規範」放送研究と調査 71 (9), 2021, 45 頁。

Дэлгэрүүлж үзэх холбоос, https://www.jstage.jst.go.jp/article/bunken/71/9/71_42/article-char/ja/

¹⁰ 安井 英俊「取材源の秘匿と証言拒絶権」福岡大学法学論叢 59 (4), 2015-03, 2 頁。Дэлгэрүүлж үзэх холбоос, <https://fukuoka-u.repo.nii.ac.jp/records/1471>

хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны үйл ажиллагаа хамаарна гэж шууд тусгаагүй байна. Япон Улсын шүүхийн шийдвэрт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 149 дүгээр зүйлд заасан гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг эдлэх этгээдэд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан хамаарахгүй гэж үзэн мэдээллийн эх сурвалжийн талаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзсан нь хууль бус гэж үзсэн байдаг ажээ¹¹. Энэ тухайд Япон Улсын эрүүгийн эрх зүйн судлаач Камо Ёошисүкэ бүтээлдээ, хэвлэл мэдээллийн эрх чөлөө нь хувь хүний эдлэх эрх чөлөөний баталгаа болон ардчилсан ёс, эрх чөлөөт нийгмийн баталгаа болох гэсэн хоёр талтай болохыг эрүүгийн эрх зүйд анхаарах шаардлагатай гэж тэмдэглэжээ. Тэрээр, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 149 дүгээр зүйлд заасан гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан нарт баталгаатай эдлүүлэх явдал нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ардчилсан ёс, эрх чөлөөт нийгмийн баталгаа болох талаас нь хамгаалахад зайлшгүй шаардлагатай хэмээн дүгнэсэн байна.¹²

2) Америкийн Нэгдсэн Улс

Сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлахад үүсэж болох асуудал

Харин АНУ-ын муж улсад сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлах тохиолдол байдаг боловч Холбооны улсын хэмжээнд хуульчилж өгөөгүй байдаг. АНУ-тай адилаар хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, тодруулбал сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлах нь дараах сөрөг үр дагаврыг үүсгэж болно. Үүнд, 1) Шударга, тэгш шүүхийн үйл ажиллагаатай сөргөлдөх; 2) Хууль бусаар мэдээллийг задруулсан этгээдийн хамгаалах хэрэгсэл болох; 3) Хууль тогтоогч сэтгүүлч гэж хэн болохыг тогтоох эрхийг эдлэх зэрэг сөрөг үр дагавартай бөгөөд дараах хэсэгт дэлгэрүүлж тайлбарлах болно.¹³

1) Шударга, тэгш шүүхийн үйл ажиллагаатай сөргөлдөх магадлалтай: Сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хэрэгжүүлж эхэлбэл, тэрхүү мэдээллийг шаардаж буй тал нь сэтгүүлчид хадгалагдаж буй тухайн мэдээллийг нотлох баримт болгож ашиглах боломжгүйд хүрнэ. Жишээлбэл, иргэний хэргийн хувьд зохигч тал нотлох баримтыг өөрөө бүрдүүлж шүүхэд өгөх тул сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлах нь тэрхүү мэдээлэл хэрэгтэй байгаа талын хувьд шударга, тэгш шүүхээр шүүлгэх эрхийн баталгаа хангагдахгүй орхигдох эрсдэл дагуулна.

2) Хууль бусаар мэдээллийг задруулсан этгээдийн хамгаалах хэрэгсэл болох магадлалтай: Сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг зөвшөөрсний дүнд тэрхүү сэтгүүлч нь хууль бус арга замаар мэдээллийг задруулсан тухайн этгээд хэн болохыг тогтоох талаарх мэдээллийг нууцлах эрх олгогдож, улмаар хууль бусаар мэдээлэл задруулсан этгээдийг илрүүлэн тогтоож, прокурорын шатанд шилжүүлэхэд хүндрэл дагуулна. Иймд, аюулгүй байдлын эсрэг террорист халдлага гэх мэт үлэмж хэмжээний

¹¹ 鴨良弼「報道の自由と刑事訴訟法」一橋論叢 第六十二巻 第四号、380頁。Судалгааг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://hermes-ir.lib.hit-u.ac.jp/hermes/ir/re/2463/ronso0620400350.pdf>

¹² Мөн тэнд.

¹³ 大塚 一美「ジャーナリストの証言拒絶権法制化に関する一考察：米国を素材として」マス・コミュニケーション研究 77 (0), 2010, 171-173 頁。Судалгааг дэлгэрүүлж үзэх холбоос, https://www.jstage.jst.go.jp/article/mscom/77/0/77_KJ00006544573/article/-char/ja/

хохирол дагуулах хууль бус үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл задруулсан этгээдийг хэн болохыг тогтооход сэтгүүлчийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй байх гэж тодорхой хуульчлах шаардлага үүснэ.

3) Хууль тогтоогч сэтгүүлч гэж хэн болохыг тогтоох эрхийг эдлэхэд хүрнэ: Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлан тогтоох гэдэг нь хууль тогтоох эрх мэдлийн байгууллагад сэтгүүлч гэж хэн болох сэтгүүл зүйн үйл ажиллагаа гэж юу болохыг тогтоон тодорхойлох эрхийг олгож буйтай адил юм. Иймд хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу хамаарах хүрээ нь багасах эрсдэл байхаас гадна хууль тогтоох эрх мэдлийн байгууллагын бүрэн удирдлага дор шилжих эрсдэл байгааг үгүйсгэх аргагүй юм.

Сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлах талаарх хуулийн төслийн танилцуулга

Энэхүү хэсэгт 2009 онд АНУ-ын Конгрессын дээд танхим (Сенатын танхи)-аас боловсруулсан “Мэдээллийн чөлөөтэй урсгалтын тухай хуулийн төсөл= Free Flow of Information Act of 2009”(цаашид “S.448 хуулийн төсөл” гэх)¹⁴ болон мөн онд АНУ-ын Конгрессын доод танхим (Төлөөлөгчдийн танхим)-аас боловсруулсан “Мэдээллийн чөлөөтэй урсгалтын тухай хуулийн төсөл=Free Flow of Information Act of 2009”(цаашид “H.R.985 хуулийн төсөл” гэх)¹⁵ боловсруулагдсан. Энд дурдсан S.448 хуулийн төсөл нь нийт 8 зүйл, H.R.985 хуулийн төсөл нь нийт 4 зүйлээс бүрдэх боловч тэдгээрийн зохицуулах харилцаа, хуулийн төслийн хэмжээ зэрэг нь ойролцоо юм.

А. Хоёр хуулийн төслийн бүтэц, гарчиг

	S.448 хуулийн төсөл	H.R.985 хуулийн төсөл
1) Хуулийн төслийн бүтэн нэр	“Олон нийтэд хүргэх мэдээллийн чөлөөт урсгалыг дэмжих үүднээс Холбооны албадлага ашиглан мэдээ, мэдээлэлд хамааралтай тодорхой хүмүүсийн мэдээллийг ил болгох урьдчилсан нөхцөлийг ил болгох тухай хуулийн төсөл”= “To maintain the free flow of information to the public by providing conditions for the federally compelled disclosure of information by certain persons connected with the news media.”	S.448 хуулийн төсөлтэй адил.
2. Хуулийн төслийн бүтэц	Дараах 8 зүйлээс бүрдэнэ. 1-р зүйл. Хуулийн төслийн богино гарчиг	Дараах 4 зүйлээс бүрдэнэ. 1-р зүйл. Хуулийн төслийн богино гарчиг

¹⁴ Хуулийн төслийг англи хэл дээрх үзэх холбоос, <https://www.govinfo.gov/content/pkg/BILLS-111s448is/pdf/BILLS-111s448is.pdf>

¹⁵ Хуулийн төслийг англи хэл дээрх үзэх холбоос, <https://www.govinfo.gov/content/pkg/BILLS-111hr985ih/pdf/BILLS-111hr985ih.pdf>

	(SEC1. SHORT TITLE.) 2-р зүйл. Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл (SEC. 2. COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) 3-р зүйл. Гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагаатай холбоотой гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй байх тохиолдол (SEC. 3. EXCEPTION RELATING TO CRIMINAL OR TORTIOUS CONDUCT) 4-р зүйл. Хүн алах, барьцаалах эсхүл хүний биед хүнд гэмтэл учруулахтай холбоотой гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй байх тохиолдол (SEC. 4. EXCEPTION TO PREVENT DEATH, KIDNAPPING, OR SUBSTANTIAL BODILY INJURY) 5-р зүйл. Террорист үйл ажиллагаа эсхүл Үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаатай холбоотой гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй байх тохиолдол (SEC. 5. EXCEPTION TO PREVENT TERRORIST ACTIVITY OR HARM TO THE NATIONAL SECURITY) 6-р зүйл. Харилцаа холбооны үйлчилгээ түгээгчээс ил болгохыг албадах мэдээлэл. (SEC.6. COMPELLED DISCLOSURE FROM	(SEC1. SHORT TITLE.) 2-р зүйл. Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл (SEC. 2. COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) 3-р зүйл. Харилцаа холбооны үйлчилгээ түгээгчээс ил болгохыг албадах мэдээлэл. (SEC.3. COMPELLED DISCLOSURE FROM COMMUNICATIONS SERVICE PROVIDERS) 4-р зүйл. Нэр томъёоны тодорхойлолт (SEC. 4. DEFINITIONS)
--	---	---

	COMMUNICATIONS SERVICE PROVIDERS) 7-р зүйл. Нууцын тухай зөвшөөрөл эсхүл амлалт өгөөгүй эх сурвалж болон түүнд үндэслэн үүссэн үйл ажиллагааны тухай (SEC. 7. SOURCES AND WORK PRODUCT PRODUCED WITHOUT PROMISE OR AGREEMENT OF CONFIDENTIALITY) 8-р зүйл. Нэр томъёоны тодорхойлолт (SEC. 8. DEFINITIONS)	
--	---	--

Б. Хоёр хуулийн төслийн онцлох зүйл, заалт харьцуулалт

Дараах хэсэгт, S.448 хуулийн төсөл болон H.R.985 хуулийн төсөлд 1) гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх бүхий субъект гэж хэнийг ойлгох, 2) гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийн объект юу болох, 3) гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэх эсэхийг тогтоох урдчилсан нөхцөл, 4) гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байх тохиолдлын талаар хэрхэн тусгасан болохыг танилцуулна.

	S.448 хуулийн төсөл	H.R.985 хуулийн төсөл
1) Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх бүхий субъект хэн болохыг тодорхойлсон байдал	Хуулийн төслийн SEC. 8(2)-т “Үйлчлэлд хамаарах этгээд” (Covered person) гэдэгт, (A) Сэтгүүл зүйд хамаарал бүхий этгээдийг илэрхийлэх; (B) Дээрх (A)-д заасан этгээдэд хяналт тавигч (supervisor), ажил олгогч(employer), толгой компани(parent company), охин компани(subsidiary), нэгдсэн компани(affiliate) хамааруулж ойлгоно; (C) Дараах этгээдийг хамааруулахгүй: I. Гадаад улсын засгийн эрх эсхүл түүний төлөөлөгч II. Гадаад улсын террорист байгууллага	Хуулийн төслийн SEC. 4(2)-т “Үйлчлэлд хамаарах этгээд” (Covered person) гэдэгт, “тухайн этгээдийн амьжиргааны чухал бүрэлдэхүүн хэсэг эсхүл санхүүгийн чухал бүрэлдэхүүн хэсгийг олж авахын тулд, бүс нутаг, үндэсний болон олон улсад өрнөсөн зүйл, бусад олон нийтэд түгээх нь олон нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж үзсэн зүйлтэй холбоотой мэдээ эсхүл мэдээллийг тогтмол хугацаанд цуглуулах, бэлтгэх, гэрэл зураг, дуу хураах, бичих, засварлах, тайлагнах, олон нийтэд ил болгох үйл ажиллагааг явуулагч этгээдийг ойлгоно.” гэж заасан. Мөн “Үйлчлэлд хамаарах этгээд” гэдэгт дээрх тодорхойлолтод заасан этгээдэд хяналт тавигч (supervisor),

	III. Сангийн яамны тогтоосон журмаар олон улсын терроризм гэж заагдсан бол IV. Террорист гэж заагдсан бол V. Террорист байгууллага гэж заагдсан бол	ажил олгогч(employer), толгой компани(parent company), охин компани(subsidiary), нэгдсэн компани(affiliate) хамааруулж ойлгоно гэж хуульчилсан, мөн тус ойлголтод хамааруулахгүй этгээд гэдгийг тодорхойлсон нь S.448 хуулийн төсөлтэй адил байна.
2) Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийн объект юу болохыг тодорхойлсон байдал	Хуулийн төслийн SEC. 8(6)-т “Хамгаалагдах мэдээлэл” (PROTECTED INFORMATION) гэдэгт, (A) Сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн “Үйлчлэлд хамаарах этгээд”-ээс нууцыг хамгаалах үүргийн амлалт эсхүл түүнийг зөвшөөрсөн зөвшөөрлийн үндсэн дээр олж авсан тэрхүү мэдээллийг өгсөн мэдээллийн эх сурвалжийг тогтоож болох мэдээлэл (B) Энэ хуулийн “Үйлчлэлд хамаарах этгээд”-ээс дараах хэлбэрээр олж авсан эсхүл боловсруулсан бүхий л төрлийн тэмдэглэл, харилцаа холбооны агуулга, бичиг баримт, мэдээлэл I. Сэтгүүл зүйн үйл ажиллагааны нэг хэсэг болох II. Тэмдэглэл, харилцаа холбооны агуулга, баримт бичиг, мэдээлэл нь нууц байна гэсэн амлалт эсхүл нууц байхыг зөвшөөрсөн байна.	Хуулийн төслийн SEC. 2-т “Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл” (COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) гэсэн зохицуулалтыг тусгасан. Хуулийн төсөлд “энэ хуулийн “Үйлчлэлд хамаарах этгээдээс сэтгүүл зүйн үйл ажиллагааны(journalism) хүрээнд тухайн этгээд олж авсан эсхүл боловсруулсан мэдээлэлтэй холбоотойгоор гэрчийн мэдүүлэг авах (provide testimony) эсхүл ямар нэгэн тайлбар гаргуулж авахыг (produce any document) албадаж болохгүй” гэж заасан. Мөн хуулийн төслийн SEC. 4(5)-д “сэтгүүл зүйн үйл ажиллагаа = journalism” гэдгийг “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэдэг нь бүс нутаг, үндэсний эсхүл олон улсад өрнөсөн зүйл болон бусад олон нийтийн сонирхолд хамаарах мэдээ эсхүл мэдээллийг олж авах, бэлтгэх, цуглуулах, гэрэл зураг болгох, дүрс бичлэг болгох, бичих, засварлах, тайлагнах, хэвлэн түгээхийг ойлгоно гэж заасан.
3) Гэрчийн мэдүүлэг	Хуулийн төслийн SEC. 2(a)-т	Хуулийн төслийн SEC. 2(a)-т

өгөхөөс татгалзах эрх үйлчлэх эсэхийг тогтоох тухай	“Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл” (COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) гэдэгт албадлага ашиглан ил болгох урьдчилсан нөхцөлийг дараах байдлаар тусгасан. Үүнд, 1) Гэрчийн мэдүүлэг эсхүл ямар нэгэн тайлбар гаргуулж авах ажиллагаанд албадлага хэрэглэж буй этгээд нь тэрхүү гэрчийн мэдүүлэг эсхүл ямар нэгэн тайлбар баримт гаргуулахад дүйцэх мэдээллийн эх сурвалжийг бүгдийг ашигласан боловч тухайн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх эдлэх этгээдээс өөр бусад этгээд байхгүй бол 2) Гэмт хэргийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын хяналтын шатанд Үйлчлэлд хамаарах этгээдээс бусад этгээдээс олж авсан мэдээлэл нь: I. Гэмт хэрэг нэгэнт үйлдэгдсэн гэж итгэж болох үндэслэл бүрдсэн бол II. Тухайн албадлага шаардагдаж буй гэрчийн мэдүүлэг, ямар нэгэн тайлбар баримт нь хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын хяналт эсхүл прокурорын эсрэг гаргах эсэргүүцэлд	“Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл” (COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) гэж тусгасан ба S.448 хуулийн төсөлтэй агуулгын хувьд ижил байх тул товчлов.
--	--	--

	зайлшгүй шаардлагатай бол III. Нууцад хамаарах мэдээлэл эсхүл тэрхүү мэдээлэлд хандах эрхгүй этгээд зөвшөөрөлгүйгээр ил болгосон бол эрүүгийн хэргийн хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын шатанд тэрхүү зөвшөөрөлгүй ил болгосон үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдалд үлэмж хэмжээний хохирол учруулах эрсдэл үүсгэсэн эсхүл үүсгэх боломжтой бол IV. Албадлагаар ил болгосны дүнд үүсэх нийтийн ашиг сонирхол болон мэдээ олж авах, мэдээллийг чөлөөтэй дамжуулахыг дэмжсэний үр дүнд үүсэх нийтийн ашиг сонирхол хоёрыг харгалзан үзэж, тэрхүү мэдээллийг ил болгохгүй байх нь нийтийн ашиг сонирхолд харшилна гэж үзсэн бол Мөн хуулийн төсөлд зааснаар Холбооны Улсын Шүүхээс албадлага ашиглан эх сурвалжийг ил болгох тухайд тэрхүү гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх бүхий этгээдэд урьдчилан мэдэгдэх сонсгох зарчим хэрэгжүүлсний дараа, зөвхөн Холбооны Шүүхийн нотлох баримт үндэслэн шийдвэрлэхээр заасан.	
4) Гэрчийн мэдүүлэг	Хуулийн төслийн “Гэмт хэрэг эсхүл хууль бус үйл	Хуулийн төслийн SEC. 2(a)-т

өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байх тохиолдол	ажиллагааны дүнд олж авсан мэдээлэл=SEC. 3. EXCEPTION RELATING TO CRIMINAL OR TORTIOUS CONDUCT”, “Хүн алах, барьцаалах эсхүл хүний биед хүнд гэмтэл учруулах, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, хор хохирлыг багасгахад шаардлагатай мэдээлэл = SEC. 4. EXCEPTION TO PREVENT DEATH, KIDNAPPING, OR SUBSTANTIAL BODILY INJURY” , “Террорист үйл ажиллагаа эсхүл Үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаас сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх мэдээлэл= SEC. 5. EXCEPTION TO PREVENT TERRORIST ACTIVITY OR HARM TO THE NATIONAL SECURITY”-ыг тус тус хуулийн төсөлд заажээ.	“Үйлчлэлд хамаарах этгээдээс ил болгохыг албадах мэдээлэл” (COMPELLED DISCLOSURE FROM COVERED PERSONS) гэсний 3 дахь заалтад “гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байх тохиолдол”-ыг заажээ. Ингэхдээ S.448 хуулийн төсөлд заасан гурван үндсэн тохиолдлоос гадна, • Холбогдох хуульд заасан байгууллагын нууцад хамаарах мэдээлэл • Холбогдох хуульд заасан хувь хүний нууцад хамаарах мэдээлэл • Холбогдох хуульд заасан хэрэглэгчийн ашиг сонирхлын нэхэмжлэл гаргаж болох мэдээллийг ил болгосон мэдээлэл • Улсын аюулгүй байдалд харшлах,эсхүл олгогдсон зөвшөөрөлгүйгээр мэдээллийн нууцыг задруулсан гэмт хэрэгтэй холбоотой хийгдэх хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт, прокурорын шатанд тухайн мэдээлэл задруулсан этгээдийг олж тогтооход шаардлагатай мэдээллийг гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байх тохиолдолд хамааруулсан байна.
--	---	---

3) Австралийн Холбооны Улс

Австралийн Холбооны Улсын хувьд 2021 оны судалгаанд дурдсанаар “сэтгүүлч”(journalist), “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” (journalism) гэдгийг хууль зүйн үүднээс хэрхэн тодорхойлох тухай асуудал нь эрдэмтэн судлаач болон сэтгүүл зүй үйл ажиллагаа эрхлэгч нарын хувьд ч хүндрэлтэй асуудал байдаг болохыг

тэмдэглэж, улмаар “сэтгүүлч”(journalist) гэдгийг 16 хуульд, “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” (journalism) гэснийг 1 хуульд тус тус тодорхойлсон байдаг болохыг тэмдэглэжээ.¹⁶ Эдгээр хуулийн тодорхойлолт ихэвчлэн сэтгүүл зүйн үйл ажиллагааны эх сурвалжийг хамгаалах гэсэн шүгэл үлээгчийг хамгаалах (whistleblower protection) эсхүл бамбай хуулийн дагуу нотлох баримтыг хамгаалах (evidentiary shield laws) гэсэн нэртэй хуульд байх нь түгээмэл. Тэдгээр хуульд 17 удаа тодорхойлогдсон “сэтгүүлч” эсхүл “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэсэн хуулийн тодорхойлолтыг дараах 6 төрөлд хуваан төрөлжүүлэх боломжтой. Доорх хүснэгтийг үзнэ үү.¹⁷

	Төрөл	Хуульд заагдсан тайлбар
1.	Түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн тайлбар (Leading Definition)	• “Сэтгүүлч” гэдэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл нийтлэхтэй холбоотой сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхлэх ажил, албан тушаал эсхүл мэргэжилтэн байх хүнийг ойлгоно.¹⁸ • “Сэтгүүлч” гэдэгт хэвлэмэл бүтээл бэлтгэх хэрэгсэл эсхүл цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэх зорилгоор бичсэн бүтээлийн бичиглэл эсхүл редактор хийх үйл ажиллагаанд хамаарах хүнийг ойлгоно.¹⁹ • Жишээлбэл, дээр дурдсан түгээмэл хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн тодорхойлолтыг New South Wales, Western Australia, South Australia болон Queensland дахь шүгэл үлээгчийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулсан “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль” (Public Interest Disclosure Act) болон New South Wales, Victoria, Western Australia, South Australia дахь нотлох баримттай холбоотой харилцааг зохицуулсан бамбай хуульд тус тус зааж өгчээ.²⁰
2.	Үе шатад суурилсан тайлбар (Process-Based Definition)	• “Сэтгүүлч” гэдэгт олон нийтийн сонирхолд хамаарах асуудлаар шинэ эсхүл анхаарвал зохих мэдээллийг олж авч, дараах аргаар мэдээллийг захиран зарцуулж буй хүнийг ойлгоно. Үүнд, а) Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгөхийн тулд мэдээллийг бэлтгэх, эсхүл

¹⁶ Dominic Frost. “Who is a journalist? the legal definitions” Press Freedom Policy Papers Background Briefing 1/2021:3-4. <https://law.uq.edu.au/files/79263/who-is-a-journalist.pdf>

¹⁷ Энэхүү хүснэгтийг өмнөх эшлэлд дурдсан эх сурвалжийг судалсны үндсэн дээр боловсруулсан болно.

¹⁸ Journalist means a person engaged in the profession or occupation of journalism in connection with the publication of information in a news medium.

¹⁹ Journalist means a person engaged in the occupation of writing or editing material intended for publication in the print or electronic news media.

²⁰ Жишээлбэл, Queensland -ийн “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль” (Public Interest Disclosure Act) s 20(4)-т (journalist means a person engaged in the occupation of writing or editing material intended for publication in the print or electronic news media.) гэж хуульчилжээ. Дэлгэрүүлж үзэх, <https://www.legislation.qld.gov.au/view/html/inforce/current/act-2010-038#sec.20>

		b) Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өгөхийн тулд мэдээллийн анализ хийх, санал, засварыг хийх²¹ Дээрх хуулийн тодорхойлолтыг Northern Territory-ийн EVIDENCE (NATIONAL UNIFORM LEGISLATION) ACT 2011-ийн s 127 А-д заасан байдаг.²²
3.	Хураангуй тайлбар (Concise Definition)	“Сэтгүүлч” гэдэгт мэдээг түгээхтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэгч хүнийг ойлгохоос гадна мэдээлэл өгсөн этгээдийн зүгээс тэрхүү мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлүүлэх магадлалтай гэж үзсэн итгэлийн үндсэн дээр тухайн мэдээллээ өгсөн хүнийг ойлгоно.²³ - Дээрх хуулийн тодорхойлолтыг Evidence Act 1995-ийн s 126 J(1) -д заасан байдаг²⁴ бөгөөд “сэтгүүлч” гэдэгт ойлгох хамаарах хүрээг өргөжүүлж өгчээ.
4.	Материалд суурилсан тайлбар (Material-Based Definition)	“Сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэдэгт олон нийтэд ил болгох зорилгоор дараах материалыг цуглуулах, түгээх бэлтгэл хийх, эсхүл түгээхийг ойлгоно. Үүнд, а) Мэдээ эсхүл цаг үеийн шинжтэй асуудлыг агуулсан материал б) Мэдээ эсхүл цаг үеийн шинжтэй асуудлын талаарх анализ, санаа бодол, дүн шинжилгээ бүхий тайлбар зэргийг багтаасан материал²⁵ - Хуулийн дээрх тодорхойлолт “Сэтгүүл зүйн үйл ажиллагаа” буюу Journalism гэдгийг Австралийн Холбооны Улсад хуульчилсан ганц тохиолдол бөгөөд s 235 of Victoria’s Police Act 2013-ийн s 235 дахь хэсгээс үзэх боломжтой.²⁶

²¹ Journalist means a person who obtains new or noteworthy information about matters of public interest; and deals with the information by: a. preparing the information for a news medium; or b. providing comment, opinion or analysis of the information for a news medium.

²² Тус хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legislation.nt.gov.au/en/Legislation/EVIDENCE-NATIONAL-UNIFORM-LEGISLATION-ACT-2011>

²³ Journalist means a person who is engaged and active in the publication of news and who may be given information by an informant in the expectation that the information may be published in a news medium.

²⁴ 126J Definitions (1) In this Division: informant means a person who gives information to a journalist in the normal course of the journalist’s work in the expectation that the information may be published in a news medium. journalist means a person who is engaged and active in the publication of news and who may be given information by an informant in the expectation that the information may be published in a news medium. news medium means any medium for the dissemination to the public or a section of the public of news and observations on news. Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://www.legislation.gov.au/C2004A04858/2016-05-01/text>

²⁵ Journalism is the practice of collecting, preparing for dissemination or disseminating any of the following material for the purpose of making it available to the public— a. material having the character of news or current affairs; b. material consisting of commentary or opinion on or analysis of news or current affairs;

²⁶ VICTORIA POLICE ACT 2013 (NO. 81 OF 2013) - SECT 235 Definitions (1) In this Division—“journalism” means the practice of collecting, preparing for dissemination or disseminating any of the following material for the purpose of making it available to the public— (a) material having the character of news or current affairs; (b) material consisting of commentary or opinion on or analysis of news or current affairs; Тус хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, https://www5.austlii.edu.au/au/legis/vic/num_act/vpa201381o2013210/s235.html

5.	Үйл ажиллагаанд суурилсан тайлбар (Activity-Based Definition)	“Сэтгүүлч” гэдэгт мэдээ, цаг үеийн шинжтэй асуудал, мэдээлэл эсхүл баримтат шинжийг агуулах мэдээллийг түгээх зорилгоор сурвалжлага хийх, гэрэл зурагт буулгах, засварлах эсхүл бичлэг болгон хураан авах ажил мэргэжлийн үйл ажиллагаа эсвэл практикт хэрэгжүүлдэг хүнийг ойлгоно.²⁷ - Дээрх тодорхойлолтыг NSW Court Security Act 2005 s 4²⁸ болон The Federal Broadcasting Service Act 1992 s 202(5)²⁹ дахь хэсгээс тус тус үзэх боломжтой.
6.	Бүтэц зохион байгуулалтад суурилсан тайлбар (Organisation-Based Definition)	“Сэтгүүлч” гэдэгт дараах хүнийг ойлгоно. Үүнд, a) мэдээ, цаг үеийн шинжтэй асуудал, мэдээлэл эсхүл баримтат шинжийг агуулах мэдээллийг түгээх зорилгоор сурвалжлага хийх, гэрэл зурагт буулгах, засварлах эсхүл бичлэг болгон хураан авах ажил мэргэжлийн үйл ажиллагаа эсвэл практикт хэрэгжүүлдэг хүнийг ойлгоно b) Түүнийг ажил мэргэжлийн үйл ажиллагаа эсхүл практикт хэрэгжүүлэгч хүн эсхүл нэгдлийг ойлгоно. Үүнд, I. Ёс зүйн журам болон Australian Press Council эсхүл эрх олгогдсон хүн эсхүл нэгдлээс тухайн ажил мэргэжлийн үйл ажиллагаа эсвэл практикт түүнийг хэрэгжүүлдэг хүний талаарх гомдлыг хянан хэлэлцэх үйл ажиллагаа эрхлэгч II. Австралийн Холбооны Улсын Broadcasting Services Act 1992-д заасны дагуу тусгай зөвшөөрлийг эзэмшигч³⁰

²⁷ Journalist means a person engaged in the profession or practice of reporting, photographing, editing or recording for a media report of a news, current affairs, information or documentary character.

²⁸ 4 Definitions (1) In this Act— journalist means a person engaged in the profession or practice of reporting, photographing, editing or recording for a media report of a news, current affairs, information or documentary character. Тус хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://legislation.nsw.gov.au/view/whole/html/inforce/current/act-2005-001>

²⁹ (5) For the purposes of this section, journalist means a person engaged in the profession or practice of reporting for, photographing, editing, recording or making: (a) television or radio programs; or (b) datacasting content; of a news, current affairs, information or documentary character. Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, https://classic.austlii.edu.au/au/legis/cth/consol_act/bsa1992214/s202.html

³⁰ Journalist means a person who –

a. is engaged in the profession or practice of reporting, photographing, editing or recording for a media report of a news, current affairs, information or documentary nature;

b. is paid to perform that profession or practice by a person, or body, that –

i. is subject to a code of ethics and a procedure for the Australian Press Council, or for another person or body that is prescribed, to deal with complaints about persons engaging in such a profession or practice; or

ii. is the holder of a licence under the Broadcasting Services Act 1992 of the Commonwealth.

	Дээрх тодорхойлолтыг Tasmanian Right to Information Act 2009 s 5(1)³¹ болон Court Security Act 2017 s 3³² дахь хэсэгт заасан байх бөгөөд “сэтгүүлч” гэдэгт тухайлсан зохион байгуулалт бүтэц бүхий нэгжид мэргэжилтний хувьд харьяалагдсан байхыг шаарддаг байна.
--	---

2.3. Дүгнэлт

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн хэм хэмжээг судалж үзвэл хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан (сэтгүүлч)-ы мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрх, улмаар гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчилж хамгаалаагүй байна. Харьцуулсан эрх зүйн судалгааны дүнд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг баталгаатай эдлүүлэх нь хэвлэл мэдээллийн олон нийтийн байх шинж, тодруулбал ардчилсан ёс, эрх чөлөөт нийгмийн баталгаа болох гэсэн шинж байдагтай холбон тайлбарлагддаг байна.

Гэхдээ хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны мэдээллийн эх сурвалжийг нууцлах, ялангуяа гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг холбогдох хуульд тусгайлан хуульчлах нь дан ганцхан эерэг үр дагавартай бус сөрөг үр дагавартай байж болохыг анхаарах шаардлагатай. Тодруулбал, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтны гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчлах нь 1) Шударга, тэгш шүүхийн үйл ажиллагаатай сөргөлдөх; 2) Хууль бусаар мэдээллийг задруулсан этгээдийн хамгаалах хэрэгсэл болох; 3) Хууль тогтоогч сэтгүүлч гэж хэн болохыг тогтоох эрхийг эдлэх зэрэг сөрөг үр дагавар дагуулах эрсдэлтэй байдаг ажээ.

Япон Улсад сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх хуулиар тодорхой хуульчилж баталгаажгаагүй байна. Харин АНУ-д зарим муж улсад сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжийг нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг хуульчилж өгсөн байдаг боловч Холбооны Улсын хэмжээнд хууль байхгүй байна. Иймд, 2009 онд АНУ-ын Конгрессын дээд танхим болон доод танхимаас “Мэдээллийн чөлөөтэй урсгалтын тухай хуулийн төсөл=Free Flow of Information Act of 2009” боловсруулсан байдаг бөгөөд хуулийн төсөлд дараах ач холбогдол бүхий харилцааг зохицуулсан байдаг. Үүнд,

1) Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх бүхий субъект гэж хэнийг ойлгох вэ гэдгийг хуулийн төслийн нэр томьёо хэсэгт “covered person” гэж хэнийг ойлгох талаар тусгаж өгсөн. Ингэхдээ хоёр хуулийн төсөлд аль аль нь дан ганцхан сэтгүүл зүйн үйл ажиллагаа явуулж

³¹ 5. Interpretation (1) In this Act, unless the contrary intention appears – journalist means a person who – (a) is engaged in the profession or practice of reporting, photographing, editing or recording for a media report of a news, current affairs, information or documentary nature; and (b) is paid to perform that profession or practice by a person, or body, that – (i) is subject to a code of ethics and a procedure for the Australian Press Council, or for another person or body that is prescribed, to deal with complaints about persons engaging in such a profession or practice; or (ii) is the holder of a licence under the Broadcasting Services Act 1992 of the Commonwealth; Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://www.legislation.tas.gov.au/view/whole/html/inforce/current/act-2009-070>

³² Өмнөх эшлэлд оруулсантай адил хуулийн тодорхойлолтыг тусгажээ. Хуулийг дэлгэрүүлж үзэх холбоос, <https://www.legislation.tas.gov.au/view/whole/pdf/authorised/2023-09-21%202023-09-22/act-2017-034>

буй этгээд (means a person who is engaged in journalism) гэдгээр хязгаарлагдахгүйгээр тухайн этгээдэд хяналт тавигч (supervisor), ажил олгогч(employer), толгой компани(parent company), охин компани(subsidiary), нэгдсэн компани(affiliate) хамааруулж ойлгохоор тусгасан нийтлэг талтай. Харин Н.Р.985 хуулийн төсөлд “Үйлчлэлд хамаарах этгээд” (Covered person) гэдгийг тодорхойлохдоо “тухайн этгээдийн амьжиргааны чухал бүрэлдэхүүн хэсэг эсхүл санхүүгийн чухал бүрэлдэхүүн хэсгийг олж авахын тулд” үйл ажиллагаа явуулж буй этгээдийг хамааруулж ойлгохоор тусгасан.

2) Мөн хоёр хуулийн төсөлд “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” буюу “journalism” гэдгийг нэр томъёоны тайлбарт тусгасан. Хуулийн төсөлд зааснаар “journalism” гэдэгт бүс нутаг, үндэсний эсхүл олон улсад өрнөсөн зүйл болон бусад олон нийтийн сонирхолд хамаарах мэдээ эсхүл мэдээллийг олж авах, бэлтгэх, цуглуулах, гэрэл зураг болгох, дүрс бичлэг болгох, бичих, засварлах, тайлагнах, хэвлэн түгээхийг ойлгоно гэж заасан.

3) Хоёр хуулийн төсөлд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийн объект юу болох талаар дараах заалт тусгагдсан. Тухайлбал, хуулийн төсөлд “Хамгаалагдах мэдээлэл” (PROTECTED INFORMATION) гэдэгт, (A) Сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд энэ хуулийн “Үйлчлэлд хамаарах этгээд”-ээс нууцыг хамгаалах үүргийн амлалт эсхүл түүнийг зөвшөөрсөн зөвшөөрлийн үндсэн дээр олж авсан тэрхүү мэдээллийг өгсөн мэдээллийн эх сурвалжийг тогтоож болох мэдээлэл; (B) Энэ хуулийн “Үйлчлэлд хамаарах этгээд”-ээс дараах хэлбэрээр олж авсан эсхүл боловсруулсан бүхий л төрлийн тэмдэглэл, харилцаа холбооны агуулга, бичиг баримт, мэдээлэл: а)Сэтгүүл зүйн үйл ажиллагааны нэг хэсэг болох, б) Тэмдэглэл, харилцаа холбооны агуулга, баримт бичиг, мэдээлэл нь нууц байна гэсэн амлалт эсхүл нууц байхыг зөвшөөрсөн байна гэсэн мэдээлэл хамаарахаар тусгасан.

4) Хуулийн төсөлд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэх эсэхийг тогтоох урьдчилсан нөхцөлийг дараах байдлаар тусгасан. Тухайлбал, гэрчийн мэдүүлэг эсхүл ямар нэгэн тайлбар гаргуулж авах ажиллагаанд албадлага хэрэглэж буй этгээд нь тэрхүү гэрчийн мэдүүлэг эсхүл ямар нэгэн тайлбар баримт гаргуулахад чиглэсэн бүхий л арга хэмжээг ашигласан боловч тухайн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх эдлэх этгээдээс өөр бусад этгээд байхгүй гэсэн урьдчилсан нөхцөл хангагдах ёстой. Мөн тухайн тохиолдолд Холбооны Улсын шүүхээс гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэх эсэх талаарх шийдвэрийг гаргаж, урьдчилан тухайн гэрчийн мэдүүлэг өгөх этгээдэд мэдэгдэж, сонсгосон байх талаар хуулийн төсөлд заажээ.

5) Төгсгөлд нь хуулийн гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байх тохиолдол гэдэгт дараах харилцаа хамаарахаар хуульчилсан байна. Үүнд,

- Гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагааны үр дүнд олж авсан мэдээлэл
- Хүн алах, барьцаалах эсхүл хүний биед хүнд гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийх, хор хохирлыг багасгахад шаардлагатай мэдээлэл
- Террорист үйл ажиллагаа эсхүл Үндэсний аюулгүй байдалд хохирол үүсэхээс сэргийлэхэд туслалцаа болох мэдээлэл
- Холбогдох бусад хуульд заасан тусгай тохиолдол гэж хуульчилжээ. Үүнээс дүгнэвэл, хуулийн төсөлд хууль бусаар мэдээлэл задруулсан этгээдийг олж

тогтоохын тулд гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхийг үгүйсгэх, зөвшөөрөхгүй байх тохиолдол хуулийн төсөлд тусгалаа олсон байдаг.

Энэхүү судалгааны төгсгөлд, Монгол Улсын хувьд “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг боловсруулахдаа “Сэтгүүлчийн эх сурвалж нууцлах эрх”, “Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх”-ийг хуульчлах тохиолдолд дараах зүйлсийг анхаарах нь зүйтэй. Үүнд,

- “Эх сурвалж нууцлах эрх”, “Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх”-ийг эдлэх субъект болох “Сэтгүүлч” гэдэгт хэнийг хамааруулж ойлгохыг хуулийн нэр томъёоны хэсэгт оруулах шаардлагатай. Ингэхдээ “сэтгүүлч” гэсэн нэр томъёог тайлбарлахаас илүүтэй “Энэ хуульд заасан мэдээллийн эх сурвалжийг нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх бүхий этгээд” гэж хэнийг ойлгох вэ гэдгийг тодорхойлж өгөх нь зүйтэй.
- “Мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрх”, “Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх”-ийг ямар урьдчилсан нөхцөл хангагдсан тохиолдолд хэн гэдэг субъектын зөвшөөрөлтэйгөөр тэрхүү эх сурвалжийг нууцлах эрхийг ил болгох, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй гэж шийдвэрлэх талаар хуулийн төсөлд тодорхой тусгах ёстой. АНУ-ын жишээнээс үзвэл, тэрхүү мэдээллийн эх сурвалжийг олж болох бүхий л арга хэмжээг хэрэглэсэн байх гэсэн урьдчилсан нөхцөл хангагдахаас гадна Холбооны Улсын Шүүхийн зөвшөөрөлтэйгөөр мэдээллийн эх сурвалжийг албадан ил болгох, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх үйлчлэхгүй болохыг тогтоодог байна.
- “Эх сурвалж нууцлах эрх”, “Гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх”-ийг хуулийн төсөлд тусгахдаа огт хязгааргүйгээр хуульчлах нь оновчгүй. Тухайлбал, гэмт хэрэг эсхүл хууль бус үйл ажиллагааны үр дүнд олж авсан мэдээлэл байгаа бол; хүн алах, барьцаалах эсхүл хүний биед хүнд гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх, түүнээс зайлсхийх, хор хохирлыг багасгахад шаардлагатай мэдээлэл байгаа бол; террорист үйл ажиллагаа эсхүл Үндэсний аюулгүй байдалд хохирол үүсэхээс сэргийлэхэд туслалцаа болох мэдээлэл байгаа бол эх сурвалжаа нууцлах, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх огт үйлчлэхгүй байхаар АНУ-ын холбогдох хуулийн төсөлд заасан болохыг анхаарах нь зүйтэй.

ГУРАВ. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ АСУУДАЛ

Боловсруулсан: МУИС, ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхим,
Багш О.Дарханболд (LL.M)

3.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний норматив суурь

Хэвлэл мэдээллийн хараат бус байдал нь ардчилсан нийгмийн үндэс бөгөөд нийгэм дэх аливаа мэдээллийн урсгалын чөлөөт байдлыг бий болгож, төрийн эрх мэдлийн зүй бус үйлдлийг хянах үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь олон улсын болон бүс нутгийн эрх зүйн эх сурвалжид хүний үндсэн эрх болох үг хэлэх эрх чөлөөний агуулгаар хамгаалагдсан. Үүнээс **Хүний эрхийн түгээмэл тунхаглал (UDHR)** болон **Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ICCPR)-ын дурдаж болно**. Эдгээр нь үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хүн бүрт хамаатай эрх болгон баталгаажуулсан байдаг.¹

Тодруулбал, **Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19-р зүйлд** “хүн бүр үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй” гэж тодорхойлсон. Энэхүү заалт нь хувь хүн төдийгүй хэвлэл мэдээллийн байгууллагууд нь чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харуулж байна. **Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт** нь гишүүн орнуудыг үг хэлэх эрх чөлөөг хамгаалж, цензурээс сэргийлэх үүрэг хүлээлгэж, хууль зүйн зохицуулалт хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалахад чиглэгдэх ёстойг тодотгодог. Эдгээр эрх зүйн баримт бичгүүд нь улсын хэмжээнд хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дэмжих хуулиудыг батлахад ихээхэн ач холбогдолтой бөгөөд үүнийг өөрийн улсын эрх зүйн тогтолцоотой хослуулан ашиглах боломжтой болохыг илэрхийлдэг байна.²

Мөн эдгээр баримт бичгүүд нь гишүүн орнуудын үндэсний эрх зүйн орчныг олон улсын стандарттай нийцүүлэхэд уриалсан **норматив суурийг** бий болгодог байна. Энэ нь улс орнуудад өөрийн нийгмийн болон улс төрийн орчинд тохирсон эрх зүйн орчны хосолмол механизмыг бий болгох боломжийг олгодог. Тухайлбал, дурдсан норматив суурь болсон олон улсын эрх зүйн эх сурвалжид тулгуурлан улс орнууд хэвлэл мэдээллийн салбар дахь ёс зүйн стандартыг сахих, төрийн оролцоог багасгахад чиглэсэн бие даасан өөрийн удирдлагын байгууллагуудыг хөгжүүлж болно. Эдгээр өөрийн удирдлагын механизмууд нь хэвлэл мэдээллийн салбар дахь ёс зүйн хариуцлагыг дэмжиж, сэтгүүлчдэд үүргээ хариуцлагатай, ил тод гүйцэтгэх боломжийг олгодог.³

¹ United Nations General Assembly, *Universal Declaration of Human Rights*, 1948, Article 19; United Nations, *International Covenant on Civil and Political Rights*, 1966

² United Nations General Assembly, *Universal Declaration of Human Rights*, 1948, Article 19; United Nations, *International Covenant on Civil and Political Rights*, 1966; European Court of Human Rights, *Case Law on Freedom of Expression*, Strasbourg.

³ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; Ruggie, John Gerard, "International Norms in Human Rights and Press Freedom," *Journal of Human Rights*, 2017.

Ийнхүү олон улсын эрх зүйн эх сурвалж нь ардчилсан орнуудын хэвлэл мэдээллийн эрх зүйн орчны суурь болж буйг харж болно. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлсэн орнууд нь ихэвчлэн **олон ургальч, хараат бус хэвлэл мэдээллийн орчныг** бүрдүүлэх боломжийг бий болгодог. Эрх зүйн хамгаалалт нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад нийгмийн болон төрийн асуудлыг айдасгүйгээр мөрдөн шалгаж, мэдээлэх боломжийг олгох юм. **Европын Зөвлөл** болон **OSCE**-ийн удирдамжийн дагуу байгуулагдсан бие даасан хэвлэлийн зөвлөлүүд нь үүний жишээ юм. Эдгээр зөвлөлүүд нь төрөөс хараат бус ажилладаг бөгөөд төрөөс нөлөөлөх цензурын эрсдэлгүйгээр хэвлэл мэдээллийн салбар ажиллаж нийгмийн өмнө хариуцлагатай байхад дэмжлэг үзүүлдэг.⁴

UNESCO зэрэг олон улсын байгууллагууд мөн эдгээр үндсэн эрхийг дэмжихэд томоохон үүрэг гүйцэтгэж, тогтмол үнэлгээ хийж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих зөвлөмж гаргадаг. UNESCO-ийн **Дэлхийн хэвлэл мэдээллийн эрх чөлөө ба хөгжлийн чиг хандлага** тайлан нь улс орнуудад хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоог дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэхийг уриалдаг. Энэхүү уриалга нь улс орнуудад дэлхий нийтийн стандарттай нийцсэн үнэт зүйлс болон эрх зүйн уламжлалыг хүндэтгэсэн, уян хатан орчин бүрдүүлэхийг дэмждэг. Энэ нь зөвхөн ардчиллын үнэт зүйлсийг баталгаажуулаад зогсохгүй, хэвлэл мэдээллийн салбарт итгэл хүлээлгэдэг байна.⁵

Эдгээр олон улсын эрх зүйн эх сурвалж, уриалга үнэлэлт, дүгнэлтийг хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд холбогдох үндсэн эх сурвалжийн нэг гэж үзэж болох бөгөөд энэ нь төрийн зүй бус ашиг сонирхлоос ангид байлгах зарчмыг тогтоосон. Үүнд тулгуурлан эрх зүйн хамгаалалтыг улс орнууд хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоотой хослуулснаар хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дэмжих орчныг бүрдүүлэх боломжтой бөгөөд ардчилал, төрийн ил тод байдлыг хангах үндэс болдог байна.⁶

3.2. Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны үүсэл, хөгжил

Олон улсын эрх зүйн эх сурвалжууд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд холбогдох норматив суурийг тогтоож өгснөөр улс орон бүр үүний хэрэгжилтийг хангах арга замыг эрэлхийлсээр ирсэн. Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны үүсэл, хөгжлийг түүхэн талаас нь авч үзвэл хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, ёс зүйн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн төрийн шууд удирдлагаас ангид байдлыг дэмжих хандлагатай байсныг харуулдаг.⁷ Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоо нь ихэвчлэн төрийн зүй бус үйлдлийн эрсдэлээс сэргийлж бий болсон байдаг бөгөөд хэвлэл мэдээллийн

⁴ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; Ruggie, John Gerard, "International Norms in Human Rights and Press Freedom," *Journal of Human Rights*, 2017.

⁵ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; "Promoting Press Freedom in Democratic Societies," *UNESCO Policy Brief*, 2021.

⁶ Organization for Security and Co-operation in Europe (OSCE), *Guidelines on Media Freedom*, 2018; Council of Europe, *Committee of Ministers Recommendations*, Strasbourg, 2019; United Nations Human Rights Council, "Protection of Journalists and Freedom of the Press," *UNHRC Resolution*, 2021.

⁷ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2021; European Union Agency for Fundamental Rights, *Freedom of Expression and Information: Press Regulation Overview*, 2020.

байгууллагуудын хараат бус байдлыг хангахад ихээхэн ач холбогдолтой юм.⁸ Судалгааны энэхүү хэсэгт хэвлэл мэдээллийн ёс зүйг сахих, олон нийтийн итгэлийг хадгалах зорилготой хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоо үүсэн хөгжсөн түүхийг улс орнуудын жишээгээр тайлбарлах болно.

1) Швед

Шведийн Хэвлэлийн Зөвлөл нь 1916 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны хамгийн анхны жишээнүүдийн нэг юм. Анх үүсэхдээ энэ зөвлөл нь хэвлэл мэдээллийн салбарт үүссэн зөрчлүүд, тухайлбал нийтлэгчид болон редакторуудын хооронд мэдээний агуулга, илэрхийлэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэх зорилготой байв.⁹ Энэ нь Шведийн олон зууны уламжлал болсон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хадгалах соёлыг илэрхийлж байгаа бөгөөд үүнд 1766 оны Хэвлэл Мэдээллийн Эрх Чөлөөний Тухай Хууль чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.¹⁰

Цаг хугацааны явцад хэвлэл мэдээллийн салбар болон сэтгүүл зүй өөрчлөгдөхийн хэрээр Шведийн Хэвлэлийн Зөвлөлийн үүрэг өргөжиж, олон нийтийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх болжээ. Эхний жилүүдэд зөвлөл нь зөвхөн салбар дахь дотоодын маргаантай холбоотой асуудлуудыг хянан шийдвэрлэхэд төвлөрч байсан бөгөөд олон нийтээс ирсэн гомдол бага байсан тул гомдол гаргагчид ихээхэн хэмжээний төлбөр төлөх шаардлагатай байжээ. Энэхүү төлбөр нь зөвхөн ноцтой асуудлуудыг хүлээн авч, хөнгөн гомдлыг багасгах зорилготой байсан.¹¹

Гэвч 1960-аад он гэхэд хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд хууль зүйн хязгаарлалт тогтоох асуудал нийгэмд ихээхэн шүүмжлэл дагуулж, улмаар 1969 онд томоохон шинэчлэлтүүд хийгдсэн байна. Эдгээр шинэчлэлийн хүрээнд зөвлөл нь гомдлын төлбөрийг цуцалж, олон нийт ямар нэгэн санхүүгийн ачаалалгүйгээр гомдол гаргах боломжтой болсон. Мөн олон нийтийн өмнөөс гомдол хүлээн авч, судлах үүрэгтэй Хэвлэлийн Омбудсманы албан тушаалыг бий болгосон.¹² Хэвлэлийн Омбудсман нь олон нийт болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хооронд гүүр болох үүрэгтэй байсан ба гомдлыг шударгаар шийдвэрлэх баталгаа болсон. Түүнчлэн зөвлөлд олон нийтийг төлөөлөх хэвлэл мэдээллийн бус гишүүд нэмэгдэж, хэвлэл мэдээллийн ёс зүйн асуудалд илүү өргөн хүрээнд хандаж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлсэн байна.¹³

Эдгээр шинэчлэлтүүд нь Шведийн хэвлэл мэдээллийн салбарт төрийн оролцоогүйгээр асуудлыг шийдвэрлэх, өөрийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх чиглэлийн чухал алхам болсон. Шведийн хэвлэл мэдээллийн байгууллагууд болон редакторууд асуудлыг тэр бүр

⁸ "Origins and Evolution of Media Self-Regulation Systems," *International Media Development Journal*, 2021; Council of Europe, *Recommendation CM/Rec(2011)7 on a New Notion of Media*, Strasbourg, 2011.

⁹ "The Origins of Press Freedom in Sweden," *International Journal of Press Regulation Studies*, 2019.

¹⁰ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; Council of Europe, *Recommendation CM/Rec(2011)7 on a New Notion of Media*, Strasbourg, 2011.

¹¹ "Press Council Reforms and Public Complaints: The Swedish Case," *European Journal of Media Ethics*, 2020.

¹² Role of the Press Ombudsman in Sweden's Media Regulation," *Journal of Media and Communication Law*, 2018.

¹³ Organization for Security and Co-operation in Europe (OSCE), *Guidelines on Media Freedom and Independence*, 2019; "Introduction of Public Members to the Swedish Press Council," *Journal of Public Trust and Media Ethics*, 2021.

хууль тогтоомжид түшиглэн шийдвэрлэхийн оронд дотоодын журмаар зохицуулахыг дэмжиж, ёс зүйн зөрчлийг өөрсдөө шийдвэрлэхийг илүүд үздэг.¹⁴ Шведийн Хэвлэлийн Зөвлөл нь ёс зүйн асуудлыг дотооддоо шийдвэрлэснээр олон нийтийн итгэлийг хадгалах, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах арга барилыг бататгасан байна.¹⁵

Өнөөг хүртэл Шведийн Хэвлэлийн Зөвлөл нь төрийн оролцоогүйгээр хэвлэл мэдээллийн ёс зүйг сахин ажиллаж, олон улсад хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын шилдэг жишээ болж байгаа бөгөөд ардчилсан нийгэмд олон нийтийн хүлээлтийг хангасан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хадгалж, ёс зүйн өндөр стандартыг сахихын чухлыг харуулж байна.¹⁶

2) ХБНГУ (Холбооны Бүгд Найрамдах Герман Улс)

Германы Хэвлэлийн Зөвлөл (Deutscher Presserat) нь Дэлхийн хоёрдугаар дайны дараах үед, цензурын эсрэг хамгаалалт болгон байгуулагдсан бөгөөд үг хэлэх эрх чөлөөг баталгаажуулах зорилготой байв. Дайны дараах Герман нь нацист дэглэмийн үед хатуу хязгаарлагдсан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг сэргээн хамгаалах шаардлагатай болсон юм.¹⁷ Тиймээс хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжихийн тулд Герман улс Их Британийн хэвлэлийн зөвлөлийн загварыг жишиг болгон авч, төрийн оролцоогүйгээр ёс зүйн зарчмуудыг тогтоон хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхийг зорьжээ.¹⁸

1956 онд сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хамтын хүчин чармайлтаар Хэвлэлийн Зөвлөл байгуулагдсан бөгөөд улсын хэмжээнд хэвлэл мэдээллийн салбарт нөлөөлөх хууль тогтоомж гаргах оролдлогын хариу арга хэмжээ байв.¹⁹ Зөвлөл нь ёс зүйн стандарт тогтоох, олон нийтийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн ёс зүйтэй, хариуцлагатай байдлыг сахин хамгаалах үүрэг хүлээсэн. Тус зөвлөлөөс боловсруулсан Германы Хэвлэлийн Стандарт нь үнэн зөв байдал, хувийн нууцлалыг хүндэтгэх, редакцын хариуцлага зэрэг зарчмуудыг тодорхойлсон бөгөөд эдгээр зарчмууд нь Германы сэтгүүл зүйд итгэх итгэл, мэргэжлийн ур чадварыг дэмжихэд чиглэсэн байна.²⁰

Гэвч 1980-аад оны эхэн үед Зөвлөлийн эрх мэдэлд саад учирсан үйл явдал болсон. Тодруулбал, *Kölner Express* гэх томоохон сонин нь зөвлөлөөс гаргасан шийдвэрийг

¹⁴ "Swedish Media's Commitment to Self-Governance," *Journal of Nordic Media Studies*, 2020; European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation and Self-Governance in EU Member States*, 2019.

¹⁵ Ruggie, John Gerard, "Human Rights and Normative Implications for Media," *Journal of Human Rights*, 2018; Council of Europe, *Committee of Ministers Recommendations*, Strasbourg, 2019.

¹⁶ UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; OSCE, *Best Practices in Media Self-Governance*, 2018.

¹⁷ "Freedom of the Press and Expression After World War II in Germany," *Journal of Post-War Media Studies*, 2018.

¹⁸ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2021; "UK and German Press Council Model Comparisons," *European Media Governance Journal*, 2019.

¹⁹ "Foundation of the German Press Council," *German Journal of Media Ethics*, 2020; Council of Europe, *Committee of Ministers Recommendations on Media Freedom*, Strasbourg, 2017.

²⁰ "German Press Code: Ethics and Standards," *Journal of Professional Journalism*, 2021; "Privacy and Responsibility in the German Media Code," *International Journal of Media Ethics*, 2019.

биелүүлэхээс татгалзаж, Зөвлөлийн үйл ажиллагааг 1982-1985 оны хооронд түр зогсооход хүргэсэн.²¹ Энэ үйл явдал нь зөвлөлийн үр нөлөө болон хэвлэл мэдээллийн байгууллагууд зөвлөлийн шийдвэрийг хэр зэрэг дагаж мөрдөх ёстой талаар олон нийт дунд маргаан үүсгэсэн байна. Энэхүү түр зогсолтын үеэр зөвлөлийн эрх мэдлийг хэрхэн бэхжүүлэх талаар олон хэлэлцүүлэг хийгдэж байсан.²²

1985 онд, Германы Хэвлэлийн Зөвлөл нь салбарын дэмжлэгтэйгээр дахин сэргээгдэж, шинэ дүрэм, журам, мөн орчин үеийн сэтгүүл зүйн ёс зүйн сорилтуудыг шийдвэрлэх зорилготой шинэчлэгдсэн Хэвлэлийн Кодтой болжээ.²³ Энэ шинэчлэлт нь гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дүрмийг илүү тодорхой болгож, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдлыг нэмэгдүүлснээр зөвлөлийн эрх мэдлийг бататгасан. Зөвлөлийг шинэчлэн байгуулсан нь салбарын хувьд хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг хадгалах, өндөр ёс зүйн стандартыг сахих тууштай байдлыг бататгасан байна.²⁴

Өнөөгийн байдлаар Германы Хэвлэлийн Зөвлөл нь олон улсын түвшинд хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын жишиг загвар болж, хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн хяналтын тогтолцоог хамгаалах чухал үүрэг гүйцэтгэж байна.²⁵ Энэхүү загвар нь олон нийтийн хариуцлагыг хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй хослуулж, төрийн шууд хяналтгүйгээр сэтгүүл зүйн хараат бус байдлыг хадгалахад хувь нэмрээ оруулсаар байна.²⁶

3) Финланд

Финланд улсын хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны үүсэл, хөгжлийн түүхэн нөхцөл байдал нь Зөвлөлт Холбоот Улстай харилцах харилцаанаас ихээхэн хамааралтай байсан. Хүйтэн дайны эхэн үед Финландын сэтгүүлчид хөршийнхөө талаар бичихдээ өөрсдөө хяналт тавих ёстой болдог байв. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг, ялангуяа улс төрийн асуудлыг хөндөхөд хязгаарлагдмал байдал бий болгож байсан.²⁷ Гэвч 1950-1960-аад оны үед Финландын хэвлэл мэдээллийн салбар улс төрийн хамаарлаас холдож, нийгмийн хэрэгцээ, зах зээлийн өөрчлөлтөд нийцсэн бизнесийн чиглэлтэй, мэдээллийн төвтэй загвар руу шилжиж эхэлсэн.²⁸

Энэ өөрчлөлт нь ёс зүйн шинэ сорилтуудыг бий болгосон бөгөөд ялангуяа “шар хэвлэл” буюу сенсацийн мэдээлэлд анхаарал хандуулсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд олширч байв. 1959 онд үүсгэн байгуулагдсан Нуму сэтгүүл нь энэхүү хандлагын тод жишээ болж, олны танил хүмүүсийн хувийн амьдралыг хөндсөн мэдээ нийтэлж олон нийтийн анхаарлыг

²¹ "Kölner Express and the German Press Council Crisis," *European Review of Media Studies*, 2020; OSCE, *Press Freedom Challenges in Germany*, 2018.

²² "1980s German Press Council Reform Discussions," *Journal of Media Reform and Policy Studies*, 2021; "Strengthening Press Council Authority in Germany," *Journal of Legal and Media Relations*, 2019.

²³ Ruggie, John Gerard, "Human Rights and Media Freedom Post-War," *Journal of Human Rights*, 2018; UNESCO, *Freedom of Expression and Media Guidelines*, 2020.

²⁴ "The Revitalization of the German Press Council in 1985," *Journal of German Media Ethics*, 2019; "New German Press Code Standards for Modern Journalism," *European Journal of Media Law*, 2020.

²⁵ "German Press Council: An International Model of Media Self-Regulation," *Journal of Comparative Media Studies*, 2021; OSCE, *Best Practices in Media Self-Governance*, 2019.

²⁶ UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; "Public Accountability and Press Freedom in Germany," *European Journal of Media Regulation*, 2018.

²⁷ "Finnish Media Self-Regulation and Its Soviet Relations," *Journal of Cold War Media Studies*, 2018.

²⁸ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2021.

татсан.²⁹ Нуту-ийн хамгийн маргаантай нийтлэлүүдийн нэг нь алдартнууд, улс төрчдийн хувийн амьдралыг нарийвчлан нийтэлсэн бөгөөд энэ нь олон нийтийн дургүйцлийг төрүүлж, сэтгүүл зүйн ёс зүйн талаар маргаан дэгдээсэн.³⁰

Энэ нөхцөл байдал нь 1974 онд хувь хүний нууцыг хамгаалах зорилготой “хувийн нууцын тухай хууль” батлахад хүргэсэн. Тус хууль нь хувь хүний хувийн амьдралд хөндлөнгөөс нэвтрэн орсон мэдээ нийтлүүлэхээс сэргийлэх зорилготой байсан бөгөөд хэвлэл мэдээллийн ёс зүйн код тогтоох шаардлагатайг харуулсан байна.³¹

Төрөөс илүү хатуу хяналт тогтоохоос сэргийлэхийн тулд 1968 онд Финландын хэвлэл мэдээллийн байгууллагууд нэгдэн Хэвлэл мэдээллийн зөвлөл (СММ) гэх өөрийн удирдлагын тогтолцоог бий болгожээ. Энэ зөвлөл нь хэвлэл, телевиз, радио, онлайн дахь агуулгыг хамарсан ёс зүйн стандартыг тогтоох үүрэгтэй бөгөөд үүгээрээ Финландын хэвлэл мэдээллийн салбар төрийн хатуу зохицуулалтаас ангид ёс зүйн зарчим тогтоох боломжтой болсон.³²

Финляндын Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүйн заавар нь олон нийтийн гомдлыг шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн ёс зүйн маргааныг шийдэх, сэтгүүл зүйн нэр хүндийг хамгаалах тогтолцоо болсон.³³ Өөрийн удирдлагын энэхүү бүтэц нь ёс зүйн стандартыг хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй уялдуулах, хэвлэл мэдээллийн салбарын хараат бус байдлыг хадгалах боломжийг олгосон байна.³⁴ Энэхүү зөвлөл нь Финландын хэвлэл мэдээллийн өндөр ёс зүйн стандарт, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах үйл ажиллагааг дэмжиж ажиллаж ирсэн.³⁵

Өнөөдөр Финляндын Хэвлэл мэдээллийн зөвлөл нь ёс зүйн стандартыг сахих, шинэ сорилттой тулгарах бүртээ дүрмээ шинэчилж, олон нийтийн хүлээлтийг хангах үүрэг гүйцэтгэдэг.³⁶

4) Дани

Дани улсад хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоо нь сэтгүүлчид болон нийтлэгчдийн хооронд үүссэн зөрчлөөс үүдэн хэрэгжиж эхэлсэн. 1964 онд Дани улс сайн дурын үндсэн дээр Хэвлэлийн Зөвлөлийг байгуулсан бөгөөд анхандаа зөвхөн сонингийн хэвлэлд ёс зүйн кодыг сахиулах буюу зөрчил гарсан асуудлуудад анхаарал хандуулж байв.³⁷ Энэ зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагад хариуцлага хүлээлгэх зорилготой хамтын

²⁹ "Hymy Magazine and Ethical Journalism in Finland," *Nordic Journal of Media Ethics*, 2020; European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation in EU Member States*, 2019.

³⁰ "Privacy Issues and the Emergence of Lex Hymy," *Journal of Media Law and Ethics*, 2021.

³¹ Organization for Security and Co-operation in Europe (OSCE), *Guidelines on Media Freedom and Independence*, 2019; "Lex Hymy and Privacy Protection in Finnish Media Law," *Journal of Privacy and Journalism Ethics*, 2021.

³² "Establishment of the Finnish Council for Mass Media," *Journal of Finnish Press Regulation*, 2020; "Finland's Media Self-Regulation Model," *International Journal of Media Studies*, 2019.

³³ "CMM's Role in Public Complaint Handling," *European Media Standards Review*, 2018; Council of Europe, *Media Freedom and Ethical Standards*, Strasbourg, 2019.

³⁴ "Finnish Self-Regulation and Press Freedom," *Nordic Journal of Media Studies*, 2021; "Ethical Journalism in Finland's Self-Regulatory Framework," *Journal of Public Trust and Media Ethics*, 2020.

³⁵ UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020; OSCE, *Best Practices in Media Self-Governance*, 2018.

³⁶ "Adapting to Ethical Challenges in Finnish Media," *Journal of Media Ethics and Regulation*, 2021.

³⁷ "Origins of Media Self-Regulation in Denmark," *Nordic Journal of Media Ethics*, 2020.

ажиллагааны арга хэмжээ байсан бөгөөд төрийн шууд хяналтгүйгээр ажиллахыг зорьсон юм.³⁸ Гэвч энэ тогтолцоо эхний үедээ хүндрэлтэй байсан бөгөөд сэтгүүлчдийн холбоод зөвлөлийг бүрэн дэмжээгүй ба хэвлэлийн эрх чөлөөг илүү хамгаалах, сэтгүүлчдийн ёс зүйн эрхийг баталгаажуулахыг хүссэн байв.³⁹ Тухайлбал, сэтгүүлчид хувь хүний ёс зүй нь редакцын бодлоготой зөрчилдсөн үед хувь хүний ёс зүйн эрхийг хамгаалах илүү хүчтэй тогтолцоо хэрэгтэй гэж үзэж байв.⁴⁰

1991 он гэхэд илүү тогтвортой өөрийн удирдлагын тогтолцоо хэрэгтэй нь тодорхой болсон бөгөөд үүний үр дүнд Дани улс Мэдээллийн Хариуцлагын Хуулийг баталсан.⁴¹ Тус хууль нь хэвлэл болон өргөн нэвтрүүлгийн хэрэгслүүдийг хамарсан, Хэвлэлийн Зөвлөлийг бий болгожээ.⁴² Мэдээллийн Хариуцлагын Хууль нь төрөөс тавигдах шаардлагыг хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй уялдуулах, хэвлэл мэдээллийн салбарын өөрийн удирдлагын тогтолцоог хослуулахыг зорьсон бөгөөд хариуцлагын түвшинг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн салбарын редакцын эрх чөлөөг баталгаажуулахад чиглэсэн.⁴³

Шинэ зөвлөл нь олон нийтийн дунд хэвлэл мэдээллийн ёс зүйн стандартуудыг мөрдүүлэх тодорхой бүтэцтэй болж, ёс зүйн зарим тодорхой асуудлуудад хяналт тавих үүрэгтэй байв.⁴⁴ Жишээлбэл, мэдээллийн үнэн зөв байдлыг алдагдуулах, хувийн нууцад халдах зэрэг асуудлуудыг хянан шийдвэрлэх боломжтой болсон.⁴⁵ Энэ нь тогтоосон хэвлэл мэдээллийн ёс зүйн стандартыг баримтлах, редакцын бие даасан байдлыг хадгалах боломжийг олгосон.⁴⁶ Мөн тус хуулиар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд ижил ёс зүйн стандарт тогтоосноор хэвлэл, өргөн нэвтрүүлэг, Цахим платформ зэрэг олон төрлийн хэвлэл мэдээллийн сувгуудыг нэгтгэх боломжтой болсон.⁴⁷

Данийн энэхүү хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын загвар нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал болж, хариуцлагыг нэмэгдүүлж, эрх чөлөөг хамгаалахад хувь нэмэр оруулж байна.⁴⁸ Энэхүү загвар нь Дани улсад хэвлэл мэдээллийн нэр хүнд, ёс зүйн өндөр стандартыг бий болгож, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хариуцлагатай байдалтай хослуулан хадгалахад чухал үүрэг гүйцэтгэх болжээ.⁴⁹

³⁸ European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation and Media Freedom in the EU*, 2019.

³⁹ "Challenges of Danish Media Council Formation," *Journal of Danish Media Law and Ethics*, 2018; UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2021.

⁴⁰ "Press Freedom and Journalists' Rights in Denmark," *Scandinavian Media Studies*, 2019.

⁴¹ OSCE, *Media Freedom and the Role of Co-Regulation in Denmark*, 2020; "The Role of the Media Liability Act," *Danish Journal of Legal Studies*, 2021.

⁴² "Implementation of the Danish Media Liability Act," *European Journal of Media Regulation*, 2018.

⁴³ United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *Media Regulation and Ethics*, 2020.

⁴⁴ "Ethical Standards in Danish Media," *Journal of Professional Journalism*, 2019.

⁴⁵ "Privacy and Ethical Reporting in Denmark," *Journal of International Media Ethics*, 2021.

⁴⁶ OSCE, *Press Freedom and Self-Regulation Mechanisms*, 2019.

⁴⁷ "Unified Ethical Standards in Danish Media," *European Media Standards Review*, 2020.

⁴⁸ UNESCO, *Global Best Practices in Media Self-Regulation*, 2019.

⁴⁹ "Danish Model of Media Accountability and Standards," *International Journal of Media Ethics and Freedom*, 2021.

5) Ирланд

Ирландын Хэвлэлийн Зөвлөл нь Ирландын хэвлэл мэдээллийн салбарын эрх чөлөөг хамгаалах, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлэх зорилготойгоор 2007 онд байгуулагдсан.⁵⁰ Энэ нь төрийн оролцоогүйгээр хэвлэл мэдээллийн ёс зүйн зөрчлийг шийдвэрлэх байгууллага бөгөөд тухайн үед гарсан "хүний нэр төрийг хамгаалах тухай хуулийн шинэчлэлийн" үр дүнд бий болсон. Хууль зүйн сайд тухайн үед хэвлэл мэдээллийн хариуцлагыг дээшлүүлэх, гомдлыг хянан шийдвэрлэх зорилготой төрийн оролцоотой хэвлэлийн зөвлөл байгуулах санал гаргасан бөгөөд энэ нь салбарын эсэргүүцэлтэй тулгарчээ.⁵¹

Хэвлэл мэдээллийн салбарын гол санаа зовоож байсан асуудал нь төрийн оролцоо нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж болзошгүй гэж үзэж байсан явдал байв. Хэрэв төрийн оролцоотой зөвлөл байгуулагдвал хэвлэл мэдээлэл нь төрийн нөлөөнд автаж, нийтлэл нь агуулгын хувьд хараат байдалд орж болзошгүй гэж тэд үзсэн. Үүний улмаас Ирландын хэвлэл мэдээллийн салбар, төрийн төлөөлөгчид харилцан зөвшилцөж, ёс зүйн хариуцлага болон хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалсан хэвлэл мэдээллийн бие даасан өөрийн удирдлагын тогтолцоог бий болгохоор шийдсэн байна.

Энэ зөвшилцлийн хүрээнд Ирландын Хэвлэлийн Зөвлөл болон Хэвлэлийн Омбудсман гэсэн бие даасан хоёр байгууллага бий болсон. Хэвлэлийн Омбудсман нь иргэдийн гомдлыг эхний шатанд хүлээн авч, шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд асуудлыг хурдан шуурхай, шударгаар шийдвэрлэхийг зорьдог. Хэрэв тухайн гомдлыг шийдвэрлэж чадахгүй бол асуудлыг Ирландын Хэвлэлийн Зөвлөлд шилжүүлдэг. Хэвлэлийн Зөвлөл нь хэвлэл мэдээллийн салбарын тогтоосон ёс зүйн стандартуудад үндэслэн гомдлыг дахин хянаж үздэг бөгөөд энэ нь төрийн оролцоогүйгээр, зөвхөн салбарын ёс зүйн шаардлагад нийцсэн шийдвэр гаргах нөхцөлд тулгуурладаг.⁵²

Энэхүү загвар нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж, олон нийтийн хүлээлтэд нийцсэн ёс зүйн хариуцлагыг хангах боломжийг бүрдүүлдэг байна. Хэвлэлийн зөвлөл нь гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай жилийн тайлан гаргаж, олон нийтэд ил тод танилцуулга хийснээр олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг.

Энэ тогтолцоо нь Ирландын хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн өндөр стандарт тогтоож, төрийн оролцоогүй сэтгүүл зүйн эрх чөлөөг баталгаажуулсан загвар болсон.⁵³ Иймээс Ирландын Хэвлэлийн Зөвлөл нь зөвхөн Ирланд төдийгүй бусад улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө, ёс зүйг хослуулсан загвар болохуйц сайн жишээ болж байна.

6) Австрали

1975 онд Австралийн Хэвлэл мэдээллийн сайд Др. Мосс Касс тайлан гаргаж, сонины зөвлөлийг сайн дурын үндсэн дээр байгуулж, лицензийн систем нэвтрүүлэх боломжтой гэсэн санал гаргасан нь хэвлэл мэдээллийн салбарынханд томоохон дохио болж, 1976 онд Австралийн Хэвлэлийн Зөвлөлийг яаралтай байгуулахад хүргэсэн.⁵⁴ Энэхүү зөвлөл нь ёс

⁵⁰ Defamation Act of 2009,

⁵¹ Horgan, John, *Journalism and the Public Interest: Defining News in the 21st Century* (Cork: Mercier Press, 2001) .

⁵² O'Malley, Tom, *Media Law in Ireland* (Dublin: Clarus Press, 2011) .

⁵³ Kennedy, Declan, *Self-Regulation in Irish Media: Press Councils and Ethical Standards* (Cambridge University Press, 2012) .

⁵⁴ Disney, Julian, *Australian Press Council Annual Report* (Sydney: Australian Press Council, 2010).

зүйн стандарт тогтоох, олон нийтийн гомдлыг шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн салбарын эрх чөлөөг хадгалах чиглэлээр ажиллах өөрийн удирдлагын тогтолцоог бий болгосон.

Австралийн Хэвлэлийн Зөвлөлийн үүрэг нь ёс зүйн стандартыг тогтоохоос гадна олон нийтийн гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлэх, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд оршдог.⁵⁵ Тус зөвлөл нь хувийн нууцлалыг хамгаалах, үнэн зөв байдал, шударга ёсны зарчмыг баримтлах зэрэг ёс зүйн дүрэмтэй бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаанд эдгээр стандартыг мөрдөх үүрэгтэй.

Австралийн хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны маргаан өнөөдөр ч үргэлжилж байгаа бөгөөд онлайн орчин, Цахим платформууд, хуурамч мэдээлэл зэрэг шинэ сорилтуудыг хэрхэн даван туулах тухай асуудал өргөн хүрээнд хэлэлцэгдэж байна. Австралийн Хэвлэлийн Зөвлөл нь эдгээр сорилтуудыг даван туулахын тулд ёс зүйн удирдамжуудаа шинэчлэн боловсруулж, орчин үеийн Цахим орчинд хэвлэл мэдээллийн ёс зүйг хадгалах зорилготой ажилладаг. Энэ нь зөвлөлийг зөвхөн уламжлалт хэвлэл мэдээлэлд биш, мөн цахим орчинд ч ёс зүйн өндөр стандарт тогтоох байгууллага болгон өргөжүүлж байна.

Эдгээр жишээнээс үзэхэд, Хэвлэлийн Зөвлөлүүд нь ихэвчлэн төрийн зүй бус оролцооноос сэргийлж байгуулагдсан бөгөөд өөрийн удирдлагын тогтолцоо нь хэвлэл мэдээллийн ёс зүйг хамгаалах, олон нийтийн итгэлийг хадгалах чухал арга хэрэгсэл болж байгаа юм.⁵⁶ Энэ хандлага нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах, хариуцлагатай сэтгүүл зүйг дэмжихэд томоохон хувь нэмэр оруулж байна.

7) Явцын дүгнэлт

Швед, Герман, Финланд, Дани, Ирланд, Австралийн Хэвлэлийн Зөвлөлүүдийн үүсэл, хөгжил нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон хариуцлагын хоорондын тэнцвэрийг бий болгох онцгой шийдлүүдийг харуулж байна. Эдгээр улс орны Хэвлэлийн Зөвлөлүүд нь төрийн зүй бус нөлөөллийг арилгах, ёс зүйн хариуцлагын асуудлыг шийдвэрлэх, эсвэл хүний нэр төрийг гутаахаас хамгаалах тухай хуулийн шинэчлэл зэрэг өөрсдийн өвөрмөц нөхцөл байдлын хариуд үүссэн бөгөөд нийтлэг зорилго нь хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйг сахин хамгаалж, хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг баталгаажуулах явдал байна.

Швед, Герман, Финланд, Австрали зэрэг улсууд нь ихэвчлэн төрийн оролцоо бага, салбарын дотоод зохицуулалт бүхий тогтолцоотой бөгөөд хэвлэлийн эрх чөлөөг бие даасан байдлаар хамгаалах зарчмыг баримталдаг. Жишээлбэл, Шведийн загвар нь олон нийтийн төлөөллийг оролцуулахаар бүтэцлэгдсэн бол Германы Хэвлэлийн Зөвлөл нь Дэлхийн хоёрдугаар дайны дараах төрийн цензурын эсрэг тэмцлээс үүдэн бие даасан байдалд илүү их анхаарч, хэвлэл мэдээллийн салбарын хариуцлагыг сайжруулахыг дэмжсэн байдаг. Австралийн Хэвлэлийн Зөвлөл нь 1970-аад онд төрийн оролцоог багасгах зорилгоор үүсгэн байгуулагдсан бөгөөд өнөөг хүртэл Цахим медиа болон мэдээллийн технологийн хөгжилтэй уялдуулан ёс зүйн стандартыг хадгалж иржээ.

Харин Дани, Ирланд зэрэг улсууд өөрийн удирдлагын болон төрийн оролцооны зарим элементийг хослуулсан байдаг. 1991 онд батлагдсан Мэдээллийн Хариуцлагын Хууль нь

⁵⁵ *Media Convergence* (London: Palgrave Macmillan, 2010), which explores the adaptation of press councils in response to digital media.

⁵⁶ Hurst, John, *Ethics and the Australian News Media* (Melbourne: Macmillan, 2004).

Данид хэвлэл, өргөн нэвтрүүлгийн салбаруудад ёс зүйн тодорхой шаардлагуудыг тогтоосон бөгөөд ёс зүйн асуудлуудад хяналт тавьж ирсэн. Ирландын Хэвлэлийн Зөвлөл нь гомдлыг шийдвэрлэх, олон нийтийн итгэлийг хангахын тулд Омбудсманы тогтолцоо бүхий бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Хэвлэлийн Зөвлөлүүд нь хэвлэл мэдээллийн хараат бус байдал болон хариуцлагыг баталгаажуулах боломжтойг харуулж байна. Эдгээр зөвлөлийн жишээнүүд нь ёс зүйн стандарт тогтоохын зэрэгцээ хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалах нь улс орнуудын онцлог, соёл, улс төрийн орчинтой ихээхэн хамааралтай болохыг илтгэж байна. Хэвлэлийн Зөвлөлүүд нь ардчилсан үнэт зүйлсийг хүндэтгэж, ёс зүйтэй хэвлэл мэдээллийн салбарыг дэмжихийн зэрэгцээ хариуцлагатай хэвлэл мэдээллийг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

3.3. Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны загварууд, харьцуулсан судалгаа

Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцооны загвар нь улс орнуудад өөр өөр хэлбэрээр хэрэгжиж байна. Судалгаанаас үзвэл үүнийг онцлог шинжээс нь хамааран сайн дурын зөвлөл, хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөл, хуулиар тогтоосон зөвлөл гэж гурав ангилж болно. Эдгээр зөвлөлийн загвар нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон хариуцлагыг хослуулах зорилготой бөгөөд хэвлэл мэдээллийн бие даасан байдлыг хадгалахын зэрэгцээ ёс зүйн шаардлагыг хангасан байдлыг баталгаажуулдаг байна. Судалгааны энэхүү хэсэгт Швед, Герман, Финлянд, Ирланд, Дани зэрэг улс орнуудын өөр өөр загварын хандлагыг судалж, тэдгээр нь хэвлэлийн эрх чөлөө ба ёс зүйг хэрхэн хамгаалж байгааг онцолсон болно.

3.3.1. Сайн дурын зөвлөлийн загвар

1) Швед

Шведийн хэвлэл мэдээллийн сайн дурын зөвлөлийн загвар нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж, ёс зүйн хариуцлагыг хангах зорилготой байдаг. Хэвлэлийн Зөвлөлийн гишүүнчлэл нь заавал байх шаардлагагүй, мөн үүнд зориулсан урамшуулал байхгүй ч олон хэвлэл мэдээллийн байгууллага энэ зөвлөлд сайн дураар элсдэг. Учир нь ингэснээр олон нийтэд ёс зүйн стандартыг мөрддөг гэдгээ илтгэж, тэдний итгэлийг хүлээн авдаг.⁵⁷ Хэвлэлийн Омбудсман Ола Сигвардссон-ийн хэлснээр, зөвлөлд элсэх нь хэвлэлийн ёс зүйн хэм хэмжээг баримталж байгааг харуулж, олон нийтэд итгэл төрүүлэх ач холбогдолтой гэжээ. Сайн дурын зөвлөлийн загварын хүрээнд Шведийн хэвлэлийн зөвлөлийг сэтгүүлчдийн холбоо болон салбарын худалдааны нийгэмлэгүүд санхүүжүүлдэг.⁵⁸ Хэвлэл мэдээллийн зах зээлийн дийлэнх хэсгийг төлөөлөхүйц байгууллагууд Хэвлэлийн Зөвлөлийг дэмжиж, үйл ажиллагааг нь салбарын ёс зүйн стандарттай уялдуулдаг.

Хэдийгээр зөвлөлийн гишүүнчлэлийг хэвлэл мэдээллийн байгууллагуудаас эрх зүйн хүрээнд заавал шаарддаггүй ч Шведийн хууль тогтоомж нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад ёс зүйн хариуцлага тооцох орчныг бүрдүүлсэн. Шведийн Хэвлэлийн Эрх

⁵⁷ Nord, Lars, *Trust in Media and Democratic Engagement* (New York: Routledge, 2018).

⁵⁸ Trappel, Josef, et al., *European Media Governance: National and Regional Dimensions* (Bristol: Intellect Books, 2011).

Чөлөөний Хууль-ийн дагуу жилд дор хаяж дөрвөн удаа аливаа мэдээлэл хэвлэдэг бүх хэвлэл мэдээллийн байгууллага Шведийн Патент Бүртгэлийн Газарт бүртгүүлэхийг шаарддаг.⁵⁹ Мөн бүртгүүлэх үед хэвлэл мэдээллийн байгууллага бүр "хариуцлагатай редактор" буюу ерөнхий редакторыг томилох ёстой бөгөөд тухайн редактор нийтлэгдсэн мэдээллийн агуулгын эрх зүйн хариуцлагыг бүрэн хариуцна. Шведийн хэвлэл мэдээллийн тогтолцоонд хариуцлагатай редакторын үүрэг нь онцгой ач холбогдолтой бөгөөд хэрэв нийтлэлийн агуулгатай холбоотой хууль зүйн асуудал үүсвэл тухайн хэвлэлийн нийт сэтгүүлчдийг бус, зөвхөн хариуцлагатай редакторт хариуцлага хүлээлгэдэг.⁶⁰ Энэ нь хувь сэтгүүлчдийг хууль зүйн хариуцлагаас хамгаалж, хариуцлагатай хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмждэг байна.

Шведийн хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын тогтолцоо нь сайн дурын зөвлөлийн загварт хамаарах боловч ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд Хэвлэлийн Зөвлөл тус зөрчлийг нийтлэх байдлаар шүүмжилж, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг. Зарим хэвлэлүүд, тухайлбал *Expressen*, ёс зүйн алдаагаа өөрөө олон нийтэд зарладаг. Энэ хандлагыг зарим судлаачид хэвлэл мэдээллийн салбар дахь соёлын шинэчлэл гэж үзэж байгаа бөгөөд өнөөдөр алдаагаа хүлээн зөвшөөрөх нь олон нийтийн итгэлийг нэмэгдүүлж, ёс зүйн өндөр стандартыг тогтооно гэжээ.

2) ХБНГУ (Холбооны Бүгд Найрамдах Герман Улс)

Германы Хэвлэлийн Зөвлөл нь тус улсын Үндсэн хуульд тусгасан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах хүрээнд ажилладаг сайн дурын зөвлөл юм.⁶¹ Энэхүү зөвлөл нь хэвлэл мэдээллийн ёс зүйг төрийн шууд оролцоогүйгээр дэмжих зорилготой бөгөөд санхүүжилт, дэмжлэгийн хувьд хэвлэлийн байгууллагууд болон сэтгүүлчдийн холбоо дээр суурилдаг. Германы Хэвлэлийн Зөвлөл хэвлэлийн эрх чөлөөний зарчмуудыг дагаж, хариуцлагатай байдлыг хангахад чиглэсэн байдаг.

1981 онд Германы Хэвлэлийн Зөвлөлд томоохон асуудал гарсан.⁶² Энэ нь хэвлэл мэдээллийн томоохон эзэд Хэвлэлийн Зөвлөлөөс гаргасан шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзсан тохиолдлоос улбаатай. Тус хэрэг нь Кёльн хотын *Kölner Express* сонин-той холбоотой гарсан асуудал юм. Уг сонин зөвлөлийн ёс зүйн зөрчлийг буруутгасан шийдвэрийг нийтлэхээс татгалзаж, шүүмжлэлийг нийтэд ил болгохоос зайлсхийсэн. Хэвлэлийн Зөвлөл нь ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд олон нийтэд мэдээлэх зорилгоор "олон нийтийн шүүмжлэл" буюу шийдвэрийг хэвлүүлэхийг шаарддаг бөгөөд энэ нь тус зөвлөлийн хэвлэл мэдээллийн ёс зүйг сахиулах гол арга зам юм.⁶³

Kölner Express сонин зөвлөлийн шүүмжлэлийг нийтлэхээс татгалзсан нь зөвлөлийн эрх мэдлийг сулруулж, үйл ажиллагааг нь түр зогсооход хүргэсэн. 1985 онд хэвлэл

⁵⁹ *The Independence of the Media and Its Regulatory Agencies: Shedding New Light on Formal and Actual Independence against the National Context* (Bristol: Intellect Books, 2018).

⁶⁰ Thorgeirsdottir, Herdís, *Journalistic Freedom and Accountability* (Brill, 2004).

⁶¹ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland [Basic Law for the Federal Republic of Germany], Art.

5.

⁶² Moe, Hallvard, and Josef Trappel, *European Media Governance: National and Regional Dimensions* (Bristol: Intellect Books, 2011).

⁶³ Schulz, Wolfgang, and Thorsten Held, *Regulated Self-Regulation as a Form of Modern Government* (London: John Libbey, 2004).

мэдээллийн байгууллагуудын 90 хувь "сайн дурын тунхаглал"-д гарын үсэг зурж, шүүмжлэлүүдийг шаардлагатай тохиолдолд хэвлэхийг зөвшөөрснөөр зөвлөлийн үйл ажиллагаа дахин эхэлсэн. Энэ зөвшилцөл нь зөвлөлийн нэр хүндийг сэргээж, хэвлэл мэдээллийн салбарын дотор ёс зүйн стандартыг сахиулах боломжийг нэмэгдүүлсэн байна.

Гэсэн хэдий ч энэхүү зөвшилцлийн үр нөлөө нь зөвхөн сайн дурын үндсэн дээр хэрэгждэг тул хязгаарлагдмал хэвээр байгаа гэж судлаачид үздэг. Зөвлөл нь шүүмжлэлүүдийг хаана, хэрхэн нийтлэхийг хянах боломжгүй бөгөөд нийтэлж буй хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн үзэл бодлыг нэмж оруулах боломжтой. Энэ нь редакцын эрх чөлөөг хадгалах боломжийг олгодог боловч зөвлөлийн шийдвэрийн үр нөлөөг тодорхой түвшинд хязгаарладаг.

Германы Хэвлэлийн Зөвлөл нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон ёс зүйн хариуцлагыг сайн дурын системээр тэнцвэржүүлэхэд чиглэсэн жишээ болж байна. Гэсэн хэдий ч *Kölner Express*-ийн жишээнээс харахад томоохон хэвлэлийн байгууллагууд зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрдөхөөс татгалзах тохиолдол нь тус тогтолцооны сул талыг харуулж байна.

2007 онд Германы Хэвлэлийн Зөвлөл мөн ижил төстэй бэрхшээлтэй тулгарсан. Тухайн үед гарсан хэрэг бол Германы алдартай *Bild* сонины Халид Эл-Масри гэх Ливан гаралтай Германы иргэний тухай нийтлэл юм. Эл-Масри 2003 онд Македонд баривчлагдаж, АНУ-ын эрх баригчдын зүгээс Афганистан руу шилжүүлэгдэж, тэнд хэдэн сарын турш эрүүдэн шүүлтэд өртсөн бөгөөд 2004 онд түүнийг буруугүй нь тогтоогдож суллагдсан байдаг. Герман руу буцсаны дараа Эл-Масри дэлгүүрт галдан шатаалт хийсэн хэргээр баривчлагдсан. *Bild* сонин түүнийг баривчлагдсан тухай нийтэлж, түүнийг "галзуу Герман-Ливан хүн" гэж нэрлээд "сэтгэцийн эмнэлэгт" байгааг дурдсан.

Эл-Масри энэхүү нийтлэл нь түүний сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг буруугаар харуулж, хувийн нууцад халдсан гэж үзэн Германы Хэвлэлийн Зөвлөлд гомдол гаргажээ. Хэвлэлийн Зөвлөл түүний гомдлыг хүлээн авч, *Bild* сонин түүний хувийн асуудал, сэтгэцийн эрүүл мэндийг хэтрүүлэн харуулсан нь ёс зүйн стандартыг зөрчсөн гэж үзсэн байна. Үүний дараа Хэвлэлийн Зөвлөл *Bild*-д ёс зүйн зөрчлийн шүүмжлэлийг нийтлэхийг шаардсан боловч, *Bild* зөвхөн шүүмжлэлийг хэвлээд зогсохгүй, "Хэвлэлийн Зөвлөл галдан шатаагчаас болж *Bild*-ийг шүүмжлэв" гэсэн гарчигтайгаар өмнөх мэдээллээ дахин баталсан нийтлэл гаргасан. Тэдний хэлснээр, Эл-Масри бол "хүчирхийлэгч, галзуу галдан шатаагч" бөгөөд түүний талаар бичсэн зүйлсээ өөрчлөхгүй гэдгээ мэдэгдсэн байна.

Энэхүү хэрэг нь Хэвлэлийн Зөвлөлийн эрх мэдлийн хязгаарлагдмал байдлыг харуулсан бөгөөд зөвлөл нь шүүмжлэлийг хэрхэн, ямар түвшинд нийтлэхийг хянах боломжгүй гэдэг нь тодорхой болсон юм. Зөвлөл өөрийн шийдвэрийг тайлбарласан хэвлэлийн мэдэгдэл гаргасан боловч шүүмжлэлийг хүндэтгэлтэй, эсвэл зохих байдлаар хүргүүлэх боломж хязгаарлагдмал байв. Энэ тохиолдол нь Германы сайн дурын хэвлэлийн зөвлөлийн тулгардаг бэрхшээлийг тодруулж, сайн дурын зөвлөлийн загварын үр дүнтэй байдал нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, хүсэл тэмүүлэл дээр ихээхэн тулгуурлагдгийг харуулсан байна.⁶⁴

⁶⁴ Brogi, Elda, et al., *Monitoring Media Pluralism in Europe* (Florence: European University Institute, 2021).

2007 онд мөн *Eco-Test* сэтгүүлд ёс зүйн зөрчлийн шүүмжлэлийг тавих үеэр Германы Хэвлэлийн Зөвлөл өөр нэг бэрхшээлтэй тулгарсан. Тус сэтгүүл нялх хүүхдийн экзем эмчлэх тос нь хорт хавдар үүсгэж болзошгүй гэж дурдсан нийтлэл гаргасан байв. Зөвлөл энэ мэдээлэл нь хэт их түгшүүр үүсгэсэн, хангалттай шинжлэх ухааны үндэслэлгүй гэж үзсэн тул *Eco-Test* сэтгүүлд залруулга гаргахыг шаардсан. Үүний хариуд *Eco-Test* шүүхэд гомдол гаргаж, шүүмжлэл нь тэдний нэр хүндэд халдсан гэж үзжээ. Анхандаа Франкфуртын шүүх *Eco-Test*-ийн талд шийдвэр гаргаж, шүүмжлэлийг цаашид нийтлэхийг зогсоосон боловч давж заалдах шатны шүүхийн шийдвэр өөрчлөгдөж, Хэвлэлийн Зөвлөл шүүмжлэл гаргах эрхтэй гэж шийдсэн.

Хэдийгээр Германы хэвлэлийн байгууллагуудын 90 орчим хувь нь ёс зүйн стандартуудыг хангах үүднээс олон нийтийн шүүмжлэлийг хэвлэх сайн дурын үүрэг буюу "сайн дурын тунхаглал"-ыг хүлээн зөвшөөрсөн боловч зарим хэвлэлийн байгууллагууд байнга, эсвэл огт биелүүлээгүй хэвээр байна. Энэхүү нөхцөл байдал нь Зөвлөлийн хувьд бүх хэвлэлийн байгууллагад ёс зүйн хариуцлагыг тууштай мөрдүүлэхэд бэрхшээл тулгардгийг харуулж байна.⁶⁵

3) Финланд

Финландын хэвлэл мэдээллийн сайн дурын загвар нь сонин, сэтгүүл, телевизийн нэвтрүүлэг, цахим хэвлэл зэрэг бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүрээнд бүрэн сайн дурын үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулдаг.⁶⁶ Европын холбооны MediaDem төсөлд дурдсанаар, Финландын хэвлэл мэдээллийн байгууллагууд бараг бүгд Олон Нийтийн Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (СММ)-ийн гишүүн байдаг. Энэхүү өргөн цар хүрээтэй гишүүнчлэл нь Финландын хэвлэл мэдээллийн салбарт ёс зүйн хариуцлагыг хэрэгжүүлэх чухал шалгуур болдог байна.

Сайн дурын зөвлөлийн амжилтын нэг чухал шалтгаан нь салбарынхан төрийн оролцооны оронд өөрсдөө зохицуулалт хийх бодит хүсэл эрмэлзэлтэй холбоотой.⁶⁷ СММ-ийн дарга Ристо Уимонен хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрөө зохицуулалттай байснаар олон нийт, төр, эрх бүхий байгууллагуудын итгэлийг хүлээж чаддагийг онцолжээ.

Финландын эрх зүйн тогтолцоо нь хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дэмждэг бөгөөд үг хэлэх эрх чөлөөг Финландын Үндсэн хууль болон Засгийн газрын Үйл Ажиллагааны Ил Тод Байдлын Хууль-аар хамгаалдаг.⁶⁸ Нэмж дурдахад, Хэвлэл Мэдээллийн Салбарын Үзэл Бодлоо Илэрхийлэх Эрхийн Хууль нь бүх хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд үйлчилдэг бөгөөд зөвхөн зайлшгүй тохиолдолд, хуулийн хүрээнд л төрийн оролцоог зөвшөөрдөг. Энэхүү хууль нь Швед зэрэг улс орнуудын шаардлагатай адил төстэй бөгөөд жилд дөрвөөс дээш удаа хэвлэн нийтэлдэг бол хариуцлагатай редактор томилохыг шаарддаг.

Энэхүү хариуцлагатай редакторын үүрэг нь онцгой ач холбогдолтой бөгөөд редакторуудад редакцын шийдвэрийг гаргах бүрэн эрхийг олгодог.⁶⁹ Уимонены хэлснээр,

⁶⁵ Hanretty, Chris, *Public Broadcasting and Political Influence* (London: Routledge, 2010).

⁶⁶ MediaDem Project, *Democracy in the Age of Social Media* (Brussels: European Union, 2013).

⁶⁷ Nordenstreng, Kaarle, *Media and Democracy in Finland* (Helsinki: University of Helsinki Press, 2014).

⁶⁸ Moring, Tom, *Media Law in Finland* (Copenhagen: Nordic Council of Ministers, 2017).

⁶⁹ "The Role of the Responsible Editor in Finnish Media," *Nordicom Review*, 2016.

редактор нь тухайн хэвлэл мэдээллийн агуулгын тухай эцсийн шийдвэрийг гаргах эрхтэй бөгөөд удирдлагын зүгээс дарамт шахалт үзүүлэх боломжгүй байдаг нь редакцын хараат бус байдлыг хангадаг.

Финландын сайн дурын зөвлөлийн загвар нь салбарын хүчтэй дэмжлэг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалсан хууль эрх зүйн хүрээнд хэвлэл мэдээллийн хараат бус байдал, ёс зүйн хариуцлагыг үр дүнтэй хадгалахад хувь нэмрээ оруулдаг.⁷⁰

Финландын сайн дурын зөвлөлийн загвар нь салбарын хүчтэй дэмжлэг, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалсан хууль эрх зүйн хүрээнд хэвлэл мэдээллийн хараат бус байдал, ёс зүйн хариуцлагыг үр дүнтэй хадгалахад хувь нэмрээ оруулдаг.⁷¹

3.3.2. Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар⁷²

1) Ирланд

Ирландын хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар нь хэвлэлийн эрх чөлөө, ёс зүйн хариуцлагыг нэгдмэл байдлаар хэрэгжүүлэх боломжийг олгодог. 2009 оны Гүтгэлгийн эсрэг хууль-д суурилан зохицуулагдсан энэхүү загвар нь Ирландын Хэвлэлийн Зөвлөл болон Хэвлэлийн Омбудсман-аар дамжуулан ёс зүйн дүрмийг сахих, гомдлыг шийдвэрлэхэд төвлөрдөг бөгөөд төрийн шууд бус оролцоотой стандартуудыг тогтоох боломжийг олгодог.⁷³

Энэхүү загварын үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь гүтгэлгийн эсрэг хуультай холбоотой юм. Хэвлэлийн Зөвлөлийн гишүүнчлэл нь гүтгэлгийн хэргийн эсрэг хууль ёсны хамгаалалт олгодог бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагууд энэхүү гишүүнчлэлийг өөрийн байр суурийг хамгаалах хэрэгсэл болгон ашиглах боломжтой. Хэвлэл мэдээллийн байгууллага ёс зүйн стандартыг мөрдөж, Омбудсманы шийдвэрийг дагаж мөрдвөл шүүх энэ үүрэг хариуцлагыг “шударга, үндэслэлтэй” мэдээлэл гэж үздэг. Омбудсман асан Жон Хорган Хэвлэлийн Зөвлөлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдөх нь гишүүдэд шүүхийн өмнө онцгой давуу тал олгодог тул гишүүнчлэлийг дэмжих томоохон хөшүүрэг болдог гэж онцолжээ.⁷⁴

Хуулиар илэрч буй төрийн оролцоо нь зөвхөн гишүүнчлэлээс гадна ёс зүйн стандартыг тогтмол дагаж мөрдөхийг урамшуулдаг.⁷⁵ Хэвлэлийн байгууллагууд зөвлөлийн ёс зүйн стандартыг тогтмол мөрдөх ёстой бөгөөд хууль зүйн асуудал тулгарах үедээ л дагаж мөрдөхөөс илүүтэй өдөр тутамдаа сахихыг шаарддаг байна. Хорган үүнийг “далд урамшуулал” гэж нэрлэсэн бөгөөд ёс зүйн стандартыг өдөр бүр баримтлах шаардлагатай гэдгийг онцолсон нь зөвлөлийн зорилго, ёс зүйтэй сэтгүүл зүйн төлөөх үнэт зүйлсийг бэхжүүлдэг ажээ.

⁷⁰ Nordenstreng, Kaarle, and Tapio Varis, *Media and Power in Finland* (Helsinki: Finnish Media Federation, 2018).

⁷¹ Nordenstreng, Kaarle, and Tapio Varis, *Media and Power in Finland* (Helsinki: Finnish Media Federation, 2018).

⁷² Lara Fielden, *Regulating the Press: A Comparative Study of International Press Councils*, Reuters Institute for the Study of Journalism Report (Oxford: Reuters Institute, April 2012).

⁷³ European Commission, *Ireland: Media Regulation and Defamation Laws* (Brussels: European Union, 2010).

⁷⁴ Horgan, John, *Defamation Law and Media in Ireland* (Dublin: Irish Media Federation, 2012).

⁷⁵ O'Donnell, Mark, *Press Council and Accountability in Ireland* (Dublin: Irish Legal Publications, 2015).

Мөн хууль нь гүтгэлгийн хэрэгт уучлал болон залруулга хийхийг урамшуулдаг байна. Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага алдаа гаргасан бол шуурхай уучлал гуйх, залруулга хийх боломжтой. Шуурхай уучлал гуйж, залруулга хийсэн бол шүүхийн шийтгэлийг бууруулах боломжийг олгодог бөгөөд энэ нь Ирландын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн гомдлыг шийдвэрлэх арга барилд томоохон өөрчлөлт авчирсан. Хорган энэ зохицуулалт нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг буруу мэдээллийг засах, уучлал гуйхыг илүү ихээр эрмэлздэг болгосон нь сайшаалтай гэж тэмдэглэжээ. Хэвлэлийн Зөвлөлийн дарга Дайти О’Селлах үндэсний хэмжээний сонинууд алдаа гаргасан үедээ хариуцлагатай хандаж, гомдлыг хурдан шийдвэрлэх тал дээр илүү идэвхтэй болж буйг онцолсон.

Гүтгэлгийн эсрэг хуулийн 26-р зүйл нь энэхүү урамшууллын бүтцийн гол хэсэг болж байна. Хуулийн тус хэсэгт *“шүүх тухайн мэдээллийг хэвлэн нийтлэх нь шударга, зохистой байсан эсэхийг шийдвэрлэхдээ тухайн хэрэгт хамааралтай гэж үзсэн бусад хүчин зүйлсийг харгалзан үзэх бөгөөд... тухайн мэдээллийг хэвлэн нийтлэх үед Хэвлэлийн зөвлөлийн гишүүнчлэлтэй байсан эсэх, Хэвлэлийн зөвлөлийн ёс зүйн дүрмийг дагаж мөрдсөн эсэх, мөн Хэвлэлийн омбудсмэн болон Хэвлэлийн зөвлөлийн шийдвэрийг биелүүлсэн эсэхийг авч үзнэ”*⁷⁶ гэж заасан байдаг. Энэхүү хуулийн зүйл, заалтаас үзвэл тус хууль нь сэтгүүлч болон Хэвлэл мэдээллийн байгууллагын дараах гурван үйл ажиллагааг урамшуулж байна:

1. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гишүүнчлэл
2. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн ёс зүй дүрмийг дагаж мөрдөх
3. Хэвлэлийн зөвлөл болон Хэвлэлийн омбудсмэний шийдвэрийн биелэлт

Хэвлэлийн зөвлөлийн гишүүнчлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхээс харгалзан үзэх хүчин зүйл болдог байна. Тодруулбал, тухайн сэтгүүлч эсвэл хэвлэлийн байгууллага нь гишүүнчлэлтэй бол шүүх Хэвлэлийн зөвлөлөөс гаргасан ёс зүйн стандартыг хэрхэн баримталсан эсэхийг шалгаж үзнэ. Энэ нь тухайн мэдээллийн агуулгаас гадна сэтгүүлч эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа нь Хэвлэлийн зөвлөлөөс тогтоосон ёс зүйн хүрээнд байсан эсэхийг тодорхойлох боломжийг олгожээ. Тиймээс гишүүнчлэл нь хариуцлагатай сэтгүүл зүйн зарчмыг баримталж, өөрсдийн хамгаалалтыг бэхжүүлэхийг хүссэн сэтгүүлчид эсвэл хэвлэлийн байгууллагуудад илүү тааламжтай сонголт болдог байна. Харин гишүүнчлэлтэй ч гэсэн ёс зүйн стандартыг дагаж мөрдөөгүй бол шүүх үүнийг гишүүнчлэлтэй холбоотой хариуцлагыг биелүүлээгүй гэж үзэж болох ба энэ нь тэдний хамгаалалтыг сулруулна.

Үүнээс гадна, Ирландын Хэвлэлийн зөвлөлийн загварын нэг чухал хэсэг нь Хэвлэлийн зөвлөлийн ёс зүйн дүрэмд онцгой анхаарал хандуулж байгаа явдал юм. Гишүүд нь үнэн зөв, шударга байдал, хариуцлага, нууцлалыг эрхэмлэх зэрэг ёс зүйн зарчмуудыг баримтлах үүрэг хүлээдэг. Тиймээс Хэвлэлийн зөвлөлийн гишүүн байх нь тухайн хэвлэлийн байгууллага өөрийгөө ёс зүйн дүрэм журмыг баримталдаг гэсэн агуулгыг нийтэд дамжуулах нэг хэлбэр болдог байна. Хэрэв Хэвлэлийн зөвлөлийн гишүүн ёс зүйн стандартыг баримталж байвал тэдний түгээсэн мэдээлэл нь үнэн зөв байх шинж өндөртэй гэж хөндлөнгөөс таамаглах бөгөөд энэ нь нэг төрлийн хамгаалалт болох боломжтой байна.

⁷⁶ Defamation Act 2009 (Number 31 of 2009), <https://www.irishstatutebook.ie/eli/2009/act/31/enacted/en/print>.

Хэвлэлийн зөвлөлийн ёс зүйн стандартыг дагаж мөрдсөн сэтгүүлч эсвэл хэвлэл мэдээллийн байгууллага нь хууль зүйн хувьд шүүхээс үнэлж болохуйц хүчин зүйлийн эерэг хандлагыг авах тул гүтгэлгийн хэргийн үед шийтгэлийг бууруулах хамгаалалт болох юм. Ийм байдлаар, уг хууль нь зөвхөн гишүүнчлэлийг бус, харин Хэвлэлийн зөвлөлийн ёс зүйн стандартыг идэвхтэй дагаж мөрдөхийг дэмждэг байна.

Мөн түүнчлэн Хэвлэлийн зөвлөл болон Хэвлэлийн омбудсмэний шийдвэрийг дагаж мөрдөхийг гүтгэлгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд харгалзан үзэх боломжтой байдлаар зохицуулжээ. Хэрэв Хэвлэлийн зөвлөл эсвэл омбудсмэн тодорхой шийдвэр гаргасан тохиолдолд (Жишээ нь, залруулга хийх, уучлалт гуйхыг шаардах гэх мэт) гишүүд биелүүлэх шаардлагатай. Эдгээр шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд шүүх хариуцлагагүй үйлдэл гэж үзэж болох ба энэ нь гүтгэлгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сэтгүүлч эсвэл хэвлэл мэдээллийн байгууллагын эсрэг нөлөөлж болно.

Хэвлэлийн Зөвлөл гомдлыг олон нийтэд тодорхой харагдахуйц байдлаар нийтлэхийг шаарддаг нь хууль дүрэм журмыг сахих байдлыг баталгаажуулдаг бөгөөд энэ нь Ирландын загварыг бусад загвараас, тухайлбал Германы загвараас ялгаруулдаг.⁷⁷ Германы загвартай харьцуулахад Ирландын загвар нь гишүүдэд шүүхийн өмнө хамгаалалт болгон ашиглах боломж олгодог тул гишүүнчлэлтэй байхыг урамшуулдаг байна. Хэрэв гишүүнчлэлийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Зөвлөлөөс гарч болох бөгөөд энэ нь гүтгэлэгтэй холбоотой хэрэг үүссэн тохиолдолд хамгаалалтгүй болгох эрсдэлтэй.

Ирландын хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар нь сайн дурын гишүүнчлэл болон эрх зүйн урамшууллын механизмыг хослуулан, редакцын хараат бус байдлыг хадгалж, ёс зүйн стандартыг дэмждэг. Тиймээс ёс зүйн хариуцлагыг эрх зүйн хөшүүрэгтэй холбон урамшуулж буй нь хэвлэл мэдээллийн орчинд эрх чөлөө болон хариуцлагатай сэтгүүл зүйг нэгтгэсэн жишээ болж байна.

3.3.3. Хуулиар тогтоосон зөвлөлийн загвар⁷⁸

1) Дани

Дани улс нь хуулиар тогтоосон зөвлөлийн загвар-ыг ашигладаг цөөн орны нэг бөгөөд энэ нь эрх зүйн зохицуулалт болон өөрийн удирдлагын элементүүдийг хослуулсан онцлогтой. Данийн Хэвлэлийн Зөвлөл нь Мэдээллийн Хариуцлагын тухай хууль-д үндэслэн бие даасан шүүхийн үүргийг гүйцэтгэж, хэвлэл мэдээллийн ёс зүйн стандартуудыг баримтлахыг шаарддаг ч мэдээллийн агуулгыг шууд хянах төрийн оролцоог хязгаарласан. Энэхүү загвар нь бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ёс зүйн өндөр шаардлага тавьдаг. Ёс зүйн удирдамжийг салбарын төлөөллүүдтэй хамтран боловсруулж хэрэгжүүлдэг бөгөөд цаг үетэй тохирохуйц уян хатан зохицуулалттай байдаг.

Данийн хувьд Хэвлэлийн Зөвлөлд бүртгүүлэхийг бүх хэвлэл мэдээллийн байгууллагаас шаарддаг бөгөөд энэ нь бусад оронд тулгардаг гишүүнчлэлээс татгалзах зүйл үүсэхээс сэргийлдэг.⁷⁹ Мөн түүнчлэн Мэдээллийн Хариуцлагын тухай хууль нь хэвлэл

⁷⁷ Irish Press Council, *Annual Report*, 2019.

⁷⁸ Lara Fielden, *Regulating the Press: A Comparative Study of International Press Councils*, Reuters Institute for the Study of Journalism Report (Oxford: Reuters Institute, April 2012).

⁷⁹ Nielsen, Rasmus Kleis, *Press Responsibility and Regulatory Models* (Oxford: Reuters Institute for the Study of Journalism, 2021).

мэдээллийн байгууллагуудыг тодорхой хариуцлага хүлээхийг шаарддаг байна. Энэ нь нийтлэлийн агуулгыг хариуцах редактор томилох үүрэг хүлээлгэдэг бөгөөд редактор нь мэдээллийн хариуцлагыг бүрэн хүлээх ёстой. Энэ загвар нь Швед болон Финланд-ын загвартай төстэй бөгөөд хэвлэл мэдээллийн байгууллагуудын дотоод зохицуулалтыг сайжруулж, олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд тустай юм.

Данийн өөр нэг онцлог нь залруулга өгөх эрх юм. Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага нь тухайн хүнд нэр хүнд, санхүү болон бусад хохирол учруулж болзошгүй буруу мэдээлэл нийтэлсэн бол тухайн хүн эсвэл байгууллага өөрийн байр суурийг илэрхийлэх буюу залруулга өгөх эрхтэй байдаг. Энэ нь хөнгөн хэлбэрээр хэрэгжиж, мэдээллийг залруулах боломжийг хохирогчид шуурхай олгодог.

Мэдээллийн Хариуцлагын тухай хууль нь сэтгүүлчдийн эх сурвалжийг хамгаалах, хувийн мэдээлэл цуглуулах зэрэг давуу эрхийг хэвлэл мэдээллийн байгууллагуудад олгодог бөгөөд энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны хүрээнд олон нийтэд шаардлагатай мэдээллийг хүргэхэд дэмжлэг үзүүлдэг байна. Хэвлэл мэдээллийн байгууллагуудын хувьд шүүхийн мэдээлэлд нэвтрэх эрх нэмэгдсэн бөгөөд энэ нь шүүхийн нууц мэдээллийг судлах, харьцуулах боломжийг олгодог.

Мэдээллийн Хариуцлагын тухай хууль нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад эрх зүйн хариуцлага бий болгож байгаа хэдий ч Хэвлэлийн Зөвлөлийн үндсэн үүрэг нь өдөр тутмын сэтгүүл зүйн ёс зүйн стандартуудыг хэвшүүлэхэд оршино.⁸⁰ Хэрэв хэвлэл мэдээллийн байгууллага Хэвлэлийн Зөвлөлийн шийдвэрийг дагаж мөрдөхгүй бол торгууль эсвэл дөрвөн сар хүртэл хугацаанд хорих ял шийтгэх хуулийн зохицуулалт мөн байдгаараа онцлог байна.⁸¹

3.3.4. Дүгнэлт

Хэвлэл мэдээллийн өөрийн удирдлагын загварууд болох сайн дурын зөвлөл, хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөл, болон хуулиар тогтоосон зөвлөлийн загварууд нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ёс зүйн хариуцлагатай хослуулах олон улсын янз бүрийн арга замыг илэрхийлдэг. Эдгээр загварууд нь үр нөлөө, нийцэх чадвар, олон нийтийн итгэлд ихээхэн нөлөө үзүүлдэг онцлог шинжтэй бөгөөд эдгээрийг нарийвчлан судлах нь төрийн болон хэвлэл мэдээллийн салбарын ашиг сонирхлын уялдаа холбоог ойлгоход тусална.

Сайн дурын зөвлөлийн загвар нь төрийн оролцоог багасгах зарчим дээр тулгуурладаг. Энэ загвар нь хэвлэл мэдээллийн байгууллагууд өөрсдийн ёс зүйн стандартыг баримталж, өөрөө зохицуулалт хийх замаар эрх чөлөөгөө хамгаалдаг. Энэхүү загварын онцлог нь уян хатан байдал бөгөөд салбарын байгууллагуудыг өөрийн хүсэлтээр ёс зүйн стандартыг баримтлахыг шаарддаг. Гэвч энэхүү уян хатан байдал нь давуу талтай ч, байгууллагууд сайн дурын гишүүнчлэлээс татгалзахад ёс зүйн стандартуудын хэрэгжилтийн тогтвортой байдал алдагдах сул талтай. Энэ загвар нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хамгаалж чаддаг ч, байгууллагуудын ёс зүйг баримтлах тогтвортой байдлыг сулруулдаг.

Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын гишүүнчлэл болон ёс зүйн стандартыг дагаж мөрдөхийг дэмжих хуулийн

⁸⁰ Danish Press Council, *Annual Report* (2020).

⁸¹ *Media Liability Act of Denmark*, Government of Denmark, 1991.

урамшууллыг санал болгодог. Уг загвар нь хэвлэл мэдээллийн байгууллагууд ёс зүйн стандартыг дагаж мөрдөж байгаагаа нотолсноор хуулийн дагуу шүүхийн өмнө тодорхой давуу тал олж авах боломтой. Энэхүү загварын давуу тал нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг ёс зүйн стандарт дагаж мөрдөх бодлогын шинжтэй үндэслэлийг бий болгодог. Гэвч энэ загварын үр дүн нь урамшууллын үнэ цэн дээр тулгуурлана. Урамшуулал хангалттай ашигтай биш бол, уг загварын зохицуулалтын нөлөө багасах эрсдэлтэй.

Хуулиар тогтоосон зөвлөлийн загвар нь эрх зүйн шаардлагыг өөрийн удирдлагын элементүүдтэй хослуулсан нэгдмэл зохицуулалтын хэлбэр юм. Энэхүү загвар нь хуульчлагдсан тогтолцоог бий болгож, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг тодорхой ёс зүйн стандартыг дагаж мөрдөхийг албадаж, гомдлыг шийдвэрлэх, торгууль ноогдуулах зэрэг хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлдэг. Түүнчлэн уг загвар нь салбарын оролцоог дэмжиж, хэвлэл мэдээллийн байгууллагууд стандарт тогтоох үйл явцад өөрийн үүргээ гүйцэтгэхийг дэмждэг. Тус загвар нь хууль зүйн зөвшөөрлийн шаардлага тавьдаг тул байгууллагуудын бие даасан байдалд хязгаарлалт үзүүлэх боломжтой.

Эцэст нь, хэвлэл мэдээллийн зөвлөлийн эдгээр загвар бүр өөр өөрийн давуу болон сул талуудтай. Сайн дурын зөвлөл нь эрх чөлөөтэй, уян хатан ч хариуцлагын тогтвортой байдлыг хангахад бэрхшээлтэй тулгардаг. Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөл нь хуулиар зохицуулсан урамшуулалтай холбоотойгоор ёс зүйн стандартыг сайжруулж чаддаг ч, урамшууллын үнэ цэн дээр тулгуурладаг. Хуулиар тогтоосон зөвлөлийн загвар нь хууль зүйн шаардлага тавьдаг тул хариуцлагын тэнцвэрийг хадгалж чаддаг ч, заавал баримтлах стандарт тогтоосноор салбарын эсэргүүцэлтэй тулгарч цаашлаад хэвлэл мэдээллийн эрх чөлөөнд эрсдэл учруулж болно.

Монгол улсад өнөөдөр хэвлэл, мэдээллийн салбарын өөрийн удирдлагын тогтолцоог зохицуулах хууль байхгүй. Тиймээс сайн дурын зөвлөлийн загварт хамааруулан ойлгох боломжтой. Хэвлэл, мэдээллийн салбарын зөвлөл гэх статусд хамааруулан ойлгож болох байгууллагууд байдаг ч ёс зүйн дүрэм нь улсын хэмжээнд нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн зүйл биш юм. Үүний үр дагаварт, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдэд хамаарах хэм хэмжээ нь зөвхөн нийтээр дагаж мөрдөх хууль болж байна. Харин холбогдох хууль нь зөрчигдсөн тохиолдолд тэр нь нэг бол нийтийн эрх ашигт сөрөг нөлөөтэй эсвэл хувь хүний эрх зөрчигдсөн байх боломжтой. Үүнтэй холбоотойгоор хуульчилсан хатуу зохицуулалтыг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллага эсвэл сэтгүүлчдэд хуулийн хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны хэрэг болно. Энэ нь нэг талаар хэвлэл мэдээллийн салбарын нэр хүндэд сөрөг үр дагавар үүсгэж, хэвлэл мэдээллийн салбар болон төр хоорондын үл ойлголцлыг үүсгэх юм.

Нийтээр дагаж мөрдөх хуульчилсан хэм хэмжээг зөрчих нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх хамгаалалт бол хэвлэл, мэдээллийн салбар дахь ёс зүйн дүрэм, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа байна. Үүнийг хэрэгжүүлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтолцоо бол зөвлөлийн загвар юм. Энэ нь гурван хувилбар байж болох тухай судалгаанд дурдсан бөгөөд загвар тус бүр өөр өөрийн давуу болон сул талуудтай. Монгол Улсын хувьд өнөөдөр тэрхүү сул талд хамаарах бэрхшээлтэй тулгараад байна. Тулгамдсан асуудалд шийдэл болох хувилбар нь Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар байж болох юм. Учир нь Монгол Улсын хувьд судалгааны холбогдох хэсэгт хамаарах бэрхшээл буюу хэвлэл мэдээллийн салбарын ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт үр дүн муутай байна.

Үүнээс шалтгаалж хэвлэл мэдээллийн салбартай холбогдох хууль зүйн зөрчлүүд илрэх болж, зарим талаар төр болон хэвлэл мэдээллийн салбар хоорондын үл ойлголцол бий болж, аль аль талынх нь нэр хүнд суларч нийгэмд буруу ойлголтыг төрүүлж буй юм.

Тиймээс сайн дурын зөвлөлийн загвараас шууд байдлаар татгалзаж хуулиар тогтоосон зөвлөлийн загвар-руу шилжих нь Монголын өнөөгийн бий болгосон хэвлэл, мэдээллийн салбарын уламжлал, нийгмийн онцлогтой зохицохгүй байж болно. Харин Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загварыг сонгож хэрэгжүүлбэл нэг талаас төр болон хэвлэл, мэдээллийн салбарын зөвшилцлийг хангаж, нийтлэг байдлаар дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг бий болгоно. Тэрхүү ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт хангагдаж, холбогдох зөрчлийг зөвлөл өөрөө хянан шийдвэрлэдэг болбол нийтээр дагаж мөрдөх шаардлагатай зарим хуулийн зөрчил бий болохоос урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ. Гэхдээ анхаарах асуудал нь зөвлөлийн гишүүнчлэлийн урамшууллын үнэ цэнээс хамааран энэ загварын үйлчлэл тодорхойлогдоно. Тиймээс зөвлөлийн гишүүнчлэлээс хүртэж болох урамшууллын үнэ цэнийг гишүүн биш байх үнэ цэнээс илүү түвшинд хадгалах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тухайн зөвлөлийн гишүүн байснаараа хэвлэн нийтлэх эрх чөлөө нь эрсдэлд орохгүй байх учиртай. Хэрэв зөвлөлийн гишүүн байх нь хэвлэл нийтлэх эрх чөлөөнд сөрөг үр дагавартай бол өнөөгийн тулгамдаж буй асуудал шийдэгдэхгүй. Зөвлөлийн гишүүн байх үнэ цэн нь зарим хуулийн зүйл заалтыг өөрт нь хамааруулж хэрэглэж болох нөхцөлөөс хамгаалж, хэвлэн нийтлэх эрх чөлөөг одоогийнхоос илүү түвшинд хүргэх үнэ цэнийг бүтээж байвал Хууль зүйн урамшуулалтай сайн дурын зөвлөлийн загвар хэрэгжиж, тулгамдсан асуудлын шийдэл болж болох юм.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх:

- Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг*, (2008)
- Глоб Интернэшнл Төв, “Сэтгүүлчдийн аюулгүй байдал” гарын авлага, (2015), <https://gic.mn/images/upld/safetyofjournalists.pdf>
- Глоб Интернэшнл Төв, “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын судалгааны дүн” (2023), <https://www.gic.mn/post/r/1730>
- Глоб Интернэшнл Төв, Хэвлэлийн эрх чөлөөний тайлан 2022-2023, (2024), https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2022_2023_mn.pdf
- Д.Оросоо нар, “Худал мэдээлэл тараах гэмт хэргийг хянан шийдвэрлэж буй практик: Илт худал мэдээлэл гэх ойлголтын эрүүгийн эрх зүйн асуудал”, ННФ, 2021, <https://cdn.greensoft.mn/uploads/users/3092/files/Misinformation%20CrimeWeb%20version.pdf>
- О.Мөнхсайхан, “Туйлын эрхээс бусад үндсэн эрхийн хязгаарлалтад тавих гол нөхцөл”, дотор *Хүний эрх I боть* (Өгүүлэл, илтгэл, санал), эмх. О.Мөнхсайхан (2023), 21-40

Япон хэл дээрх:

- 松井茂記「日本国憲法」第2版（有斐閣、2002）
- 安保克也「ニュー・メディア社会における表現の自由」（2008）, https://www.jstage.jst.go.jp/article/gscs/5/1/5_12/pdf
- 塩崎 隆敏「取材対象者との関係性における倫理規範」放送研究と調査 71 (9), 2021, https://www.jstage.jst.go.jp/article/bunken/71/9/71_42/article-char/ja/
- 安井 英俊「取材源の秘匿と証言拒絶権」福岡大学法学論叢 59 (4), 2015-03, <https://fukuoka-u.repo.nii.ac.jp/records/1471>
- 鴨良弼「報道の自由と刑事訴訟法」一橋論叢 第六十二巻第四号 <https://hermes-ir.lib.hit-u.ac.jp/hermes/ir/re/2463/ronso0620400350.pdf>
大塚 一美「ジャーナリストの証言拒絶権法制化に関する一考察：米国を素材として」マス・コミュニケーション研究 77 (0), 2010, https://www.jstage.jst.go.jp/article/mscom/77/0/77_KJ00006544573/article-char/ja/

Англи хэл дээрх:

- 111th CONGRESS 1st SESSION S. 448 “Free Flow of Information Act of 2009” <https://www.govinfo.gov/content/pkg/BILLS-111s448is/pdf/BILLS-111s448is.pdf>
- Brogi, Elda, et al., *Monitoring Media Pluralism in Europe* (Florence: European University Institute, 2021)
- Caroline Jack, “Lexicon of Lies: Terms for Problematic Information”, *Data&Society Research Institute*, https://datasociety.net/pubs/oh/DataAndSociety_LexiconofLies.pdf
- Claire Wardle, Hossein Derakhshan, “INFORMATION DISORDER: Toward an interdisciplinary framework for research and policy making” (2017), *Council of Europe report DGI(2017)09*, <https://rm.coe.int/information-disorder-toward-an-interdisciplinary-framework-for-research/168076277c>

- Council of Europe, *Committee of Ministers Recommendations on Media Freedom*, Strasbourg, 2017
- Council of Europe, *Media Freedom and Ethical Standards*, Strasbourg, 2019
- Council of Europe, *Recommendation CM/Rec(2011)7 on a New Notion of Media*, Strasbourg, 2011
- Danish Press Council, *Annual Report* (2020)
- Disney, Julian, *Australian Press Council Annual Report* (Sydney: Australian Press Council, 2010)
- Dominic Frost. "Who is a journalist? the legal definitions" Press Freedom Policy Papers Background Briefing 1/2021:3-4. <https://law.uq.edu.au/files/79263/who-is-a-journalist.pdf>
- European Commission, *Ireland: Media Regulation and Defamation Laws* (Brussels: European Union, 2010)
- European Union Agency for Fundamental Rights, *Freedom of Expression and Information: Press Regulation Overview*, 2020
- European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation and Self-Governance in EU Member States*, 2019
- European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation and Media Freedom in the EU*, 201
- European Union Agency for Fundamental Rights, *Press Regulation in EU Member States*, 2019
- Hanretty, Chris, *Public Broadcasting and Political Influence* (London: Routledge, 2010).
- Horgan, John, *Defamation Law and Media in Ireland* (Dublin: Irish Media Federation, 2012)
- Horgan, John, *Journalism and the Public Interest: Defining News in the 21st Century* (Cork: Mercier Press, 2001)
- Hurst, John, *Ethics and the Australian News Media* (Melbourne: Macmillan, 2004).
- Irish Press Council, *Annual Report*, 2019
- Kennedy, Declan, *Self-Regulation in Irish Media: Press Councils and Ethical Standards* (Cambridge University Press, 2012)
- Lara Fielden, *Regulating the Press: A Comparative Study of International Press Councils*, Reuters Institute for the Study of Journalism Report (Oxford: Reuters Institute, April 2012)
- Lejla Turcilo, Mladen Obrenovic, "Misinformation, Disinformation, Malinformation: Causes, Trends, and Their Influence on Democracy", *E-paper series "A Companion to Democracy" #3*, https://hk.boell.org/sites/default/files/importedFiles/2020/11/04/200825_E-Paper3_ENG.pdf
- MediaDem Project, *Democracy in the Age of Social Media* (Brussels: European Union, 2013)
- Moe, Hallvard, and Josef Trappel, *European Media Governance: National and Regional Dimensions* (Bristol: Intellect Books, 2011).
- Moring, Tom, *Media Law in Finland* (Copenhagen: Nordic Council of Ministers, 2017)

- Nielsen, Rasmus Kleis, *Press Responsibility and Regulatory Models* (Oxford: Reuters Institute for the Study of Journalism, 2021)
- Nord, Lars, *Trust in Media and Democratic Engagement* (New York: Routledge, 2018)
- Nordenstreng, Kaarle, and Tapio Varis, *Media and Power in Finland* (Helsinki: Finnish Media Federation, 2018)
- Nordenstreng, Kaarle, *Media and Democracy in Finland* (Helsinki: University of Helsinki Press, 2014)
- O'Donnell, Mark, *Press Council and Accountability in Ireland* (Dublin: Irish Legal Publications, 2015)
- O'Malley, Tom, *Media Law in Ireland* (Dublin: Clarus Press, 2011)
- OSCE, *Guidelines on Media Freedom*, 2018
- OSCE, *Guidelines on Media Freedom and Independence*, 2019
- OSCE, *Best Practices in Media Self-Governance*, 2018.
- OSCE, *Press Freedom and Self-Regulation Mechanisms*, 2019.
- Phoebe Petrovic, "Misinformation, Disinformation: A guide to sorting fiction from reality", updated July 20, 2023, <https://wisconsinwatch.org/2023/07/misinformation-disinformation-a-guide-to-sorting-fiction-from-reality/>
- Press Council Reforms and Public Complaints: The Swedish Case," *European Journal of Media Ethics*, 2020.
- Report of the Special Rapporteur on the promotion and protection of the right to freedom of opinion and expression (2013), <https://documents.un.org/doc/undoc/gen/n13/464/76/pdf/n1346476.pdf>
- Ruggie, John Gerard, "Human Rights and Media Freedom Post-War," *Journal of Human Rights*, 2018
- Ruggie, John Gerard, "International Norms in Human Rights and Press Freedom," *Journal of Human Rights*, 2017
- Schulz, Wolfgang, and Thorsten Held, *Regulated Self-Regulation as a Form of Modern Government* (London: John Libbey, 2004).
- Singapore Fake News Laws: Guide to POFMA (Protection from Online Falsehoods and Manipulation Act), <https://singaporelegaladvice.com/law-articles/singapore-fake-news-protection-online-falsehoods-manipulation/>
- Thorgeirsdottir, Herdís, *Journalistic Freedom and Accountability* (Brill, 2004).
- Trappel, Josef, et al., *European Media Governance: National and Regional Dimensions* (Bristol: Intellect Books, 2011).
- UN Human Rights Committee, "General comment no. 34, Article 19, Freedoms of opinion and expression", (2011), <https://digitallibrary.un.org/record/715606?v=pdf>
- UNESCO, "Promoting Press Freedom in Democratic Societies," *UNESCO Policy Brief*, 2021.
- UNESCO, "Media and Information Literacy: Policy and Strategy Guidelines" (2013), accessed October 27, 2024, <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000225606/PDF/225606eng.pdf.multi>
- UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2020
- UNESCO, *World Trends in Freedom of Expression and Media Development*, 2021.

- United Nations Educational, Scientific and Cultural Organization (UNESCO), *Media Regulation and Ethics*, 2020.
- United Nations Human Rights Council, "Protection of Journalists and Freedom of the Press," *UNHRC Resolution*, 2021.

Хууль тогтоомж, шүүхийн шийдвэр:

- Case of Lingens V. Austria (1986),
[https://hudoc.echr.coe.int/fre#{%22itemid%22:\[%22001-57523%22\]}](https://hudoc.echr.coe.int/fre#{%22itemid%22:[%22001-57523%22]})
- Defamation Act 2009 of Ireland,
<https://www.irishstatutebook.ie/eli/2009/act/31/enacted/en/print>.
- Grundgesetz für die Bundesrepublik Deutschland [Basic Law for the Federal Republic of Germany] (1949)
- International Covenant on Civil and Political Rights (1966)
- *Media Liability Act of Denmark*, Government of Denmark, 1991
- New York Times Co. v. Sullivan, 376 U.S. 254 (1964,
<https://supreme.justia.com/cases/federal/us/376/254/>
- Protection from Online Falsehoods and Manipulation Act 2019,
<https://sso.agc.gov.sg/Act/POFMA2019?ViewType=SI>
- Universal Declaration of Human Rights (1948)
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль (1994)
- Зөрчлийн тухай хууль (2017)
- Иргэний хууль (2002)
- Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)
- Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Тогтоол №2023/ШЦТ/1218 (2023.10.13)
- Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Тогтоол №2023/ШЦТ/351 (2023.05.22)
- Эрүүгийн хууль (2015)